

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2024 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2025 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 17-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН



ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2025 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр, Баасан гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-8
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	9-81
<hr/>	
1.Хуулийн төслийг эцэслэн батлах	9-10
2.Малын индексжүүлсэн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Малчны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.01.09-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	10-50
3.“Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд хийх төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглавар батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл	50-51
4.“Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл	51-56
5.Өргөн мэдүүлсэн хуулийн төслийг танилцуулах	56
6.“Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Экспорт-Импорт банк хоорондын Зээлийн хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.01.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, яаралтай хэлэлцэх эсэх, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1-д заасны дагуу/	56-58
7.“Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Экспорт-Импорт банк хоорондын Зээлийн хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.01.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах/	58-81

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы
2025 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр /Баасан гараг/-ийн нэгдсэн
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 126 гишүүнээс 66 гишүүн хүрэлцэн ирж, 52.4 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 05 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: Б.Батцэцэг, Б.Бейсен, Д.Бум-Очир, Ш.Бямбасүрэн, С.Бямбацогт, Л.Гантөмөр, Б.Дэлгэрсайхан, С.Зулпхар, Т.Мөнхсайхан, П.Наранбаяр, Ч.Номин, С.Одонтуяа, Б.Пүрэвдорж, Х.Тэмүүжин, Ж.Энхбаяр, Л.Энхнасан, Р.Эрдэнэбүрэн;

Чөлөөтэй: П.Батчимэг, Ж.Баярмаа, Ж.Ганбаатар, Д.Жаргалсайхан, Ц.Мөнхбат, П.Мөнхтулга, Б.Найдалаа, М.Нарантуяа-Нара, Л.Оюун-Эрдэнэ, Б.Тулга;

Эмнэлгийн чөлөөтэй: Н.Алтанхуяг, Д.Батлут, С.Лүндэг, Ц.Мөнхтуяа, Н.Наранбаатар, Б.Түвшин, Б.Энхбаяр;

Тасалсан: Х.Баттулга;

Хоцорсон: Т.Аубакир -02 минут, Ц.Баатархүү -13 минут, Э.Батшугар -15 минут, Ж.Бат-Эрдэнэ -02 минут, Х.Булгантуяа -05 минут, Д.Ганбат -1 цаг 06 минут, М.Ганхүлэг -11 минут, Ц.Даваасүрэн -09 минут, Т.Доржханд -1 цаг 27 минут, Х.Жангабыл -12 минут, Б.Жаргалан -21 минут, З.Мэндсайхан -01 минут, Б.Пунсалмаа -38 минут, Д.Пүрэвдаваа -13 минут, О.Саранчулуун -01 минут, Г.Тэмүүлэн -12 минут, А.Ундраа -2 цаг 30 минут, Г.Уянгахишиг -06 минут, Д.Цогтбаатар -03 минут, Б.Чойжилсүрэн -33 минут, Д.Энхтуяа -03 минут.

Нэг.Хуулийн төслийг эцэслэн батлах

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн дарга Б.Нарангэрэл, Байнгын хороодын ажлын албаны Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн, мөн албаны Төсвийн байнгын хорооны ажлын албаны референт Б.Мөнгөн-Аргамж нар байлцав.

Д.Амарбаясгалан: Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 66

Татгалзсан: 8

Бүгд: 74

89.2 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал, Д.Батбаяр нарын “дэмжсэн” санал “эсрэг” гарсан тул санал хураалтыг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, дэмжсэнээр тооцон нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

Уг асуудлыг 10 цаг 11 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Малын индексжүүлсэн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Малчны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.01.09-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, Сангийн яамны Санхүүгийн зах зээл, даатгалын хэлтсийн дарга Б.Амарбаясгалан, мөн хэлтсийн мэргэжилтэн Б.Гарамханд, Санхүүгийн зохицуулах хорооны Даатгалын газрын ахлах референт Н.Батцэцэг, мөн газрын референт Э.Сайнзаяа, “Үндэсний давхар даатгал” ХК-ийн гүйцэтгэх захирал Б.Жавхлант, мөн компанийн Эрсдэлийн удирдлагын ахлах ажилтан П.Шинэзул, ерөнхий андеррайтер Д.Мөнхбилэг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн дарга Б.Нарангэрэл, мөн хэлтсийн зөвлөх Г.Алтанцэцэг, Байнгын хороодын ажлын албаны Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Ариунжаргал нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Сангийн сайд Б.Жавхлан, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ нар танилцуулав.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн У.Отгонбаяр, Х.Баасанжаргал, Б.Бат-Эрдэнэ, П.Ганзориг, Р.Сэддорж, Ж.Батжаргал, Д.Батбаяр, Г.Хосбаяр, Ц.Идэрбат, Ц.Сандаг-Очир, Л.Мөнхбаясгалан, Л.Соронзонболд, З.Мэндсайхан, Ч.Ундрэм, Х.Булгантуяа нарын тавьсан асуултад Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Сангийн сайд Б.Жавхлан, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, “Үндэсний давхар даатгал” ХК-ийн гүйцэтгэх захирал Б.Жавхлант нар хариулж, тайлбар хийв.

Д.Амарбаясгалан: 1.Байнгын хорооны саналаар Малын индексжүүлсэн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 46

Татгалзсан: 43

Бүгд: 89

57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Байнгын хорооны саналаар Малчны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 48
Татгалзсан: 41
Бүгд: 89
53.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан үг хэлэв.

Малын индексжүүлсэн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Малчны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 12 цаг 34 минутад хэлэлцэж дуусав.

Гурав. “Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд хийх төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглавар батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн дарга Б.Нарангэрэл, мөн хэлтсийн зөвлөх Ж.Түвшинжаргал, Байнгын хороодын ажлын албаны Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн, мөн албаны Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны референт Э.Баттогтох нар байлцав.

Төслийн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Д.Амарбаясгалан: “Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд хийх төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглавар батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 49
Татгалзсан: 40
Бүгд: 89
55.1 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 12 цаг 39 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв. “Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн дарга Б.Нарангэрэл,

мөн хэлтсийн зөвлөх Г.Анар-Эрдэнэ, Байнгын хороодын ажлын албаны Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн, мөн албаны Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны референт Э.Баттогтох нар байлцав.

Төслийн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн, Ж.Батжаргал нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан, Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Ж.Бат-Эрдэнэ нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан үг хэлэв.

Д.Амарбаясгалан: “Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 49
Татгалзсан: 39
Бүгд: 88
55.7 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 12 цаг 52 минутад хэлэлцэж дуусав.

Үдээс өмнөх хуралдаан 2 цаг 47 минут үргэлжилж, 12 цаг 52 минутад завсарлав.

Үдээс хойших хуралдаан 15 цаг 05 минутад эхлэв.

Тав.Өргөн мэдүүлсэн хуулийн төслийг танилцуулах

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур байлцав.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан Монгол Улсын Засгийн газраас 2025.01.17-ны өдөр өргөн мэдүүлсэн “Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Экспорт-Импорт банк хоорондын Зээлийн хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд хуваарилсныг танилцуулав.

Уг асуудлыг 15 цаг 07 минутад хэлэлцэж дуусав.

Зургаа. “Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Экспорт-Импорт банк хоорондын Зээлийн хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.01.17-ны өдөр

*өргөн мэдүүлсэн, **яаралтай хэлэлцэх эсэх**, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1-д заасны дагуу/*

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн дарга Б.Нарангэрэл нар байлцав.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан Монгол Улсын Засгийн газраас үндэсний эдийн засгийн аюулгүй байдлыг хангахтай холбогдуулан “Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Экспорт-Импорт банк хоорондын Зээлийн хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг яаралтай хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд өргөн мэдүүлснийг танилцуулав.

Д.Амарбаясгалан: “Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Экспорт-Импорт банк хоорондын Зээлийн хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг яаралтай хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 49
Татгалзсан: 40
Бүгд: 89
55.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Б.Жавхлан, Ж.Батжаргал нарын “дэмжсэн” санал “эсрэг” гарсан тул санал хураалтыг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, дэмжсэнээр тооцов.

“Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Экспорт-Импорт банк хоорондын Зээлийн хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг гишүүдийн олонхын саналаар яаралтай хэлэлцэхээр шийдвэрлэсэн тул Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 15 цаг 22 минутад хэлэлцэж дуусав.

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо хуралдах тул хуралдаан 15 цаг 22 минутад завсарлав.

Хуралдаан 17 цаг 37 минутаас үргэлжлэв.

Долоо. “Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Экспорт-Импорт банк хоорондын Зээлийн хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.01.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга Л.Сонор, мөн

яамны Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Газрын тосны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Ч.Хишигдалай, “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК-ийн гүйцэтгэх захирал Д.Алтанцэцэг, мөн компанийн Гэрээ, эрх зүйн газрын дарга У.Чинзориг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн дарга Б.Нарангэрэл, мөн хэлтсийн зөвлөх С.Дунжидмаа, Байнгын хороодын ажлын албаны Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн, референт Б.Гандиймаа нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Сангийн сайд Б.Жавхлан, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн нар танилцуулав.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Ганбаатар, Н.Номтойбаяр, С.Ганбаатар, Б.Уянга нарын тавьсан асуултад Сангийн сайд Б.Жавхлан, Сангийн яамны Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Газрын тосны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Ч.Хишигдалай, “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК-ийн Гэрээ, эрх зүйн газрын дарга У.Чинзориг нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин долдугаар зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1-д заасан шаардлагуудыг хангаж, Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулган завсарлах боломжтой болсныг мэдэгдэж, Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганыг үргэлжлүүлэн хуралдуулах эсэх талаарх Улсын Их Хурлын гишүүдийн саналыг сонсож, Улсын Их Хурлын гишүүдийн гадаад болон дотоод томилолтыг түр зогсоон намрын ээлжит чуулганыг үргэлжлүүлэн хуралдуулахаар шийдвэрлэв./18:18/

Мөн ажлын цаг дууссан тул “Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Экспорт-Импорт банк хоорондын Зээлийн хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төслийн хэлэлцүүлгийг хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуухаар нэр өгсөн Улсын Их Хурлын гишүүдийн асуулт, хариултыг дуусах хүртэл сунгав./18:19/

Улсын Их Хурлын дэд дарга Х.Булгантуяа 18 цаг 20 минутаас хуралдааныг даргалав.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа, Д.Энхтүвшин, Л.Мөнхбаясгалан, Г.Уянгахишиг, Б.Пунсалмаа, Ч.Анар нарын тавьсан асуултад Сангийн сайд Б.Жавхлан, Сангийн яамны Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК-ийн гүйцэтгэх

захирал Д.Алтанцэцэг, мөн компанийн Гэрээ, эрх зүйн газрын дарга У.Чинзориг нар хариулж, тайлбар хийв./19:02/

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 7 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч Ш.Мөнхцоож, С.Энхзаяа, ахлах мэргэжилтэн С.Золжаргал нар хариуцан ажиллав.

Хуралдаан 4 цаг 29 минут үргэлжилж, 126 гишүүнээс 91 гишүүн хүрэлцэн ирж, 72.2 хувийн ирцтэйгээр 19 цаг 02 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Б.БААСАНДОРЖ

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр,
Баасан гараг
Төрийн ордон “Их хуралдай” танхим
10 цаг 05 минут.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүдэд өглөөний мэнд хүргэе. 66 гишүүн ирж, 52,4 хувиар ирц хүрсэн тул 2025 оны 1 дүгээр сарын 17-ны өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Өнөөдрийн хуралдаанаар дараах 6 асуудлыг хэлэлцэнэ. 1 дүгээрт, Хуулийн төсөл эцэслэн батална. Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл байгаа. 2 дугаарт, Малын индексжүүлсэн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна. 3 дугаарт, Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд хийх төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглавар батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ. 4 дүгээрт, Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ. 5 дугаарт, Нийслэл Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна. 6 дугаарт, баталсан хууль, тогтоолын эцсийн найруулгыг сонсоно. Хэлэлцэх асуудалдаа орёе.

Нэг.Хуулийн төслийг эцэслэн батлах

Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулна. Эцэслэн батлуулах хуулийн төслийн хувилбарыг Төсвийн байнгын хороо бэлтгэн гишүүдэд тараасан байна. Ирцэд бүртгэлтэй гишүүдийг танхимд орж ирэхийг хүсье. Хууль эцэслэн батална. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.2-т нэгдсэн хуралдаанд хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулах бөгөөд Улсын Их Хурлын нийт гишүүний олонх дэмжсэн бол хууль эцэслэн баталсанд тооцно гэж заасан. Гишүүдээ дуудъя. Ирц бүртгэлийн санал хураалт 1 явуулаадахъя. Бүртгэлтэй гишүүд танхимд байгаа эсэх дээр. Санал хураалт 54 гишүүн санал хураалтад оролцсон байна. Санал хураалтад оролцож амжаагүй хэд байна вэ? 1, 2, 3, 4, 5, 6, 7. Ирцэд бүртгэлтэй гишүүд орж ирье. 63, 64 гишүүнээр хууль эцэслэн батлагдана. Ирц бүртгэлийн санал хураалт дахиж явуулъя. Санал хураалт.

Санал хураалт Байнгын хорооны саналаар Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт. 64 гишүүн дэмжиж, Жигжидийн Батжаргал гишүүнийг дэмжсэнээр протоколд тэмдэглүүлье. Далайн Батбаяр гишүүнийг дэмжсэнээр протоколд тэмдэглүүлье. 86,5 хувиар санал

дэмжигдлээ. Хуулийн төсөл батлагдлаа. Улсын Их Хурлын гишүүд, ажлын хэсэгт талархал дэвшүүлье.

Хоёр.Малын индексжүүлсэн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Малчны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.01.09-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Дараагийн асуудалд оръё. Малын индексжүүлсэн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна. Хууль санаачлагчийн илтгэлийг Засгийн газрын гишүүн, Сангийн сайд Болдын Жавхлан танилцуулна. Индэрт урьж байна.

Б.Жавхлан: Эрхэм Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас Малын индексжүүлсэн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг дагалдах хуулийн төслийн хамт боловсруулан та бүхэндээ танилцуулж байна. Зуд болон бусад гэнэтийн эрсдэлээс малчдын амьдралын баталгаа болсон мал сүргийг хамгаалах зорилгоор Засгийн газар Дэлхийн банкны санхүүгийн дэмжлэгтэйгээр малын индексжүүлсэн даатгал төслийг 2005 оноос 2014 он хүртэл 10 жилийн турш амжилттай хэрэгжүүлж, улмаар Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийг Монгол Улсын Их Хурлаас 2014 онд баталсан. Ийнхүү Малын индексжүүлсэн даатгалын тухай хууль хэрэгжиж эхэлснээс Монгол Улсад малчдын гамшгийн хэрэгслээс хамгаалах даатгалын тогтолцооны суурь тавигдсан.

Хэдийгээр малын даатгалын эрх зүйн орчныг шинээр бүрдүүлж, индексжүүлсэн даатгалыг Монгол Улсад амжилттай нэвтрүүлсэн боловч жилд дунджаар нийт малчин өрхийн 11-ээс 18 хувь нь хамрагдаж, нийт малын 7-гоос 10 хувийг л даатгуулж байгаа нь хууль тогтоомжид тодорхой өөрчлөлт шинэчлэлтийг хийх шаардлага байгааг харуулж байна. Байгалийн гамшгаас урьдчилан сэргийлэх, малчдын мал сүргийг учирч болзошгүй эрсдэлээс хамгаалах даатгалын тогтолцоог бэхжүүлэх зорилгоор Засгийн газраас Малын индексжүүлсэн даатгалын тухай хуульд дараах өөрчлөлтүүдийг оруулахаар боловсруулаад байна. Үүнд: 1 дүгээрт, даатгалын нөхөн төлбөр олгох босго үзүүлэлтийг хуульчилсан байгааг өөрчлөн уян хатан тогтоох, энэ нь малын индексжүүлсэн даатгалын хамрах хүрээ, хүртээмжийг нэмэгдүүлэх, улмаар малчдын даатгалд хандах итгэл үнэмшлийг сайжруулахад чухал ач холбогдолтой юм.

2 дугаарт даатгалын нөхөн төлбөрийг гэрээний хугацаанд дараа жилийн намар буюу хохирол гарсны дараа олгодог байсныг өөрчилж, нөхөн төлбөрийг хэсэгчлэн урьдчилан олгох шинэлэг зохицуулалтыг тусгаад байна. Ийнхүү нөхөн төлбөрийг урьдчилан олгосноор малчдын амьжиргааны эх үүсвэрт дэмжлэг үзүүлэх, нөгөөтээгүүр үргэлжлэн тохиолдож болзошгүй зудын эрсдэлээс урьдчилан сэргийлэх боломжууд бүрдэх юм. Малын индексжүүлсэн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 35 дугаар зүйлд заасны дагуу Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 2025 оны 1 дүгээр сарын 14-ний өдрийн хуралдаанаар хэлэлцэж, хуулийн төслийг

хэлэлцэхийг дэмжсэн. Иймд Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 36 дугаар зүйлд заасны дагуу хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Төслүүдийн талаарх БОХХАА-н байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Бат-Өлзийн Бат-Эрдэнэ танилцуулна. Индэрт урьж байна.

Б.Бат-Эрдэнэ: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын ЗГ-аас 2025 оны 1 дүгээр сарын 9-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Малын индексжүүлсэн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх асуудлыг БОХХАА-н байнгын хороо 2025 оны 1 сарын 14-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ. Хууль санаачлагч малын индексжүүлсэн даатгалд малчин өрх болон мал бүхий иргэдийн хамрах хүрээ, хүртээмжийг нэмэгдүүлэх, индексжүүлсэн даатгалын үйл ажиллагааг улам сайжруулах, даатгалын нөхөн төлбөр олгох босго үзүүлэлтийг уян хатан тогтоох, даатгуулагч даатгалын үр шимийг цаг алдалгүй хүртэх, зудын эрсдэлийг хохирол багатай даван туулах зорилгоор нөхөн төлбөрийг хэсэгчлэн урьдчилан олгодог болох, давхар даатгалын компанийн үйл ажиллагааны хамрах хүрээг хязгаарласан зохицуулалтыг бууруулах зэрэг өөрчлөлтийг тусгасан бөгөөд хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон төрийн байгууллагаас зардал гарахгүй байхаар боловсруулсан байна. Малын индексжүүлсэн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг D.parliament.mn цахим сайтад байршуулж иргэд, олон нийтийн саналыг авч байгаа болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй байгаа, индексжүүлсэн даатгалын нөхөн төлбөрийг урьдчилан олгох гэснийг тодруулах, Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ уг хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Малчны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд малчин нь нэн хөнгөлөлттэй зээл авахад малын индексжүүлсэн даатгалд хамрагдсан байх шаардлага тавьж байгаа нь суурь хуулийнхаа зорилготой нийцэж байгаа эсэх, арилжааны банкны зээл олголтын үйл явцаар дамжуулан малын индексжүүлсэн даатгалыг албан журмын болгож байгаа эсэх, зудад өртсөн малчдыг гамшгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх, сөрөн тэсвэрлэх боломжийг нэмэгдүүлэх зорилгоор малчдад олгож байгаа нөхөн олговрыг хуульд заасан хугацаанаас өмнө олгох зохицуулалтын талаар, Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал уур амьсгалын өөрчлөлт, байгаль цаг уурын давагдашгүй хүчин зүйлийн давтамж нэмэгдсэн одоо цаг үед энэ хуулийн ач холбогдол буурч байгаа бөгөөд эрхэлж байгаа аж ахуй нь байгалиас хараат байгаа учраас эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эрсдэл үүссэн тохиолдолд эрсдэл хуваалцдаг, малчдынхаа амьдралын баталгаа, ядуурлаас хамгаалах тогтолцоог бүрдүүлэх зорилгоо хангаж байгаа эсэх, даатгалын хувь хэмжээ, босго үзүүлэлтийг бүсчилсэн байдлаар тогтоох боломж байгаа эсэх, малчдад олгох нөхөн төлбөрийн явцын мэдээллийг үндэслэн урьдчилан олгоод, гүйцэтгэлээр гарсан зөрөөг хэрхэн тооцож байгаа талаар асуулт асууж, хариулт авлаа.

Түүнчлэн Улсын Их Хурлын гишүүн М.Ганхүлэг Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт нь малчдад чиглэсэн гэхээс илүү даатгалын компани болон арилжааны банкнуудын үйл ажиллагааг дэмжсэн ашгийн төлөө байх агуулгатай байгааг анхаарах, Улсын Их Хурлын гишүүн Г.Ганбаатар Монгол Улсын Үндсэн хуульд заасан мал сүрэг үндэсний баялаг, төрийн хамгаалалтад байх гэсэн агуулгад нийцүүлэн даатгалын хураамжийн 50 хувийг төрөөс, 50 хувийг малчдад өөрсдөө төлөх боломжийг бүрдүүлэх, Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга төсөлд давхар даатгалын үйл ажиллагаа эрхлэх компани нь төрийн болон хувийн хэвшлийн оролцоотой компани байхаар тусгасан нь давхар даатгалын үйл ажиллагаанд төрийн зохицуулалт байх шаардлагатай эсэх талаар, хувийн хэвшилд шилжүүлснээр эрсдэл үүсэх эсэх, тодорхой судалгаа байгаа эсэх, хамтын эрсдэлийн алдагдлаас хамгаалах, дээд, дунд түвшний эрсдэлийг хамгаалах зэрэг сангуудын үйл ажиллагааг нэгтгэн зохицуулах боломжтой эсэх талаар асуулт асууж хариулт авлаа.

Хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ, Г.Ганбаатар малын индексжүүлсэн даатгалын талаарх ойлголтыг малчдад түлхүү өгөх, сурталчлан таниулах болон Үндэсний давхар даатгалын компани үйл ажиллагаагаа сайжруулахад анхаарах, Улсын Их Хурлын гишүүн С.Замира даатгалын үр өгөөжийг малчдад сайн ойлгуулах, даатгалд хамрагдсан малчдын нөхөн төлбөрийг чирэгдэлгүйгээр олгох боломжийг бүрдүүлэх талаар санал хэлсэн болно.

Малын индексжүүлсэн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 58,8 хувь нь үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, Малын индексжүүлсэн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн хэлэлцэх эсэх талаар БОХХАА-н байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээсээ хүсье. Анхаарал хандуулсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Баярлалаа Бат-Эрдэнэ гишүүнд. Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Болдын Жавхлан Сангийн сайд, Цэндгомбын Болорчулуун ХХААХҮЯ-ны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Батбаатарын Амарбаясгалан Сангийн яамны Санхүү бодлогын газрын Санхүүгийн зах зээл, даатгалын хэлтсийн дарга, Батсайханы Гарамханд Сангийн яамны Санхүүгийн зах зээл, даатгалын хэлтсийн мэргэжилтэн, Насанбатын Батцэцэг Санхүүгийн зохицуулах хорооны Даатгалын газрын ахлах референт, Эрдэнэбилигийн Сайнзаяа СЗХ-ны Даатгалын газрын референт, Батмөнхийн Жавхлант Үндэсний давхар даатгал ХК-ийн гүйцэтгэх захирал, Пүрэвлхагвын Шинэзул Үндэсний давхар даатгал ХК-ийн эрсдэлийн удирдлагын ахлах ажилтан, Дугарсүрэнгийн Мөнхбилиг Үндэсний давхар даатгал ХК-ийн ерөнхий андеррайтинг.

Ингээд Улсын Их Хурлын гишүүд хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан намын бүлэгт болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууна.

Асуулт асууж, хариулт авна. Нийт энэ хуулийн төслийг Дэгийн тухай хуулийн дагуу 180 минутаар хэлэлцэхээр хугацааг Даргын дэргэдэх зөвлөл дээр тогтсон байгаа. Ингээд 180 минутад харгалзах гишүүд буюу нийт 18 гишүүн асуулт асуухаар нэр ирүүлсэн байна. Дарааллын дагуу Ухнаагийн Отгонбаяр гишүүн асуулт асууя.

У.Отгонбаяр: Өглөөний мэнд хүргэе та бүгдэд. Засгийн газраас Малын индексжүүлсэн даатгалын тухай хууль орж ирж байгаад маш их баяртай байгаа. Өнөөдөр энэ хуулийг орж ирж байгааг хараад 21 аймаг 330 сумд суугаа малчид маань ч гэсэн их баяртай байгаа байх. Яагаад гэвэл өнгөрсөн хугацаанд малын индексжүүлсэн даатгалд хамрагдаад малынхаа хорогдлын нөхөн төлбөрийг төдийлөн малчид маань авч чаддаггүй байсан. Хамрагдалт хүртэл маш бага. Дунджаар 13-аас 18 хувь нь энэ малын индексжүүлсэн даатгалд хамрагддаг. Яагаад хамрагддаг вэ гэвэл 1 дүгээрт гол шалтгаан нь мал хоргодоод нөхөн төлбөр авах гэдэг энэ бол 1 дүгээр шалтгаан биш. Банкнаас зээл авахын тулд малын индексжүүлсэн даатгалд хамрагддаг ийм л байдал өнөөдрийг хүртэл явж байгаа.

Тэгэхээр энэ малын индексжүүлсэн даатгалыг зайлшгүй шинэчлэх өөрчлөх зайлшгүй шаардлага байгаа. Тийм учраас Засгийн газраас энэ малын индексжүүлсэн даатгалыг Улсын Их Хурал руу оруулж ирж байна гэж би хувьдаа ойлгож байгаа. Өнгөрсөн жил хамгийн их хэмжээний нөхөн олговор олгогдсон. Яагаад гэвэл өнгөрсөн жил тэр дундаа Монгол Улсын зүүн бүс нутаг, говийн бүс, зүүн бүс, төвийн бүсээр үндсэндээ байгалийн гамшиг тохиолдсон. Тэрний улмаас 18 орчим тэрбум төгрөгийн нөхөн олговор олгогдсон. Үүнээс эхний хамгийн их нөхөн олговор авсан 3 аймгаар Сүхбаатар, Дорноговь, Хэнтий гэсэн энэ 3 аймаг хамрагдаж, үндсэндээ хамгийн анхны удаа жишээ нь Сүхбаатар аймаг гэхэд 2382 өрх даатгалд хамрагдсанаас 100 хувь нөхөн төлбөрөө 4,1 тэрбум төгрөг авсан байх жишээтэй. Дорноговь аймаг 1537 өрх даатгалд хамрагдсанаас 1329 өрх ингээд бараг 90 орчим хувьтай, Хэнтий аймаг мөн ялгаагүй 1475 өрх хамрагдсанаас 1413 гээд гээд 95 орчим хувьтай гээд.

Хэрвээ байгалийн гамшиг яг өнөөгийн энэ хуулийн зохицуулалтаар бол байгалийн гамшиг л тохиолдвол бид бүхэн нөхөн төлбөрийг нэлээн бололцооны түвшинд авах юм байна гэдэг ийм л хуулийн зохицуулалт байгаа. Тэгээд энийг зайлшгүй засаж залруулах зайлшгүй шаардлага байгаа. Хуулийн төсөлд малын өргөдлийн босго хувь процентыг авсан. Энийгээ аваад Засгийн газар энэ босго хувийг тогтоохоор хуулийн төсөлд тусгагдсан байна лээ. Энийг яг ямар шалгуур үзүүлэлтээр энэ хувь хэмжээг Засгийн газар тогтоох юм бэ? Энэ дээр нэг тодорхой хариулт өгөөч. Тэгээд саяын хариултыг сонсож байгаад тодруулъя.

Д.Амарбаясгалан: Малын индексжүүлсэн даатгалтай холбоотой энэ асуудал дээр маш тодорхой сайн тайлбар хиймээр байна. Хэн тайлбар хийх вэ? Үндэсний давхар даатгал уу? Хэн байна вэ? 20 дугаар микрофон. Малчид яг энэ даатгалын талаар маш олон асуулттай байдаг. Тэгэхээр маш ойлгомжтой тодорхой тайлбар хийж өгмөөр байна. Тэгээд энэ хуулийн нэмэлт, өөрчлөлт оруулж байгаа гол утга, зорилго санаа юу вэ гэдгийг маш энгийнээр олон нийтэд ойлгомжтой хэлбэрээр тайлбарыг сайн хийж өгөх ёстой шүү. Ажлын хэсгийн 20 дугаар микрофон.

Б.Жавхлант: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүдийн энэ өдрийн мэндийг хүргэе. Үндэсний давхар даатгал ХК-ийн гүйцэтгэх захирал Батмөнхийн Жавхлант байна. Малын индексжүүлсэн даатгалын тухай хууль 2014 онд хэрэгжиж эхэлснээсээ хойш ингээд 11 дэх жилдээ хэрэгжилтдээ явж байна. Өнгөрсөн хугацаанд сая гишүүний дурдсанчлан малын индексжүүлсэн даатгалд хамрагдсан малчдын тоо хангалттай түвшинд байхгүй байгаа. Дунджаар 15-аас 16 орчим хувийн малчид маань даатгалд хамрагддаг, нийт мал сүргийн 9-өөс 11 хувь маань даатгалд хамрагддаг гэсэн ийм статистик тоон үзүүлэлт харагддаг. 2023 онд Улсын Их Хурлын БОХХАА-н байнгын хорооны дэргэд ажлын хэсэг байгуулагдаж, хуулийн хэрэгжилтэд хяналт тавих, үнэлэлт дүгнэлт өгөх ажлын хэсэг байгуулагдсан байгаа. Энэхүү ажлын хэсгийн ажлын хүрээнд нийт 21 аймгийн Засаг дарга нараас санал асуулга болон малчидтай нүүр тулсан уулзалтад тавигдсан асуулгын хүрээнд энэ босго үзүүлэлтийн асуудлыг уян хатан болгох асуудлыг шийдэж өгөөч гэсэн энэ асуултыг ихэнх малчид болон Засаг дарга нарын зүгээс тавьсан байгаа.

Ийм учраас ерөнхийдөө энэ даатгалын хамрагдалт буюу энэ малын индексжүүлсэн даатгалын хохирлыг илүү бодитой болгох зорилгоор сумын хэмжээнд малын индексийн даатгалын босго үзүүлэлтийг уян хатан болгох зайлшгүй шаардлага үүсэн бий болсон юм. Малын индексжүүлсэн даатгалын босго үзүүлэлт нь одоогийн байдлаар хуульд 6 хувь байна. 1 дүгээр босго үзүүлэлт 6 хувь байна гэж зааж өгсөн байгаа. Энэ нь юу гэсэн үг вэ гэхээр 6 хувь хүртэлх хэмжээний хохирлыг малчин өөрөө хариуцаад, 6-аас дээш хувийн хохирлыг даатгалын компани хариуцна, даатгалд олон улсын давхар даатгалын компани хариуцах ийм зохицуулалтыг оруулж өгсөн.

Энэ маань юу гэсэн үг вэ гэхээр зэрэг үндсэндээ малчны өөрийн хариуцах хэсэг маань зарим сумдад өндөр түвшинд байгаад байгаа учраас малчид даатгалд хамрагдахгүй байх нэг хөшүүрэг болж өгдөг юм байна гэсэн ийм дүр зураг харагдаж байгаа юм. Тэгэхээр зэрэг одоогийн байдлаар 6 хувь гээд хатуу хуульчлан тогтоосон байгаа учраас үүнийг уян хатан болгож өөрчлөх боломж өнөөдрийн байдлаар Үндэсний давхар даатгал компани болоод даатгалын компаниудад байхгүй байгаа юм. Ийм учраас шинээр орж байгаа энэ хуульд босго үзүүлэлтийг уян хатан болох зохицуулалтыг хийх ийм юм оруулж ирсэн. Үндсэндээ одоо байж байгаа даатгалын малын индексжүүлсэн даатгалын тухай хуульд заасан зохицуулалтын дагуу тухайн сумын малын хорогдол, даатгуулагчдын тоо, хураамжийн орлогын хэмжээ, нөхөн төлбөр олголт гэсэн энэ 4 үндэслэлийг харгалзан үзэж босго үзүүлэлтийг Засгийн газар тогтоодог байгаа. Энэ хуулийн зохицуулалт өөрчлөгдөхгүй.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Нэмж хариулт өгөх үү? 20 дугаар микрофон нээе, нэмэлт минут өгье.

Б.Жавхлант: Энэ 4 үндэслэл, энэ 4 суурь статистик тоон мэдээлэл дээр үндэслээд малын индексжүүлсэн даатгалын босго үзүүлэлт буюу тухайн сумын том малын зүй бус хорогдлын хувь хэмжээг тодорхойлж өгснөөрөө тухайн сум сумд ялгамжтай байдлаар энэ босго үзүүлэлтийг тогтоох ийм боломжийг бүрдүүлнэ гэж харж байгаа юм. Өөрөөр хэлбэл зарим сумдад босго үзүүлэлт бага байх боломжтой, зарим сумдад одоогийн байж байгаа түвшиндээ байлгах ийм боломжийг бүрдүүлэх. Өөрөөр хэлбэл тухайн сумын малын хорогдол, даатгалд

хамрагдалтын хэмжээнээс шалтгаалаад актуар үндэслэл дээр тус суурилж босго сум болгонд ялгавартай тогтоох боломжийг энэ хуулийн өөрчлөлтийн дагуу бий болгоно гэж харж байгаа. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Ухнаагийн Отгонбаяр гишүүн тодруулж асууя.

У.Отгонбаяр: Ямар ч байсан тэр 6 хувийн босгыг авч, сум болгонд бүс нутаг болгонд харилцан адилгүй тогтоохоор байгаа гэж ойлголоо. Нөхөн олговрын асуудал, хуучин одоогийн хуулийн зохицуулалтаар нөхөн олговрыг хагас жилийн мал тооллогоос хойш олгодог байсан. Энэ дээр яг ямар зохицуулалт байна вэ?

Танай балансыг аваад үзэхээр 2 дахь асуудал, танай балансыг аваад үзэхээр алдагдлаас хамгаалах нөөцийн санд 19 тэрбум, орлогод тооцоогүй нөөцийн санд 4 тэрбум. Гэхдээ энэ 2024 оны 3 дугаар улирлын байдлаар тийм дүн харагдаж байна лээ шүү. Өнгөрсөн хугацаанд өнгөрсөн жил жишээ нь 18 тэрбум төгрөг нөхөн олговорт олгосон гэж байгаа юм. Тэгээд цаашдаа энэ маань хамрагдалт нэлээн өргөн хүрээнд болоод, малчид нэлээн малаа даатгуулаад нөхөн олговор тэр 18-аас чинь дээшээгээ гараад ирэхийн.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Нэмэлт хариулт өгье. Ажлын хэсгийн 20 дугаар микрофон. Энэ дээрээ нэг зүйлийг тодруулаад хэлчихмээр байна. Сум болгон харилцан адилгүй босго хувь тогтооно гэж байна шүү дээ. Тэгээд энэ чинь цаашдаа ахиад янз янзын хувь хүний хүчин зүйлээс нөлөөлсөн нөлөөлөл ороод, ялгавартай ханддаг байдал бий болоод, нөгөө л эрх мэдэлтэн, албан тушаалтан, дархтнууд давуу байдал үзүүлээ гэдэг хэл ам руу орох суурь болж байгаа юм биш биз дээ? Энийгээ ойлгомжтой хэлбэрээр тайлбарламаар байна. Сая энэ СЗХ, Нийслэл энэ автомашины албан журмын даатгалтай холбоотой асуудал гаргаад л туршлагатай, туршлагагүй жолооч ялгавартай даатгалд хамрагдана гэдэг асуудал хөндөгдөнгүүт эргээд иргэд бол тэрийг бүрэн ойлгож хүлээж авахгүй, эсэргүүцэлтэй тулгарч байсан юм шүү дээ. Тэгэхээр энэ асуудал дээр тодорхой тайлбар өг, хариулт өгье. 20 дугаар микрофон.

Б.Жавхлант: Отгонбаяр гишүүний асуултад хариулъя. Энэ 1 дүгээрт энэ асуудал маань өөрөө одоо байж байгаа Малын эдийн засгийн даатгалын тухай хуулийн дагуу хагас жилийн мал тооллогын нэгдсэн дүн гарсны дараа нөхөн төлбөр олгодог нь ялангуяа энэ даатгалын ач холбогдлыг ойлгож хүлээж авах энэ даатгуулагчид малчдын идэвхийг сэтгэлийг ер нь бууруулдаг нэг хүчин зүйл байна гэж хараад байгаа. Олон улсын эрдэм шинжээчдийн зүгээс ч гэсэндээ ирчихсэн гамшгийн тохиолдлын үе дэх эрт санхүүжилт маань өндөр үр ашигтай ийм зохицуулалт болж өгдөг. Ялангуяа даатгалд хамрагдах хөшүүргийн зөв хувилбар болж нэг зөв хувилбар болдог гэж тайлбарладаг юм. Ийм учраас одоо орж байгаа хуулийн өөрчлөлтөд Үндэсний статистикийн хорооноос гаргасан явцын мэдээнд үндэслэж, тухайн сум орон нутгийн босго үзүүлэлт маань нийт малынхаа хорогдол нь 50 хувиасаа дээш.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Сангийн сайд Болдын Жавхлан нэмж хариулъя.

Б.Жавхлан: Отгонбаяр гишүүний асуултад нэмж хариулъя. Гишүүд маань энэ хуульд нэлээн анхаарал хандуулаарай. Энэ их чухал хууль. Тэгээд энэ өвлийн завсарлагаагаар хөдөө орон нутагт ажиллах гишүүд маань ярьж хэлэлцэх,

малчидтай яг газар дээр нь хуулийг ойлгуулах, тэндээс санал шүүмжийг нь авч ирэх, тэгээд хаврын чуулганаар үргэлжлүүлэн хэлэлцэх ийм товтой болж байгаа. Ерөөсөө л гол 2 өөрчлөлт байгаа. Энд саяын Амарбаясгалан даргын асуудаг тэр даатгалын хувь хэмжээнд огт өөрчлөлт орохгүй, төлбөрт огт өөрчлөлт орохгүй. Харин даатгалын тохиолдол үүсэх эрсдэлийн босгыг нь одоо хууль дээр аягүй модон хатуу 6 хувь гээд заачихсан байгааг байхгүй болгоод, уян хатан болж ирж байгаа гэсэн үг 1 дүгээрт.

2 дугаарт зуд болно, өвөлжингөө болно, хавар ингээд л хэцүү тулна. Тэгээд бүр яг хагас жилийн тооллогоос хойш 7 сарын 1-нээс хойш статистик гарахаар нөгөө даатгалынхаа төлбөрийг өгдөг байсан юм. Одоо хүртэл тэгж байгаа. Энийг болиулаад уян хатан болгож байгаа юм. Бүр 11 сараас эхлээд сар сарын мэдээ аваад, эрсдэлийн босго түвшнээ давуулсан тохиолдолд нөхөн төлбөрийг нь урьдчилаад эхлээд явцыг нь дунд нь өгдөг ийм гол 2 өөрчлөлт л орж байгаа юм. Тэгэхээр өөрөөр хэлбэл малчдадаа илүү хүртээмжтэй, илүү ойлгомжтой, тодорхой тийм яг малчид руугаа чиглэсэн илүү зөөлөн болж байгаа гэж ойлгож болно.

Д.Амарбаясгалан: Энэ дээр Хүнс, хөдөө аж ахуйн яам Болорчулуун дарга хариулах уу? Ер нь малчид яг энэ индексжүүлсэн даатгалын үйл ажиллагаанд сэтгэл ханамж хэдэн хувьтай байдаг юм бэ? Тэрийг судалсан уу? Өнгөрсөн жил зуднаар орон нутагт бид нэлээн явж хүрч ажилласан. Иргэд, малчдын хувьд яг индексжүүлсэн даатгал өөрөө эргээд нөхөн төлбөр олгодог байдал сумынхаа түвшинд 6 хувьдаа хүрээгүй бол бид хий хоосон даатгал хийлгээд байна шүү дээ гэсэн нэг ерөнхий тийм зүйл яриад болж өгдөггүй. Мэдээж энэ даатгалын үр дүнгээр үнэхээр 6 хувьдаа хүрчихвэл малаа хорогдуулсан иргэд даатгал авахаас гадна, малаа хорогдуулаагүй байсан иргэд ч тодорхой хэмжээнд даатгалын тэтгэмжийн нөхөн төлбөрийг авчихсан тийм тохиолдлууд гардаг юм байна лээ шүү дээ. Тэгэхээр яах вэ тэр хэсэг нь болохоор дуртай байгаад байдаг, хорогдуулчихсан хэсэг чинь өөрөө сэтгэл ханамж ямар байдаг юм бэ? Энэ дээр нэг мэдээлэл, нэмэлт хариулт өгөөдхөөч. Хэн өгөх вэ? Болорчулуун дарга уу? Ажлын хэсгийн 19 дүгээр микрофон.

Ц.Болорчулуун: ХХААХҮЯ-ны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Болорчулуун. Их Хурлын даргын асуултад нэмэлт хариулт өгье. Тэгэхээр ер нь даатгалын тогтолцоо гэдэг хөдөө аж ахуйн салбарыг эрсдэлээс бууруулах хамгийн том механизм байгаа. Хөдөө аж ахуй тэр дундаа мал аж ахуй, газар тариалангийн даатгал үйлчилж байж цаг уурын энэ уур амьсгалын өөрчлөлттэй дасан зохицож, эрсдэлийг сөрөн туулах ийм боломжийг бүрдүүлнэ гэж харж байгаа. Малын индексжүүлсэн даатгалтай холбоотой хуучин үйлчилж байсан хууль дээр учир дутагдалтай ийм зүйлүүд байсан учраас малчдын хамрагдалт бага байсан. Одоо орж байгаа өөрчлөлт дээр энэ малчид нэлээд хамрагдалтын хэмжээ нэмэгдэх, тэгээд нөхөн төлбөрөө урьдчилж авах, цаг хугацаандаа авах ийм боломж бүрдэхээр хуулийн зохицуулалт орж ирж байгаа. Тийм учраас хамрагдалтын тоо нэмэгдэнэ. Хуучин хууль дээр мэдээж яг малчид бүрэн дүүрэн хамрагдаж нөхөн төлбөрөө авах нь удаашралтай байсан учраас сэтгэл ханамж.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Нэмэлт минут өгье. Гүйцээж хариулъя.

Ц.Болорчулуун: Тэгэхээр малчдын хувьд хуучин үйлчилж байсан хуулийн зохицуулалт дээр сэтгэл ханамж төдийлөн сайн биш байсан гэдэг. Зүгээр хөдөө

орон нутагт ажиллаж байх үед ийм яг бүрэн иж бүрэн судалгаа хийсэн асуудал харьцангуй байхгүй байгаа.

Д.Амарбаясгалан: Тэгэхээр чинь байна шүү дээ ийм учир дутагдалтай юм зүгээр надад сонсогдож байгаагаар яах вэ тэр хувь босго хэмжээг ингээд нэг тогтоочихъё. Тэгээд нөхөн төлбөрийн асуудлыг хагас жилийн тооллогоор биш, нөхөн мал хорогдсон тухайн цаг үед нь олгоё гэж байгаа байхгүй юу. Тэгээд сумын хэмжээнд тооллого хийгээд, тэгээд наадхыг чинь олгоно гэхээр тийм амархан шууд шийдэгдчихгүй зүйл гэдгийг та бид бүгдээрээ мэдэж байгаа юм. Сум болгоноос хамаараад даатгалын тэр хувь хэмжээтэй холбоотой асуудал гэж ойлгохоор яаж тогтоох юм бэ, яаж үнэлэх юм бэ? Зудархуу, цагаан зуд, төмөр зуд гээд энэ ОБЕГ-аас тогтоодог тэр нөхцөл байдалтай нь уялдуулсан байдлаар эсхүл энэ хуульдаа тодорхой хувь хэмжээг нь тогтоож өгөх ёстой юм уу? Хугацаа нь яаж явах юм бэ гэдэг дээр жоохон дараа дараачийн хүмүүсийн асуулт дээр жоохон тодорхой хариулаад явах нь зүйтэй байх гэж бодож байна.

Мэдээж Сангийн сайдын хэлж байгаа үнэн. Энэ индексжүүлсэн даатгалд иргэдийн зүгээс үл ойлгогдох, тодорхой хэмжээний сэтгэл ханамж авахгүй байгаад байгаа нөхцөл байгаа учраас хууль, эрх зүйн орчинд нь сайжруулалт хийж өгөх ёстой гэж зорилго агуулж байгаа нь зөв байгаад байна. Гэхдээ хийж байгаа өөрчлөлт нь ахиад амьдралаас хол тасархай юм байж болохгүй. Тэгэхээр энийг их тийм сайн анхаарч, асуудалд хандаарай. Дараачийн гишүүн асуулт асууя. Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн асуулт асууя.

Х.Баасанжаргал: Би сая Их Хурлын даргын асуусан тэр малчид сэтгэгдэл сэтгэл ханамж хэр байдаг вэ гэдгийг магадгүй энэ даатгалд хамрагдаж байгаа хамрагдалтын тоо өөрөө харуулж байгаа гэж хувьдаа харж байна. Нийт өрхийн 11-ээс 18 хувь нь, нийт малын 7-гоос 8 хувь нь л даатгуулж байна гэж байна. Тэгэхээр энэ чинь 14 оноос хойш явж байгаа бүтэн 10 жил болж байгаа ийм даатгалын тогтолцоонд малчдын итгэх итгэл ямар байна вэ гэдэг нь даатгуулж байгаа энэ тоо хангалттай би харуулна гэж бодож байна. Тэгэхээр энэ даатгалын систем энэ даатгалын тогтолцоо өөрөө яг малчин өрхийн хаалгаар нь яг орж чадаж байна уу, үнэхээр тэр эрсдэлийг нь хуваалцаж чадаж байна уу, үгүй юү гэдгийг бид өнгөрсөн жилийн зудаар хангалттай харсан.

Тийм учраас 2, 3 зүйл тодруулж асууя. Би энэ асуултыг Бүлгийн хурал дээр асуусан. Араас материал, судалгаа явуулна гэсэн ирээгүй. Тэгэхээр дахиж энэ хуулийн төслийн хувьд зарим нэг зүйлийг зайлшгүй харах ёстой гэж бодож байна. 1 дүгээрт сумын хэмжээнд энэ хэмжээг тогтоодог хэвээрээ орж ирж байна. Энийг жижиглэх багаар болгох боломж байна уу? Болдог өрх айлаар болгомоор байна. Боломжгүй гэдэг хариултыг та бүхэн Бүлгийн хурал дээр хийсэн. Гэхдээ энэ хойд талын энэ хэлэлцүүлсэн материалыг хараад уншаад үзэхээр иргэдийн зүгээс яг энэ асуултыг та бүхнээс асуусан байгаа юм л даа. Тэгэхэд буцаагаад та хэд зүгээр боломжгүй л гэдэг хариулт хэлээд, дээрээс нь энэ малыг тоолох, эрсдэлийг зөвөөр үнэлэх үнэхээр малаа хорогдсон уу, үгүй юү гэдэг тоог үнэн зөв гаргахад эргэлзэж байна гэж байгаа байхгүй юу.

Гэтэл бид чинь малаа хамгийн сайн тоолдог хүмүүс шүү дээ. Хүүхдээсээ илүү тоолдог. Хүүхдээсээ илүү ажилладаг нэгж тэр мал дээр байгаа. Тэгэхээр одоо болтол бид энэ малын тоо, тооллого, эрсдэлийг, малаа үнэн зөв мэдүүлж байна

уу, үгүй юу гэдэг дээр эргэлзэж байгаа бол энэ даатгал өөрөө ажиллахгүй байгаагийн нэг шинж. Тэгэхээр энийг багийн хэмжээнд 1 дүгээрт аваачих боломж дахиад байна уу? Холбоотой тоо судалгааг нь яг тоотой нь хэлээч гэсэн байна.

2 дугаарт хэлэлцүүлсэн байдал. Олон нийтээр хэлэлцүүлсэн байдал, хөдөө орон нутгаар хэлэлцүүлсэн байдал дээр нэг хариулт өгөөдхөөч. Хуулийн тус төсөлд хавсаргасан материалыг харахаар хэлэлцүүлсэн байдал хангалтгүй байна. Тэгэхээр ялангуяа орон нутгийн иргэд, малчдын оролцоо энд маш чухал. Тэгэхээр энэ хэлэлцүүлсэн байдал дээр нэг хариулт өгөөч.

3 дугаарт тэр 6 хувийн босгыг байхгүй болгож байгаа юм, ЗГ өөрөө тогтоох гэж байгаа юм гэж битгий худлаа яриад бай. 7.2 чинь хэвээрээ орж ирж байгаа шүү дээ, 6 хувь чинь хэвээрээ орж ирж байгаа. Зөвхөн 1 хувиар нэмдэг, хасдгийг л хасаж байгаа болохоос биш яг хэвээрээ орж ирж байгаа. ЗГ тогтоодог нь хэвээрээ байгаа. Тэгэхээр үнэн зөв мэд мэдээлэл өгөөд, яг бодитой мэдээлэл өгөөд, дээрээс нь бүүр босго хүндэрч орж ирж байна. Энэ хуулийн төслөөр чинь. Бид эсвэл буруу ойлгоод байна уу? Давхар даатгалын компанийн саналыг харгалзаж, энэ босгыг тогтоодог болно гээд байгаа байхгүй юу. Хэзээ ч гаднын олон улсын байгууллага, олон улсын даатгалын компани манай нүүдлийн мал аж ахуйг ойлгоод, энэ босгыг бууруулахгүй, улам өндөр болно гэсэн үг. Дахиад энэ даатгалын систем бүүр улам ажиллахгүй болно гэсэн үг. Тэгэхээр энэ асуултуудад хариулж өгөөч.

Д.Амарбаясгалан: Сангийн сайд Болдын Жавхлан хариулт өгье.

Б.Жавхлан: Баасанжаргал гишүүний асуултад ерөнхий мэдээлэл өгье. Манайхан нэмээд хариулаарай. Энэ бэлчээрийн мал аж ахуйтай цөөхөн улс гүрэн дэлхийд байдаг. Түүн дундаа бэлчээрийн мал аж ахуйндаа даатгалын тогтолцоотой цорын ганц улс нь манай улс. Нүүдэлчин соёлтой Киргиз, Казахстан улсуудад малын даатгал байдаг. Тэгэхдээ бэлчээрийнх байхгүй, зөвхөн фермерийнх байдаг. Цорын ганц бэлчээрийн даатгалтай улс бол манайх. Энэ бол даатгалын тогтолцоо, тэрнээс халамжийн тогтолцоо биш. Хэрвээ сумаар биш, багаар, айл өрхөөр болоод явчих юм бол энэ шал өөр халамжийн тогтолцоо болоод явчихна. Зуд боллоо, байгалийн гамшиг боллоо, нэрвэгдлээ, халамж өгдөг тийм л тогтолцоо руу яваад орчихно шүү дээ. Энэ чинь өөрөө даатгалын тогтолцоо Тэр босго байхгүй болж байгаа. Тийм, тэрийг хуулиа сайн унших хэрэгтэй байх. Тэр талаар мэдээлэл өгөөдөх.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн 20 дугаар микрофон. Үндэсний давхар даатгал.

Б.Жавхлант: Үндэсний давхар даатгал ХК гүйцэтгэх захирал Жавхлант. Баасанжаргал гишүүний асуултад хариулъя. Энэ багийн түвшинд гарах хохирлын асуудлыг ер нь яах вэ малчидтай хийж байгаа нүүр тулж байгаа уулзалтууд дээр ч яригддаг. Энэ босго үзүүлэлтийг 2005, 6 онд Дэлхийн банкны шинжээчдийн зүгээс боловсруулсан энэ даатгалын бүтээгдэхүүний хүрээнд гарч ирсэн. Энэ хугацаанд багийн түвшин, сумын түвшин, аймгийн түвшин гэсэн хэд хэдэн түвшнүүд дээр тооцоо судалгаа хийгээд, хамгийн боломжит буюу эдийн засгийн хувьд хэрэгжих боломжтой энэ юу нь босго үзүүлэлтийн хязгаар нь сумын босго үзүүлэлт юм байна гэсэн 1 дүгээрт ийм асуудал яригдсан, яригдаад энэ сумын

босго үзүүлэлт дээр 2006 оноос 2014 он хүртэл Монгол Улсын хэмжээнд Монгол Улсын ЗГ-тай хамтраад төслийн үед туршилтын журмаар хэрэгжээд.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Нэмэлт минут өгье.

Б.Жавхлант: Цаашдаа хэрэгжих боломжтой юм байна гээд энэ хууль маань батлагдсан байдаг. 2 дугаарт нь энэ багийн түвшинд хохирлыг тооцохтой холбоотойгоор өнгөрсөн 2023, 2024 оны малын тоо хорогдолтой уялдуулаад Архангай, Увс, Хэнтий гэсэн 3 бүс нутгийг аймгуудыг сонгож энэ багийн түвшний хохирлоор тооцвол бид ямар хэмжээнд нөхөн төлбөр гарах вэ гэдэг энэ тооцооллыг хийж үзсэн. Яг 23, 24 оны тоон мэдээлэл дээр үндэслэх юм бол нэг сумд дунджаар тэрбум төгрөгийн малын даатгалын хохирол гарах юм байна гэдэг ийм тооцоо судалгаа гарсан. Энэ тооцоо судалгааг даатгалын компаниуд болон Үндэсний давхардал компанийн актуарч нартай хамтарч хийгээд, ер нь энэ тохиолдолд ер нь хувийн хэвшил энэхүү даатгалын бүтцэд оролцох боломжгүй юм гэдэг байр сууриа илэрхийлсэн байдаг.

3 дугаарт нь багийн түвшний хохирол гэдэг үндсэндээ сум орон нутгийн хэмжээнд эрсдэлийг удирдах боломжтой.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Дахиж нэмэлт минут өгье, гүйцээж хариулъя.

Б.Жавхлант: Сум орон нутгийн хэмжээнд тухайн эрсдэлийг удирдах боломжтой хохирол гэж тооцох үндэслэлтэй гэж үздэг. Өөрөөр хэлбэл 6 хувь гэдэг маань энэ сумын хэмжээнд босго үзүүлэлт тавьж байгаа нь тухайн сум орон нутагтаа гамшгийн нөхцөл байдал буюу давагдашгүй хүчин зүйл бий болсны улмаас даатгалын тохиолдол бий болсон гэж ойлгогдох энэ нөхцөл байдлыг даатгалын түвшинд ойлгуулахаар ингэж тавьж хуульчилж өгсөн байгаа. Өөрөөр хэлбэл энэ даатгалын системийг бий болгохын тулд сумын босго үзүүлэлт гэдэг тоо гарч ирсэн юм байна лээ.

Хэлэлцүүлгийн түвшинд бид өнгөрсөн 2023, 2024 онуудад давхардсан тоогоор 8 аймгийн 30 гаруй сумдад ажилласан байгаа. Мөн түүнчлэн НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын хийсэн 2024 онд 21 аймгийн 10 мянга гаруй малчидтай хийсэн нүүр тулсан уулзалт хийсэн судалгааны үр дүн, тайлангууд бид нарт ирсэн байдаг.

Д.Амарбаясгалан: Ер нь жилд дунджаар малын индексжүүлсэн даатгалаас хэчнээн төгрөгийн орлого олдог, эргээд магадгүй 3 жилийн дунджаар ч юм уу нөхөн олговорт хэдэн төгрөг олгож байгаа талаар нэг мэдээлэл өгөөдхөөч?

Б.Жавхлант: Амарбаясгалан даргын асуултад хариулъя. Үндэсний давхар даатгал ХК-ийн гүйцэтгэх захирал Жавхлант. Үндэсний давхар даатгал ХК нийт 7 даатгалын компанитай хамтраад 21 аймаг 330 сумдад малын индексжүүлсэн даатгалын борлуулалтын үйл ажиллагаа эрхэлж байна. Өнгөрсөн 10 жилийн хугацаанд нийтдээ 37 тэрбум төгрөгийн хураамжийн орлого төвлөрүүлсэн. Үүнээс 29,4 тэрбум төгрөгийн нөхөн төлбөрийг олгогчоод байгаа. Үүнийг бид юу гэж ойлгож болох вэ гэхээр зэрэг өнгө сайн жилүүддээ бид эрсдэлийнхээ нөөц санг

хуримтлуулж байна. Үндсэндээ гамшгийн жилүүдэд бид нөхөн төлбөр олгож байна гэдэг ийм дүр зургийг эндээс харж болно.

Д.Амарбаясгалан: Монгол Улсын Шадар сайд Сайнбуянгийн Амарсайхан хариулт өгье.

С.Амарсайхан: Малын индексжүүлсэн даатгалын энэ тогтолцоо ер нь ажиллахгүй байгаа, үр дүнгүй байгаа гэдгийг ганцхан жишээгээр бид харж болж байгаа юм. Өнгөрсөн 23-аас 24 оны хооронд нийтдээ 8 сая гаруй мал хорогдсон. Мөнгөн дүнгээр нь аваад үзвэл зах зээлийн хамгийн бага үнээр тооцвол 1,5-аас 2 их наяд төгрөгийн ийм хохирол учрахад индексжүүлсэн даатгалын журмаар 18-хан тэрбум төгрөгийн нөхөн олговор олгосон байгаа юм. Тийм учраас энэ журмыг цааш нь шинэчилж, 1 дүгээрт нөхөн төлбөрийг шуурхай бодитой олгодог, хүнд сурталгүй механизмыг бүрдүүлэх, 2 дугаарт энэ одоогийн индексжүүлсэн системийг өөрчилж, малыг хорогдсон тохиолдолд бодитойгоор хохирлыг барагдуулдаг шууд үнэлгээний тогтолцоог бүрдүүлэх шаардлагатай байгаа.

Өөрөөр хэлбэл малчин бүр даатгалд хамрагдах боломжийг бүрдүүлээд, тэгээд энэ малчдыг бүхэлд нь хамарсан даатгалын тогтолцоог бүрдүүлэх 1 дүгээр асуудал байгаа. 2 дугаарт энэ хуулийг хэлэлцүүлгийн явцад ажлын хэсэг ажиллаж нэлээн сайжруулах, шинэчлэх, тооцох асуудал бий. Сая Баасанжаргал гишүүний хэлдэг маш чухал бөгөөд үнэн асуудлууд, анхаарахгүй бол болохгүй асуудлууд байгаад байгаа юм. Энэ хуулийг бид уур амьсгалын өөрчлөлтөөс сэргийлэх, хөдөө аж ахуйн салбарын сөрөг үр дагаврыг багасгах энэ хуультайгаа уялдуулж, тэгээд эцэст нь яг энэ тогтолцоог цааш нь ер нь хураамжаасаа эхлээд даатгалд хамрагдах, тэгээд нөхөн олговор авах, бүр хохирлоо барагдуулах бодитой ийм үр дүнтэй тогтолцоог шат шатад нь бий болгохгүй бол яг бүс нутгийн хорогдолтой уялдуулаад нөхөн олговрыг олгоно гэх юм бол малчид хамрагдах боломж бүрдэхгүй байгаад байгаа. Малчдаа хамруулж чадахгүй байгаад байгаа.

Мэдээж бид гадаад, дотоодын олон улсын байгууллагуудын зөвлөмж, зөвлөгөөг сонсоно. Гэхдээ энэ Монгол Улсын уламжлалт мал аж ахуй, газар тариалан, тэгээд байгаль орчин энэ цаг уурын нөхцөл байдалтай холбоотой яг энэ манай орны онцлогт тохирсон даатгалын системээ бид өөрсдөө бүрдүүлж, тэрийг бүрэн ашиглах хэрэглэх боломж нөхцөлийг малчдад бүрдүүлж байж цаашдаа энэ мал аж ахуйн салбарын тогтолцоо, тэгээд энэ хорогдол, аливаа зүй бус хорогдлыг бууруулах боломж нөхцөл нь бүрдэнэ гэж харж байгаа учраас манай гишүүд маань яг энэ ажлын хэсэг хэлэлцэх эсэх асуудал шийдэгдээд, ажлын хэсэг байгуулагдаад, цааш нь хэлэлцээд явах хугацаанд бүх зүйлүүд дээр нарийвчилж саналаа боловсруулж, илүү амьдралд ойрхон бодитой болгох талаас нь та бүхэн маань анхаарч ажиллаарай гэдгийг хэлье.

Д.Амарбаясгалан: Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн тодруулж асууя.

Х.Баасанжаргал: Тодруулаад дахиад энэ нөгөө дагалдаж орж ирж байгаа хууль дээр Малчны тухай хууль дээр заавал малын индексжүүлсэн даатгалд даатгуулсан байж зээл авахаар нэмээд оруулаад иржээ. Үүний шалтгааныг 1 дүгээрт тайлбарлаач. Бодвол бүх малчдаа даатгалд даатгуулах тэр л хөшүүрэг гэж харж байгаа байх. Гэхдээ энэ чинь Монгол Улсын онцлог юутай холбоотой гэсэн мөртөө энэ чинь яг албан журмын даатгал болох гээд байгаа юм уу, сайн

дурын болох гээд байгаа юм уу? Хэрвээ сайн дурын байх юм бол энд чинь шал өөр концепц үйлчлэх ёстой шүү дээ. Тэгэхээр Малчны тухай хууль дээр дагалдуулаад заавал малын индексжүүлсэн даатгалд даатгуулна гэдэг ийм заалт орж ирээд байна, үүнийгээ тайлбарлаач.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн 20 дугаар микрофон хариулт өгье.

Б.Жавхлант: Үндэсний давхар даатгал хк-ийн гүйцэтгэх захирал Жавхлант. Баасанжаргал гишүүний асуултад хариулъя. Дагаж орж байгаа хууль нь өөрчлөлт нь Малчны тухай хуульд ЗГ-аас олгож байгаа нэн хөнгөлөлттэй зээл, зээлийн хөтөлбөрт хамрагдаж байгаа малчин заавал даатгуулах үүрэг оруулсан байгаа. Энэ нь үндсэн зорилго нь юу вэ гэхээр зэрэг нэн хөнгөлөлттэй зээлийн санхүүжилт маань улсын төсвөөс санхүүждэг ийм тусгай зориулалттай эргэн төлөх нөхцөлтэй зээл байгаа. Ийм учраас төсвийн эрсдэлийг бууруулах зорилгоор энэ хуулийн зохицуулалтыг оруулсан гэж ойлгож болно. Албан журмын даатгал бол тухайн малчин иргэн зээл авсан, аваагүйгээс үл хамаараад заавал даатгуулах ийм хуулийн шаардлага оруулж өгдөг. Зээлийн асуудал бол сайн дурынх учраас энэ даатгалын тогтолцоо маань өөрөө албан журмын даатгалын тогтолцоо биш юм.

Д.Амарбаясгалан: Тэгэхдээ наадах чинь ямар учиртай юм бэ? Зээл авахын тулд заавал индексжүүлсэн даатгалаар даатгуулсан байх ёстой гэдэг нь. Тэр чинь тэр Банкныхаа хуулиар зохицуулагдаад явах ёстой зүйл биз дээ. Жавхлан сайд нэмэлт хариулт өгье.

Б.Жавхлан: Нэн хөнгөлөлттэй зээл гэж байгаа. Өөрөөр хэлбэл татвар төлөгчдийн мөнгөөр татаас нь болж очиж байгаа тусгай нөхцөлтэй банкны зээлд хамрагдах гэж байгаа малчин аль, аль талдаа эрсдэлээ бууруулаад даатгалд хамрагдсан байх ёстой. Банкны ч эрсдэл, төсвийн ч эрсдэл нөгөө малчны өөрийнх нь ч эрсдэл. 1 банк бусаас очоод банкнаас нэг машин авахад зээлээр машин авахад машинаа даатгуулсан байх ёстой аягүй энгийн шаардлага шүү дээ. Хамгийн энгийн анхны шаардлага. Нэн ялангуяа төсвөөс татаасыг нь өгч олгож байгаа нэн хөнгөлөлттэй зээл дээр заавал эрсдэлийг нь бууруулах ийм шаардлага орж байх ёстой. Харин банк өөрийнхөө эх үүсвэрээр өгч байгаа зээлүүд дээрээ даатгуулна уу, даатгуулахгүй байна уу тэр банк зээлдэгч хоёрын хоорондын харилцаа.

Д.Амарбаясгалан: Тэгэхээр чинь Жавхлан сайд ийм шүү дээ. Одоо индексжүүлсэн даатгалд хамрагдаж байгаа малчид байна. Ердийн даатгалд өөрийн хөрөнгийн даатгалын үйл ажиллагаа явуулж байгаа малчид байгаа шүү дээ тийм ээ. Жишээ нь энэ эрчимжсэн мал аж ахуй, хагас эрчимжсэн байгаа эд нар чинь ямар бололцоо байгаа юм бэ? Тэгэхээр чинь ер нь зүгээр хөрөнгийн даатгалд мал, эд хөрөнгөө даатгуулах боломжийг нь энэ заалт чинь орж ирээд бүр хязгаарлаад, зөвхөн индексжүүлсэн даатгал гэдэг дээр хязгаарлаад явчих юм биш биз дээ? Тэгээд ямар ч хэрэггүй жишээ нь нэг жижиг ферм ажиллуулж байгаа, бизнес хийж байгаа нөхөр аж ахуй эрхлэгч зээл авъя гээд тэгсэн чинь заавал индексжүүлсэн даатгалд хамруулах шаардлага үүсээд байдаг. Нөгөө аж ахуй эрхэлж байгаа иргэнд индексжүүлсэн даатгалд хамруулах ямар ч шаардлага байхгүй. Тэр битгий хэл тэр чинь эрчимжсэн мал, эрчимжүүлэн фермийн үйл ажиллагаа явуулж байгаа бол хөрөнгийн даатгалын асуудал яригдах ёстой шүү дээ. Өндөр үнэтэй мал, үржил угсаа нь сайжирчихсан мал маллаж байгаа иргэн

шүү дээ. Тэгэхээр тэрийг чинь үүгээрээ бүр хязгаарлаж өгөх юм биш үү? Жавхлан сайд тодруулж хариулт өгье.

Б.Жавхлан: Амарбаясгалан даргын асуултад нэмэлт мэдээлэл. Ер нь эсрэгээрээ л дээ. Төсвийн мөнгөөр олгогдож байгаа зээлийн эрсдэлийг нь бууруулж байгаа юм. Төсвийн мөнгөөр олгогдож байгаа гээд энэ нь бүр ямар ч зах хязгааргүй эрсдэлтэй, төлөгдөх ч бай, төлөгдөхгүй ч бай хамаагүй гэдэг тийм байдал руу яваад орчхож болохгүй. Нөгөө талаар малын индексжүүлсэн даатгалын хүртээмжийг нэмэгдүүлэх нэг хөшүүрэг болж байгаа гэсэн үг. Өөрөөр хэлбэл төр өөрөө нэн хөнгөлөлттэй зээл ингээд төсвийн мөнгөөр өгч байгаа бол нөгөө талдаа мөн малчдаа индексжүүлсэн даатгалд хамруулах нэг хөшүүрэг нь болно л гэсэн үг. Хэрвээ банканд нэн хөнгөлөлттэй биш, өөр банкны зээл авах гэж байгаа бол тэр хүний өөрийн сонголт нь байгаа. Ер нь манайд Монгол Улсад малын индексжүүлсэн даатгалаас өөр бэлчээрийн мал аж ахуйн даатгал огт байхгүй, нэг ч бүтээгдэхүүн байхгүй. Яагаад гэвэл маш өндөр эрсдэлтэй байдаг учраас хувийн даатгалынхан үүгээр ерөөсөө огт ордоггүй. Дандаа давхар даатгал буюу энд давхар даатгуулсан л ийм даатгалын бүтээгдэхүүнүүд байдаг учраас ингэх нь зөв гэж харж байгаа юм. Тийм.

Д.Амарбаясгалан: Наадах чинь зүгээр яах вэ энэ шинэ хоршоо, чинээлэг малчин хөтөлбөр гээд л явж байгаа зүйл дээр ингээд харахад малчид илүү малаа эрчимжүүлэх чиглэл дээр энэ авсан зээлийн бараг 70 орчим хувь нь яваад байна шүү дээ. Тэгээд энэ чинь малынхаа үүлдэр угсаагаа сайжруулаад байна гэсэн үг шүү дээ. Мал нь улам бүр үнэтэй болоод байна. Бөөнөөр нь намар нядалгаанд 1000 ширхэг хонийг 100 мянган төгрөгөөр бодоод өгдөг байсан бол одоо хагас эрчимжсэн, малынхаа үүлдэр угсааг сайжруулсан жилийн 4 улирал зах зээлд нийлүүлдэг болоод ирэхээрээ нэгж хониных нь өртөг 200, 300 мянга хүртэл өсөөд явах боломжтой буюу бизнес хийж байгаа бизнесийнх нь нэр төрлийн бүтээгдэхүүн болоод эхэлж байгаа л зүйл шүү дээ. Тэгээд яваад ирэхээр заавал нөгөө энэ чинь өөрөө ингээд төр засгаас юм уу, арилжааны банкнаас тодорхой хөнгөлөлттэй нөхцөлтэй зээлүүдэд хамрагдаад явж байгаа, тэр нь заавал индексжүүлсэн даатгал байна гээд явахаараа зүгээр миний харж байгаа өнцгөөр маш их хязгаарлалт хийгээд өгчхөж байна.

Харин ч тэр бизнес хийж байгаа хүмүүс чинь өөрсдөө эрсдэлээсээ урьдчилан сэргийлээд, тэр үхэр, хонь, адуу, ямаагаа арилжааны зориулалтаар энгийн ердийн даатгалын компанид даатгуулаад явж байдаг. Тэгсэн ч гэсэн энэ төр засгаас хэрэгжүүлж байгаа зарим төрлийн хөнгөлөлттэй зээл хөтөлбөрт хамрагдаад явж байх боломж нь нээлттэй байх хэлбэр байхгүй бол давхардчих юм биш үү л гэж ингэж харж байна. Энэ дээр энийг хэлэлцэх явцдаа энийг их тийм уян хатан жоохон амьдралд нийцүүлэхгүй бол саяын Баасанжаргал гишүүний хэлж байгаа үнэн шүү. Одоо биднээр яах вэ ингэж оруулж ирж хэлэлцүүлээд наана уу, цаана уу зөндөө олон асуудлуудыг хөндөөд, зөв, буруугаар нь яриулж байгаад ард нь гарчихдаг. Гарсан хууль маань өөрөө амьдралд очоод хэрэгжихгүй байна л гэдэг асуудал үүсэж байгаа юм.

Амьдралд хэрэгжихгүй байгаагийн нэг шалтгаан чинь энд байж байна шүү дээ. Өнгөрсөн 10 жилийн хугацаанд хэрэгжсэн индексжүүлсэн даатгал хамрагдсан байдал нь 11-ээс 18-хан хувьтай байна гэдэг чинь өөрөө амьдралд бүрэн нийцэхгүй байгааг л илэрхийлж байгаа байхгүй юу. Тэгэхээр яах вэ мэдээж энэ

чинь өөрөө хүндрэлтэй. Хөрөнгө, санхүү, нөхөн олговор гээд ингээд явахад хүндрэлтэй байдгийг ойлгож байна. Гэхдээ оновчтой болгоод өгөх юм бол энэ чинь авч байгаа хүндээ ч, даатгуулж байгаа хүндээ ч өөрөө энэ чинь үр ашгаа өгөөд явах боломжтой. Нөгөө талаасаа Үндэсний давхар даатгал мэдээж яг энэ онцлог түрүүн Жавхлан сайдын хэлдэг үнэн л дээ. Бэлчээрийн мал аж ахуйтай Монгол оронд эхний ээлжид энэ даатгалын тогтолцоог нэвтрүүлэхийн тулд индексжүүлсэн даатгалын төрлийг нэвтрүүлсэн байгаа юм.

Тэгвэл энэ чинь цаашаагаа хөгжих ёстой шүү дээ. Арилжааны зориулалтаар, бизнесийн зориулалтаар, үнэхээр эд хөрөнгөө 1 ширхэг ч хонь хорогдуулахгүй байхын төлөөх сэтгэл зүй, тэр сэтгэхүйг бий болгохын төлөөх даатгалын салбарын хөгжлийн асуудал шүү дээ. Энэ дээр энэ хувийн даатгалын байгууллагуудыг Үндэсний даатгалын корпорац өөрөө яаж давхар даатгалыг яаж авч явах юм бэ? Цаашлаад бүр гаднын давхар даатгалын компаниудыг хэрхэн яаж оруулж ирэх юм бэ? Энэ салбар чинь өөрөө яаж хөгжих юм гэдэг асуудлуудаа ярихгүй бол саяын тайлбарууд дунд чинь одоо байгаа даатгалын компаниудынхаа хүчин чадал, одоо байгаа даатгалын компаниудын хийж байгаа бизнес сонирхол гэдэг юман дээр нь тулгуурлаад бид өөрчлөлт яриад байгаа байхгүй юу. Уг нь тэр боломжийг нь төр хязгаарлах биш, нээж өгөөд, салбар нь ч хөгжөөд, иргэд нь ч хожоод явж байх тэр бололцоо руу бид энэ хуулийн өөрчлөлтөөр оруулж өгөх ёстой. Тэгж хийж чадвал энэ хууль цаашдаа амжилттай хэрэгжинэ гэж бодож байна. Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүн асуулт асууя.

Б.Бат-Эрдэнэ: Эрхэм гишүүддээ энэ өдрийн мэнд хүргэе. Энэ мал, малчин, даатгал гээд. Уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой асуудал хүндэрнэ. 2024 онд дэлхийн хамгийн дэлхийн дулааралтай жил болсон. Өөрөөр хэлбэл дэлхий дахинд олон улсын цаг уурын байгууллагаас гаргаснаар 1,5 хэмээс илүү гарч болохгүй. Илүү гарвал дулаарал явагдах хэмжээгээр байгалийн гамшиг илүү их болно. 2024 онд 1,6 хэмээр дулаарсан. Дэлхийн тавьсан түвшнээс 0,1 хэмээр илүү гарсан гэсэн үг. 2050 он хүртэл Монгол Улсын агаарын температур 2,6 хэмээр дулаарна, одоо байгаагаасаа нэмээд. 2080 он хүртэл дахиад 6,2 хэмээр дулаарна. Өвөл ордог цасны хэмжээ чинь буурна, ихэснэ, зун ордог борооны хэмжээ чинь буурна. Одоо бид энэ уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой асуудал дээр нэг талдаа малчид маань илүү их сайн анхаарах ёстой боловч нөгөө талдаа бид төр засгийн зүгээс энэ эрсдэлийг тооцоолох нь хамгийн зөв алхам болж байгаа юм. Тэгэхээр бид малчдын хувьд авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээг маш зөв зүйтэй авч хэрэгжүүлэх ёстой гэж харж байгаа.

Малын индексжүүлсэн даатгал нэмэлт, өөрчлөлт орж ирж байгаа нь маш сайн гэж харж байна. Гэхдээ бид хэлэлцэх шатдаа тодорхой хэмжээний өөрчлөлтүүдийг маш сайн хийх ёстой. 1 дүгээрт малын индексжүүлсэн даатгал яагаад өнөөдөр албан журмын даатгал шиг хэлбэрийг агуулж орж ирж байгаа юм бэ? Энийг би Байнгын хорооны хурал дээр хэлсэн. Арилжааны банк өөрийнхөө системээр л явах ёстой. Гэтэл энд нэн хөнгөлөлттэй болон хөнгөлөлттэй зээл олгох гэдэг үндсэн төрөөс өгч байгаа татаас хэлбэр дээр малын индексжүүлсэн даатгалд заавал хамруулсан байх ёстой буюу сая Жавхлан сайд өөрөө бараг хэлчихлээ л дээ. Хүртээмжийг нэмэгдүүлэх гэж байгаа юм гээд.

Байнгын хорооны хурал дээр би ч гэсэн хэлж байсан. Өнгөрсөн хугацаанд даатгагдсан хэмжээ маш бага. Одоо хуулиар далайлгаад хүртээмжийг албаар

нэмэгдүүлэх гэж байгаа юм байна л даа. Дараа нь нөгөө босго үзүүлэлтээс авхуулаад тодорхой хэмжээний өөрчлөлтүүдийг хийгээд эхлэхээр нөгөө жолоочийн даатгал шиг асуудал үүсэх вий. Энэ том асуудал болгоомжлол орж ирж байгаа юм. Энийг албан журмын даатгал огт болгож болохгүй.

2 дугаарт энэ дээр нэг ийм юм ороод ирчихсэн байгаа юм 7.2 дээр өөрчлөлт дээр. Малын индексжүүлсэн даатгалтай холбоотой асуудал дээр, алив хуулийн өөрчлөлтийг би гаргаад ирье. 4.1.9 давхар даатгалын компани гэж энэ хуулийн 18.1-д заасан давхар даатгалын үйл ажиллагаа эрхлэн явуулах тусгайлсан чиг үүрэг бүхий хуулийн этгээдийг зааж өгч байгаа юм. Тэгээд давхар Засгийн газраас авч байгаа одоо байгаа 7.2 буюу хууль дээр зөвхөн Засгийн газар сумаар нь тогтоож өгдөг байсан бол энэ дээр давхар даатгалын компанийн оруулж ирсэн саналыг үндэслээд Засгийн газар тогтоох хэлбэр лүү оруулж ирж байгаа юм. 7.1 буюу даатгалын тохиолдлыг тодорхойлох эрсдэлийг хуваарилах зорилгоор босго үзүүлэлтийг дараах байдлаар Засгийн газар сум бүрээр тогтооно гэдэг ийм заалттай.

Гэтэл одоогийн орж ирж байгаа та хэдийн оруулж ирж байгаа энэ өөрчлөлт дээр өөрсдийнхөө давхар даатгалын компанийн саналыг харгалзаж үзэхээр тогтоолыг оруулж ирж байгаа юм. Энэ хуулийн 7.1-д заасан босго үзүүлэлтийг энэ хуулийн 18.1-д заасан давхар даатгалын компанийн саналыг харгалзан тогтооно гээд. Тэгэхээр энэ юу харагдаж байна гэхээр нөгөө давхар даатгалын компани маань өөрийнхөө чадамжийг нэмэгдүүлэх процессын 1 дүгээрт, 2 дугаарт заавал малын индексжүүлсэн даатгалд малчид даатгуулдаг энэ системийг оруулж ирээд байгаа юм л даа.

Дараагийнх нь хувьцаатай холбоотой асуудал. 1 минутаа нэмээд авчихъя даргаа. Хувьцаатай холбоотой асуудал. 2023 оны 3 сарын 31-ний өдөр СЗХ-ноос анхдагч зах зээлд хувьцаагаа гаргах зөвшөөрлийг олгосон. Энэ бол хувьцаат компани байх ёстой. 2022 оны 244 дүгээр Засгийн газрын тогтоолоор ХК болгож өөрчлөх шийдвэр гарсан. Гэтэл өнөөдөр хувьцаат хэлбэр лүүгээ одоог хүртэл шилжээгүй явж байгаа юм. Яагаад? Энэ дээр бид зайлшгүй хариулт авах ёстой байгаа.

3 дугаар асуулт отор. Яах вэ сум бүрээр ингээд тооцчихож байгаа юм байна. Отроор явж байгаа малчдын асуудлыг бид яаж шийдвэрлэх вэ? Өнөөдөр бид отроор явж байгаа малчдыг даатгалд хамруулах юм уу, хамруулахгүй юм уу? Давхар даатгалын компанитай би уулзсан. Байнгын хороон дээр асууж байхад давхар даатгалын компани цаашаа дахиад олон улсын даатгалын компанид давхар даатгалтай. Давхар, давхар даатгалын асуудал яригдаж байгаа юм. Тэгээд уур амьсгалын өөрчлөлт ийм их хэмжээтэй явагдаж байгаа энэ цаг хугацаанд бид энэ даатгалын асуудлыг маш зөв зүйтэй олж харахгүй бол болохгүй. Тэгээд асуултууддаа хариулт аваад, нэмж тодруулъя. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Энэ тийм тэгээд албан журмын даатгал шиг индексжүүлсэн даатгалд нийтээр хамрагддаг байх нөхцөл рүү шахах гэдэг байж болохгүй зүйл л дээ. Ер нь даатгал сайн дурынх л байх ёстой шүү дээ. Хариулт өгье. Ажлын хэсгийн 20 дугаар микрофон.

Б.Жавхлант: Үндэсний давхар даатгал ХК-ийн гүйцэтгэх захирал Жавхлант. Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариульъя. Уур амьсгалын өөрчлөлттэй холбоотойгоор энэ байгаль цаг уурын эрсдэлт нөхцөл байдал, ялангуяа гамшгийн давтамж, зудын давтамж, ялангуяа өвлийн хур тунадасны хэмжээ жилээс жилд өндөр хэмжээгээр нэмэгдэх ийм тооцоолол, урьдчилсан тооцоолол гарч ирж байгаа. Ийм учраас бид цас зудын нөхцөл байдалтай ер нь ойр ойрхон нүүр тулах нь тодорхой болж байгаа юм. Яг энэ үед бид нарын ЗГ-аас олгогдож байгаа нэн хөнгөлөлттэй зээл тусламж буюу энэ төсвөөс санхүүждэг төсвийн санхүү, татвар төлөгчдийн эх үүсвэрээс төлөгддөг зээлийн эх үүсвэртэй энэ нэн хөнгөлөлттэй зээлийн эргэн төлөгдөх нөхцөл байдлыг баталгаажуулах асуудал тэргүүн ээлжид тавигдах учиртай гэж харж байгаа.

Тийм болохоор зэрэг 2 жил дараалаад манай улсын хэмжээнд малын гарз хохирол нэлээн өндөр гарчихлаа. 25 онд ч гэсэндээ баруун бүс нутгаар өвөлжилт нэлээн хүндэрчихсэн явж байна. Тэгэхээр зэрэг 3 жил дараалаад ингээд малын хорогдол өндөр болоод ирэх нөхцөлд зээлийн эргэн төлөх эх үүсвэрийн баталгаа болсон мал сүргийн бүрэн бүтэн байдалтай холбоотойгоор энэ зээл маань эргэн төлөгдөхөд хүндрэлтэй байдал үүсэх ийм нөхцөл байдал бай гарч болзошгүй гэсэн ийм дүр зураг харагдаж байгаа.

2 дугаарт нь энэ даатгалын босго үзүүлэлтийг хуульд заасан 4 үндэслэл байж байгаа. 4 үндэслэлийг харгалзаж тогтоодог. Энэ хуульд байж байгаа энэ 4 үндэслэл даатгуулагчдын тоо, сумын малын хорогдлын хэмжээ, даатгалын нөхөн төлбөрийн хэмжээ, даатгалын хураамжийн орлогын хэмжээ гэсэн актуар шинжлэх ухааны 4 суурь тоон тооцоололд үндэслэж, босго үзүүлэлтийн хэмжээ дээш, доошоо хөдлөх энэ боломж бүрддэг. Одоо ч яг одоо явж байгаа систем маань ч гэсэн яг энэ 4 үндэслэл дээрээ тулгуурлаад, Засгийн газар 3 жил тутам тогтоодог ийм тогтолцоотой явж байгаа.

Хувьцааны, хувьцаат компанийн асуудлын хувьд болохоор зэрэг Монгол Улсын ЗГ-аас Үндэсний давхар даатгал ХК-ийн хувьцаа гаргах хугацааг хойшлуулсан ийм тогтоол гарсан байгаа. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Пүрэвжавын Ганзориг гишүүн асуулт асууя.

П.Ганзориг: Манай Монгол Улсын гол салбар болсон энэ хөдөө аж ахуйн салбар тэр тусмаа 200 мянган малчин өрхийн амьжиргаа болсон малыг эрсдэлээс хамгаалах энэ чухал механизм тогтолцоог бүрдүүлж байгаа энэ Малын даатгалын тухай хуультай холбоотой 2 чухал заалт орж ирж байна. Тэгээд энийг гишүүд маань нэлээн ач холбогдол өгч харж саналуудаа хэлээд ингээд явбал зүгээр байх гэж бодож байна.

Тухайлбал энэ хууль дээр 2 чухал малчдын эрх ашгийг хамгаалсан заалт байна гэж харж байна. Нэгд энэ босго үзүүлэлтийг 6 хувь гээд хатуу тогтоочихоор нийт малчид нөхөн төлбөр хамрагдаж чадахгүй байна. Тэгэхээр энэ хамрагдалтыг нэмэгдүүлж, даатгалын нөхөн төлбөрийн хүртээмжийг нэмэгдүүлэхийн тулд босго үзүүлэлтийг газар нутгийн онцлог, эрсдэлд тулгуурлаад өөрчилье гэж байгаа юм байна. Энэ зөв. Тэгээд энийгээ яг нарийн тооцож гаргахдаа тодорхой хязгааруудаа яаж харж байгаа вэ? 6 дээр +, - 1 байсан бол хэд болж өөрчлөгдөх вэ? Ер нь та

нарын төсөөллөөр. Ингээд сул чөлөөтэй хаячихаар эсрэгээрээ босгоо өсгөөд байх зарим газар ийм эрсдэл байгаа. Тэгэхээр энэ дээр ямар тооцоолол байгаа вэ?

2-т энэ босго үзүүлэлт өөрчлөгдөж малчид даатгалд илүү хамрагдах нөхцөл бүрдсэнээр хэдэн хувиар нэмэгдэнэ гэж та нар судалж байгаа вэ? Ер нь энэ эрсдэлээс хамгаалах чухал механизм энэ даатгалын тогтолцоо бол энэ халамжийн ялангуяа энэ хөдөө аж ахуйн салбарт халамжийн тогтолцооноос гаргаж, өөрсдийнх нь эрсдэлийг өөрсдөөр нь үнэлүүлж, энэ даатгалд хамрагддаг энэ тогтолцоо руу шилжүүлэх гэж байгаа нэг арга л даа. Тийм болохоор бид ниргэсэн хойно нь хашхираад суудаг биш, өөрсдөө эрсдэлээ даатгуулаад, тэрийгээ энэ яг энэ орчин үеийн даатгалын механизмаараа нөхөн төлбөрөө аваад явдаг ийм тогтолцоог бүрдүүлэх ёстой.

2-т энэ урьдчилж нөхөн төлбөр олгох гэж байгаа зохицуулалт орсон байна. Одоо бол 10 сард, тухайн жилийн 10 сард нөхөн төлбөр авч байгаа. Тэгвэл 6 сарын өмнө, 7 сарын өмнө ингээд нөхөн төлбөр авах юм байна. Ингэснээрээ нэмж гарах хохирлын хэр хэмжээгээр хамгаална гэж та нар тооцож байгаа вэ? Тухайлбал яг зуд турхантай хүндэрчихсэн үед нөхөн төлбөрийг нь түрүүлээд өгчихөөр дараагийн нэмж гарах эрсдэлүүдээсээ тэр тухайн нөхөн төлбөр санхүүжилтээрээ өөрсдөө хамгаалаад явах ийм боломж бүрдэнэ гэж та бүхэн үзэж, энийг оруулсан байна лээ үндэслэл дээрээ. Тэгэхээр энэ нь хэр хэмжээний нэмэлт хохирлоос хамгаална гэж тооцож байгаа вэ?

3-д ер нь энэ манай улсын энэ гамшгийн эрсдэлийг сөрөн тэсвэрлэх чадвар 40 хувьтай гээд судалгаагаар гараад ирсэн. Тэгэхээр энийг нэмэгдүүлдэг нэг чухал юм нь энэ даатгалын тогтолцоонууд байж байгаа юм. Тэгэхээр өнгөрсөн жил улсын хэмжээнд 8,2 сая толгой мал хоргодоод, 1.5, 6 их наяд хохирол учирсан. Гэтэл бид энэ даатгалаараа 20-хон тэрбумыг олгож чадаж байгаа юм. Энэ нь ерөөсөө нэгхэн хувь нийт хохирлын. Энийг нэмэгдүүлэх энэ давхар даатгалын үндэсний тогтолцоог бэхжүүлэх, бүр цаашлаад энэ олон улсын давхар даатгалд тодорхой хэсгүүдийг нь ингээд даатгуулж явдаг байх энэ дээр ямар бодлоготой байгаа вэ? Одоо бол энэ Францын Скор гээд давхар даатгалын компанитай даатгуулаад явж байгаа юм байна. Энэ давхар даатгалын компанид хэдий хэмжээний төлбөр төлөөд, эргээд хэдий хэмжээний нөхөн төлбөр авсан бэ? Ер нь цаашдаа энэ малчин өрхийг гол амьжиргаа болсон малыг эрсдэлээс хамгаалахын тулд хэдий хэмжээний өөрсдийнх нь сайн дураар хамгийн багадаа өрх бүрийг л уг нь даатгалд хамруулдаг сайн дураар нь болгочихвол амар байгаа юм. Сайн байгаа юм. Тэгээд малчин, мал сүргийнх нь тодорхой хувийг хамруулаад явъя гэсэн зорилт танай энэ Үндэсний давхар даатгалын компанид байгаа вэ гээд ийм 3 асуултыг асууя.

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Ажлын хэсгийн 20 дугаар микрофон.

Б.Жавхлант: Үндэсний давхар даатгал ХК-ийн гүйцэтгэх захирал Жавхлант. Ганзориг гишүүний асуултад хариулъя. Одоогийн байдлаар босго үзүүлэлтийг дээш, доош нь хөдөлгөх, дээд, доод интервалын түвшнийг энэ хуулийн түвшнээр хязгаарлаагүй байж байгаа. Яг өнөөдрийн байдлаар бид нарын хувьд Үндэсний давхар даатгал ХК болон даатгалын компаниудын дунд хийгдсэн судалгаагаар сумын босго үзүүлэлтийг 4 хүртэл хувь хэмжээнд бууруулах боломжтой сумдын жагсаалт гарсан байгаа. Тэгэхээр өөрөөр хэлбэл одоо бид

нарт байж байгаа судалгаагаар 4 хүртэл хувийн хэмжээнд буурах боломжтой ийм сумдын жагсаалт гарсан байдаг юм.

Энэ хуулийн өөрчлөлт ялангуяа энэ босго үзүүлэлтийг бууруулаад, 2 дугаарт нь эрт санхүүжилт буюу эрт нөхөн төлбөрийг олгож эхэлснээрээ малын энэ төсвийн даатгалын хамрагдалт хэрхэн нэмэгдэх вэ гэдэг энэ тооцоо судалгааг өнгөрсөн хугацаанд хийсэн. Малчидтай хийсэн нүүр тулсан уулзалтууд болоод, сүүлд хийсэн малчдын зөвлөгөөнөөс авсан тоон мэдээ зэргээс аваад үзэхэд хамгийн багадаа 15-аас 20 хувиар өсөх боломжтой байна гэсэн ийм тооцоолол харагддаг.

3 дугаарт нь урьдчилж олгосон нөхөн төлбөр буюу эрт санхүүжилтийг олгосноороо энэ малчдад яг даатгалын ач холбогдлыг тухайн цаг үед ойлгох, тухайн үр ашгийг нь хүртэж, ингэж хүртсэнээрээ нөгөө даатгуулагч маань илүү ач холбогдолтыг нь ойлгож, илүү хамрагдалт маань нэмэгдэх хөшүүрэг болох болов уу гэсэн хүлээлттэй байгаа. НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын гаргасан судалгаагаар эрт санхүүжилтийн үед олгосон 1 төгрөгийн зардал гамшгийн сан, гамшгийн эрсдэлийн дараах 7 төгрөгийн зардалтай тэнцүү байна гэсэн ийм судалгааг гаргасан байгаа. Өөрөөр хэлбэл бид бүхэн урьдчилж нөхөн төлбөр олгосноороо бид дараа нь гарах 7 төгрөгийн эрсдэлийг 1 төгрөгөөр хаах боломжийг бүрдүүлж байна гэж, бүрдүүлэх юм гэсэн ийм хүлээлттэй байгаа.

Түүний дараачийн асуудал нь болохоор зэрэг урьдчилж олгох энэ тогтолцоотой холбоотойгоор малын индекс нь энэ малын, том малын зүй бус хоригдол жилийн 1-ээс 2 дугаар сард нийт тухайн жилийн малын өргөдлийн 70-аас 80 хувь нь гардаг юм байна. Тийм учраас зэрэг тухайн цаг үе тухайн жилийнхээ өвөлжилтийн хамгийн өндөр хохиролтой цикл байгаа учраас тухайн үед нь нөхөн төлбөрийг урьдчилж тооцох хамгийн оновчтой цаг хугацаа гэж харж байгаа. Олон улсын давхар даатгалд Үндэсний давхар даатгал ХК болоод даатгалын 7 компанидаа хамтын эрсдэлийн сангаар даатгуулдаг. Өнгөрсөн хугацаанд 6,9 тэрбум төгрөгийн хураамжийг олон улсын давхар даатгалд төлөөд, эргүүлээд 12 тэрбум төгрөгийн нөхөн төлбөрийг олон улсын давхар даатгалын компаниудаас авсан байх ийм байгаа статистик тоон мэдээлэлтэй байна. Үүнээс харвал ерөнхийдөө.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Гүйцээж хариулъя. Ингээд харахаар зэрэг ерөнхийдөө олон улсын давхар даатгалын түвшинд болон үндэсний давхар даатгалын түвшиндээ гамшгийн эрсдэлийн даатгалынхаа тогтолцоог хамтран хэрэгжүүлж байгаа энэ тогтолцоо маань түвшин түвшинд эрсдэлийнхээ түвшин болгонд хэрэгжээд явж байна гэсэн ийм дүгнэлтийг мэргэжлийн салбарын оролцогчид дүгнэдэг юм. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Ренчинбямбын, Ганзориг гишүүн, Пүрэвжавын Ганзориг гишүүн тодруулж асууна.

П.Ганзориг: Энэ босгыг мэдээж хэлэлцүүлгийн явцад их сайн зохицуулж зааж явахгүй бол хэтэрхий чөлөөтэй орхичихдог, тэгээд давхар даатгалын Үндэсний давхар даатгалын компанийн саналаар ингээд тогтоогоод явчихаар эргээд дээд босго дээшээ яваад, эрх ашиг нь зөрчигдөх асуудлууд гарч магадгүй. Энийг хэлэлцүүлгийн явцдаа зохицуулаад явж болох байх гэж бодож байна.

2-т нэн хөнгөлөлттэй зээл авч байгаа дээр хуульд ингэж оруулахгүйгээр энэ зээлийнх нь журамд оруулаад явах боломж байгаа. Энийг харах ёстой байх. Ипотекийн зээл авахад орон сууцаа заавал даатгуулж байгаа шүү дээ. Тэгэхдээ журмаар явж байгаа. Тэгэхгүй бол иргэдэд, олон нийтэд буруу ойлголт өгөөд байх шиг байна. Ер нь яах вэ заавал даатгал бол биш л дээ. Энэ заавал даатгал тусдаа бие даасан хуультай байдаг. Энэ бол зээлтэй холбоотой ингээд зохицуулалт болгоод оруулж байгаа юм байна. Тэгэхээр иймэрхүү маягаар явуулах бололцоо байгаа юу гэдгийг тодруулж асууя. Тэгээд энийг.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Шадар сайд Амарсайхан тодруулж хариулъя, нэмэлт хариулт өгье.

С.Амарсайхан: Ганзориг гишүүний ярьж байгаад олон асуудлууд санал нийлж байгаа. Ер нь зүгээр яах вэ бид ингээд шинэ хоршоо хөдөлгөөн гэдэг юм уу нэн хөнгөлөлттэй зээл олгож байгаа. Жишээ нь 21 хувийн зээл хүүтэй зээл авдаг байсан бол 6 хувийн хүүтэй болгож үлдсэн 15 хувийг нь ЗГ-аас төрөөс даадаг болсон энэ тохиолдолд болсон нөгөө талдаа эрсдэлийг хамгаалах даатгалын тогтолцоо маш чухал гэдэг агуулгаар манай энэ даатгалын байгууллагынхан яриад байх шиг байна. Гэхдээ энэ нэгэнт бид энэ индексжүүлсэн ч бай, үгүй ч бай энэ даатгалын хууль, эрх зүйн орчныг ярьж байгаа тохиолдолд нэг мөр энэ асуудлыг цогцоор нь шийдвэрлэх ёстой. Энэ дотроо зөвхөн индексжилт гэлтгүйгээр хэлэлцүүлгийн явцад бол, жишээ нь малын, мал аж ахуйн шууд үнэлгээний тогтолцоог 1 дүгээрт бүрдүүлэх ямар хувилбар байгаа юм. 2 дугаарт бэлчээрийн даатгал, орлогын даатгал.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Гүйцээж хариулъя.

С.Амарсайхан: Ер нь энэ хууль хэлэлцэх явцад бид нэг мөр шийдмээр байгаа юм. Өөрөөр хэлбэл заавал индексжүүлсэн гээд жилийн хугацаанд тулгаад байхгүйгээр улирлын байж болохоор, гамшгийн уян байж болохоор, орлогын даатгал, орлого хамгаалах даатгал байж болохоор. Өөрөөр хэлбэл орлого нь буурвал яах юм. Бэлчээрийн даатгал байх, малын эрүүл мэндийн даатгалын гэдэг юм уу гэх мэтээр ингэж ангилж ялгаад заавал өвлийн, бүтэн жилийн турш биш, тухайн гамшиг эрсдэлтэй өвлийн турш эсвэл бэлчээрийн хамгаалалт, нэг бол малын эрүүл мэндийнхэн бол малын өвчин, үржил хорогдлын үед хохирлоо барагдуулдаг. Бэлчээрийн доройтлын үед яах юм, бэлчээрийн гарц ургамал муутай, зуншлага тааруу болсон газар орон нутагт нь тухайн үедээ хамрагддаг байх ч гэдэг юм уу малчдад бид илүү боломжийг нь сонголттой нь олгоод, тэгээд эргээд хамгийн гол нь даатгагчид даатгалаа авч чадахгүй.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Ренчинбямбын Сэддорж гишүүн асуулт асууя.

Р.Сэддорж: Анх энэ хуулийг Норовын Алтанхуяг сайд гаргаж ирж байсан. Зорилго нь энэ 5-аас 6 хувийн хүртэлхийг малчин өөрөө, 30 хүртэлх хувийг компани, 30-аас дээш улсаас хариуцна гэж. Дээр нь 10 жилийн зайтай нэмэлт, өөрчлөлт орж байгаа ийм хууль байна. 2014 онд нэмэлт, өөрчлөлт орсон. Ингээд энэ зудын давтамж 10 жилийн зайтай яваад байна. Өнгөрсөн онд 10 сая мал хорогдсон, 6,2 тэрбум төгрөгийн хохирлыг малчдад олгосон. Малчид өөрсдөө 3 тэрбум төгрөг төвлөрүүлсэн гэж байгаа.

Миний энэ санал байгаа. 6, 30 гэсэн энэ хувийг байхгүй болгож байгаа ч энэ давхар даатгалын компанийн саналыг харгалзан тогтоохоор хуульчилж байгаа нь хүний үзэмж орох магадлал өндөр байна. Энэ дээр нэг журам гарч таарна. Тэгээд зарчмын хувьд компани үнэлгээгээ тогтоож байгаа бол улс оролцохгүй байх боломжтой. Тэгээд хамгийн гол зүйл малчин хүн даатгуулсан л бол бодит хохирлоо авах эрхтэй. Ер нь нэг даатгал төлөөд тийм бага хэмжээний хохирлыг төлүүлээд, энэ нэг л болж өгөхгүй л байгаа ийм хууль. Ийм учраас энэ нэмэлт, өөрчлөлт оруулж байгаа дээрээ нэг бодитой болгоод, энэ малчид, энэ даатгалын компани эд нар нэг ялангуяа малчид бол энэ дээр сэтгэл ханамжгүй байдаг юм. Ийм учраас энэ саналыг онцгойлон тусгаж оруулж өгөхийг хүсье.

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Ажлын хэсгийн 20 дугаар микрофон.

Б.Жавхлант: Үндэсний давхар даатгал ХК-ийн гүйцэтгэх захирал Жавхлант. Сэддорж гишүүний асуултад хариульъя. Хэлэлцүүлгийн түвшинд таны дэвшүүлсэн саналуудыг хэлэлцүүлгийн түвшинд ярилцаад явах боломжтой. Ялангуяа энэ малчдын энэ даатгалд хамрагдах үндсэн үзүүлэлт болсон босго үзүүлэлтийг хэрхэн тогтоох вэ гэдэг тал дээр хэлэлцүүлгийн түвшин сайжруулаад явах боломжтой гэж харж байгаа. Үндсэндээ бид нарын хийж байгаа энэ тооцоолол 6 хувь гэдэг нь босго үзүүлэлтийг л уян хатан болгохыг зорьж байгаа. 2 дугаарт нь хуульд заагдчихсан байж байгаа 4 суурь үндсэн чухал үзүүлэлт маань хөдлөөгүй байгаа учраас энэ нь даатгалын актуар тооцоолол дээр тулгуурлаад энэ босго үзүүлэлт маань тогтоогдож явах ийм учиртай. Ийм үндсэн ойлголт ухагдахуун байгаа.

2 дахь нь болохоор зэрэг энэ мал, малын, малчны хотонд гарсан хохирлоор нөхөн төлбөрийг олгох асуудал яригддаг. Энэ бол үндсэндээ уламжлалт даатгалын тогтолцоо гэж ойлгогддог, уламжлалт малын тогтолцоо маань сүүлийн 91 оноос хойш энэ даатгалын тогтолцоо огт хэрэгжээгүй учраас 2006 оноос энэ малын индексийн даатгалын тогтолцоог л шинээр оруулж ирсэн ийм өмнөх түүхтэй юм. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Жигжидийн Батжаргал гишүүн асуулт асууя.

Ж.Батжаргал: Баярлалаа. Тэгэхээр Малын индексжүүлсэн даатгалын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл орж ирж байгаа юм. Үзэл баримтлалынх нь хувьд хэлэлцэхийг нь дэмжчихмээр байна. Тэгээд чуулганы завсарлагаагаар гишүүд тойрогт ажиллахдаа энэ хууль ер нь энэ нэмэлт, өөрчлөлтийн талаар иргэдэд их олон талаас нь зөв мэдээлэл өгч, тэдний санал бодлыг авч, нэлээн өргөн хүрээтэй, бодитой хэлэлцүүлэг хийгээд, тэгээд дараагийн хэлэлцүүлгүүд явах нь зөв юм байна гэж. Тэгэхдээ энэ чинь шинэчилсэн найруулга биш нэмэлт, өөрчлөлт учраас бодит амьдралаас гарч ирж байгаа асуудлуудыг хуулийн төсөлд оруульъя гэхээр хөндөгдөөгүй гэдэг үүднээс ярьж чадахгүй болчих нь. Тийм учраас магадгүй би Их Хурлын гишүүдийг хуулийн төсөл санаачилж оруулж ирээд, тэгээд хамтатгаад хэлэлцээд явбал амьдралдаа нийцсэн хуулийн шинэчлэл болж магадгүй гэж энэ талаас нь би хараад байна. Ингэх нь ч бараг зөв байх гэж.

Одоо орж ирчхээд байгаа хуулийн төсөл дээр хорогдлынхоо босгыг уян хатан болгоно гээд тоогүй болгож, хувьгүй болгож байгаа нэг. 2 дугаарт гарсан хохирлыг бүр гүйцэтгэлийн тооллого тайлангаар биш явцын мэдээлэл дээр тулгуурлаад хэсэгчилж олгох тухай ийм л 2 асуудал хөндөөд байгаа юм. Тэгэхээр тэр босго үзүүлэлт юмыг тогтооход яах аргагүй энэ Монгол Улсын өргөн уудам нутаг дэвсгэрийг мужлах шаардлагатай болчихоод байна. Тэгэхээр тэр тухайн мужид байгаа сум орон нутгуудад ямар босго байх юм гэдгийг харгалзах ёстой, энэ илүү үнэнд ойрхон болно гэж. Дээр нь хэрвээ бид бодитой юм тогтооё гээд байгаа бол дан ганц даатгалын санал баймгүй байна л даа. Онцгой комиссынхоо саналыг давхар авч ярьдаг байх ёстой. Ингэх бололцоо боломж та нарт ер нь байна уу, юу гэж ойлгоцгоогоод байна вэ гэж? Нэг ийм зүйл байна гэж.

2 дугаарт энэ даатгалын хууль хэрэгжээд 11 жил шахуу болчихож байгаа юм. Тэгээд энэ хугацаанд бид 37 тэрбум төгрөгийн хураамж төвлөрүүлээд, 29,4 тэрбум төгрөгийн нөхөн олговор олгоод, нийт хамрагдах ёстой малчдынх нь 16 хувь хамрагдаад, малын 9-хөн хувь хамрагдсан. Тэгэхээр энэ хууль угаасаа амьдралд нийцэхгүй, даатгуулагчдынхаа сонирхлыг, эрх ашгийг хангаж чадахгүй байгаа хууль юм байна гэдэг нь тов тодорхой харагдаж байгаа зүйл. Тийм учраас энийг өөрчлөхөөс өөр арга байхгүй. Тэгэхээр үнэхээрийн уур амьсгал өөрчлөгдөөд, байгалийн давагдашгүй хүчин зүйлүүдийн давтамж нэмэгдээд байгаа, дээр нь бид өөрсдөө байгалийн нэн хараат бэлчээрийн мал аж ахуй дээр тулгуурласан улс орны хувьд яах аргагүй энэ байгалийн гамшигт үзэгдлээс урьдчилан сэргийлэх бэлтгэл, бэлэн байдлаа хамгаалах, эрсдэл үүссэн тохиолдолд эрсдэлийг хуваалцдаг тэр системээ бий болгох ёстой юм. Тийм учраас энэ даатгалынхаа, давхар даатгалынхаа тогтолцоог илүү баттай, чадамжтай болгох тухай асуудал, малчдаа илүү өргөн хүрээтэй хамруулах нөхцөлийг нь, сонирхлыг нь бий болгох ёстой асуудал. Өнгөрсөн жилийн Сүхбаатар, Дорнод, Хэнтийд болсон үйл явдал 11 сард бидэнд тодорхой болсон шүү дээ. Тэгвэл заавал малын хорогдол харалгүйгээр ийм нөхцөл байдал үүсчихлээ. Энэний үйл явцаар ер нь өдий хэмжээний мал хорогдох юм байна. Бид даатгалын нөхөн төлбөрт ийм юм өгөх юм байна гэж хараад, эрсдэлийг бууруулах үүднээс тэр бүс нутаг руу тэр даатгуулагдсан малчид руу эрсдэлээ бууруул гээд тодорхой хэмжээний дэмжлэг.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Нэмэлт минут өгье Батжаргал гишүүнд.

Ж.Батжаргал: Илүү зохилтой юм шиг. 10 хэдэн тэрбум төгрөгийн хохирол өгсөн тухай яриад байгаа юм. Үгүй ээ яагаад 8-ыг нь урьдчилаад өгөөд, малаа ангилаад зах зээлд мах бэлтгэх тухай асуудал, отор нүүдэл хийх тухай асуудал, өвс тэжээлийнхээ нөөцийг нэмж бүрдүүлээд үлдсэн малаа хорогдуулахгүй байх асуудал руу нь даатгалын байгууллага анхаарч болдоггүй юм бэ? Нэгэнтээ гарах гээд байгаа мөнгө чинь тодорхой, тэрнийхээ 40, 50 хувийг тэр сайн үйл ажиллагааг нь дэмжээд өгч болохгүй юм бэ? Үүнийг хэдүүлээ эрх зүйн талаас нь судалж үзье л дээ. Тэгж байж энэ нэлээн би зохистой явах болов уу гэж. Дээр нь хохирол аваагүй даатгуулагчдыг 5 жил, 10 жилийн үечлэлээр хураамжийнх нь хувь хэмжээг тодорхойгоор бууруулдаг ч гэдэг юм уу, эсхүл тэр сайн үйл ажиллагаа, эрсдэлийг давах чадамж бий болгож байгаа үйл ажиллагааг нь урамшуулж дэмжсэн тодорхой хөрөнгийн хуваарилалт ч гэдэг юм уу ийм зүйлүүдийг энэ хуульд тусгаж байж л бид сая үндэсний.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Батжаргал гишүүний энэ хөндөж байгаа маш чухал зүйл шүү. Зуд боллоо дараа нь яах вэ малчид орлогоо алдсан учраас гээд ямар нэгэн төрлийн халамж тэтгэмж өгөхөөс өөр сонголтыг төрд үлдээдэггүй. Яг энэ даатгал өөрөө хөгжөөд, үнэхээр эд хөрөнгөөрөө хохироод, орлогоо алдаж байгаа тэр нөхцөл тохиолдолд энэ даатгалын байгууллага тэр нөхөн төлбөрийг нь олгож чаддаг тийм итгэл үнэмшилтэй, тийм өндөр сонирхолтой байлгах өөрчлөлтийг л бид энэ хуулийн өөрчлөлтөөр хийж өгч чадах ёстой. Сүүлийн өнгөрсөн жилийн ганцхан 24 оны зудыг яриад байгаа юм. 23-аас 24 онд шилжих зудын үеийн 8,5 сая орчим толгой мал, 22-оос 23 онд шилжих жилийн 3 орчим сая толгой малын хоригдол, нийт дүнгээрээ зах зээлийн ханшаар бодох юм бол 2 их наяд төгрөгийн малын хорогдлын асуудал яригдаж байгаа юм.

Тэгэхээр энэ даатгалын тогтолцоо нь 10 жилийн хугацаа дахь 30 гаруйхан тэрбум төгрөгийн асуудал яриад сууж байгаа. Тэгэхээр энэ өөрөө ямар их тийм хол ялгаатай амьдралаас хол, ард иргэд, малчдын хэрэгцээг огт хангахгүй байгаа гэдэг дүгнэлтийг зүгээр л энэ дүнгээс хараад хийчхэж болж байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ хуулийг хэлэлцүүлэх гэж оруулж ирж байгаа Жавхлан сайдын санаачилга маш зөв байна. Харин Улсын Их Хурал энэ хуулийн төслийг хэлэлцэх эсэхээ шийдээд, маш өргөн хүрээний ажлын хэсгийг байгуулаад, энэ намрын чуулганы завсарлагаагаар гишүүд яг хөдөө орон нутгаар явж малчны хотонд очиж бодит нөхцөл байдалтай нь танилцаж, энэ хуулийн нэмэлт, өөрчлөлтийг амьдралд нийцүүлэх хэлбэрээр хийж авах ёстой. Энийг хийж авч чадахгүйгээс л жил болгон өвлийн, хаврын хүндрэлийн дараа төсвөөс татаас өгнө, тэтгэмж олгоно, зээлийн хүү тэглэнэ гээд янз янзын улс төрийн поп сэдвүүд гарч ирж асуудал шийдвэрлэх тэр зам руу орчихдог.

Тэгэхээр энийг бид боломж болгож Улсын Их Хурал ашиглая. Өнөөдөр Улсын Их Хурлын гишүүддээ хандаж хэлэхэд энэ асуудлыг олон талаас нь сайхан ярилцаад, хэлэлцэх эсэхийг дэмжчих нь зүйтэй. Эргээд харин энэ намрын, намар, хаврын чуулганы завсарлагааны хугацаанд маш өргөн хүрээний хэлэлцүүлгийг хийгээд, яг орон нутагт хөдөө мал дээр, газар нутгаа харж хамгаалан суугаа малчдынхаа хохирлыг, нөхөн олговрыг зах зээлийн зарчмаар шийддэг болох энэ өөрчлөлтийн төлөө хэдүүлээ хамтдаа хичээх нь зөв гэж ингэж бодож байна. Батжаргал гишүүний асуултад нэмэлт хариулт, тодруулж хариулт өгье. Ажлын хэсгийн 20 дугаар микрофон, Үндэсний давхар даатгал.

Б.Жавхлант: Үндэсний давхар даатгал ХК гүйцэтгэх захирал Жавхлант. Батжаргал гишүүний асуултад хариулъя. 1 дүгээрт нь эрсдэлийг мужлах асуудал яригдаж байна. Эрсдэлийн мужлалын хувьд одоо шинээр энэ босго үзүүлэлтийг уян хатан тогтоодог болсноороо сум болгонд ялгавартайгаар энэ босго үзүүлэлтүүд ялгавартайгаар тогтоогдож ирнэ. Өөрөөр хэлбэл өвөлжилт хүндэрдэггүй өнөтэй өвөлждөг ийм сумд нэлээн хэдэн сумд байдаг. Эдгээртэй бага хэмжээний босго үзүүлэлт тогтоогддог. Харин эсрэгээрээ энэ цаг уурын, уур амьсгалын өөрчлөлт нь байнга нэрвэгддэг хэсгүүд дээрээ босго үзүүлэлт маань өөр илүү хэмжээгээр тогтоогддог. Өөрөөр хэлбэл яг энэ эрсдэлийн мужлалынхаа дагуу энэ зураглалууд гарч ирэх ийм боломж бүрдэнэ гэж харж байгаа.

Босго үзүүлэлтийг өөрчлөх дээр түрүүний Батжаргал гишүүний хэлж байгаа Онцгой комисс, улсын онцгой комиссын үүрэг болон онцгой байдлын албаны үүрэг мөн Ус, цаг уур, орчны шинжилгээний хүрээлэн болоод статистикийн

байгууллагын төлөөлөл зайлшгүй орж ажиллах ийм шаардлага үүсэж байгаа. Энэ бол ажлын хэсгийн үед манай ажлын хэсэг дээр орж ажиллацгаах ажиллах юм. 11, одоо шинжлэх ухааны ололтод тулгуурлаад хойд туйлын уур амьсгалын өөрчлөлт болон хүйтэн уур амьсгалын индекс зэрэгтэй уялдуулаад мал, өвөлжилтийн байдлыг урьдчилан тооцоолох ийм боломж бололцоо бол шинжлэх ухааны түвшинд бий болсон байгаа. Үүнтэй уялдуулаад тусгай нөөц сан бүрдүүлэх, энэ асуудал яг энэ хууль, яг хамтын эрсдэлийн сан буюу энэ төр, хувийн хэвшлийн хамтран хэрэгжүүлдэг энэ хамтын эрсдэлийн сангийн тогтолцооны хувьд яг одоогийн хуульд тусгагдаж өгөөгүй байгаа.

Цаашдаа яах вэ олон улсын туршлагыг аваад үзвэл энэ гамшгийн эрсдэлийн даатгал, ялангуяа мал аж ахуйн салбар дахь гамшгийн эрсдэлийн даатгалын тогтолцоонд төрийн оролцоо зайлшгүй байх шаардлагатай гэдэг ийм концепц явдаг юм байна лээ. Тэгэхээр энийг цаашдаа хэлэлцээд явах боломжтой байх. Даатгалын хураамжийн хувьд бид нарт байгаа тоогоор сүүлийн 3 жил дараалан даатгуулаад нөхөн төлбөр аваагүй малчин улсын хэмжээнд 2200 малчин байдаг юм байна лээ. 2 жил дараалан даатгуулаад нөхөн төлбөр аваагүй 6000 орчим малчин байдаг юм байна. Эдгээр малчдад болохоор зэрэг хураамжийн хувь, даатгалынхаа зарчмын дагуу хураамжийн хувь хэмжээ буураад явдаг. Нөгөө даатгуулагчид маань нөгөө жил болгон адилхан хэмжээний хураамж төлөөд яваад заншчихсан байдаг юм ихэнх нь. Гэтэл энэ цаад талдаа хураамжийн хувь буурч байна гэдэг маань даатгуулсан даатгалын үнэлгээ маань өсөөд явж байгаа ийм даатгалын урамшуулал гэдэг маань даатгалын хураамжийн хувь дээр нь ийм хөнгөлөлт үзүүлж явдаг ийм тогтолцоо маань хэрэгжээд явдаг юм. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Далайн Батбаяр гишүүн асуулт асууя.

Д.Батбаяр: Энэ өдрийн мэндийг хүргэе. 2024 онд нийтдээ 1 их наяд 357 тэрбум төгрөгийн хохирол зуднаас болж учирсан гэсэн байна. Индексжүүлсэн даатгалаар энэний 10 хувьд нь ч хүрэхгүй нөхөн төлбөрийг оногдсон байна. Нийтдээ 16,8 тэрбум төгрөг. 2 жилийн хугацаанд зуд гамшиг боллоо. Даатгуулсан малчин өрхийн тоо нэмэгдээгүй байна. Нөхөн төлбөрийн тоо нэмэгдээгүй байна. 2014 оноос хойш хэрэгжиж явж байгаа энэ индексжүүлсэн даатгал гэдэг хэрэгжих боломжгүй, хэрэгжихгүй боломжгүй гэдэг нь амьдрал дээр харагдаад байгаа учраас энэ хуулийг нэмэлт, өөрчлөх нь яалт ч үгүй чухал байгаад байна. Тэгэхээр бүр эхнээс нь асууя л даа. Саяын хэлж байгаа Жавхлан сайдын хэлж байгаа 2 зүйлийг өөрчлөөд, асуудлыг шинэчлээд өөрчилчихнө, байдлыг өөрчилчихнө гэдэг дээр би итгэхгүй байгаад байгаа учраас би ахиад нэг үндсэн асуулт асуучихъя гэж байна. Яг энэ даатгалын тогтолцоо олон нийтийг хамрахгүй байгаа, үр ашигтай байхгүй байгаагийн гол шалтгааныг яг юу гэж үзэж байгаа юм бэ? Тэрийгээ маш богинохон тодорхойгоор хэлчих.

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Үндэсний давхар даатгал Жавхлант 20 дугаар микрофон.

Б.Жавхлант: Батбаяр гишүүний асуултад хариулъя. Сүүлийн 10 жилийн хугацааны хамрагдалтыг аваад үзэхээр зэрэг малчдын маань нийт тал хувь нь энэ даатгалын талаарх мэдлэг би мэдэхгүй гэдэг ийм асуудал тавьдаг юм. 2014 он хүртэл төсөл хэрэгжиж байх хугацаанд төслийн үед энэ нүүр тулсан сургалтуудыг, сурталчилгаануудыг, ойлгон таниулах, сурталчлан таниулах соён гэгээрүүлэх

ажлууд нэлээн сайн хийгддэг байсан. 14 оноос хойш хувийн хэвшлийн компаниуд маань яг энэ чиг үүргийг буюу өөрөөр хэлбэл малчны хотонд очиж борлуулалт хийж байгаа даатгалын компанид чиг үүрэг шилжсэн. Мэдээж энэ ашгийн төлөө үйл ажиллагаа бас хосолмол төрийн болон хувийн хэвшлийн хамтын түншлэлийн асуудал яригдаж байгаа учраас энэ соён гэгээрүүлэх сурталчлан таниулах асуудал хүндрэл учирсан.

2 дугаарт нь бүх шатын Засаг дарга энэ хуулийн хэрэгжилтэд хяналт тавих үүрэг хүлээдэг. Сүүлийн 10 жилийн хугацаанд Засаг дарга нарын зүгээс яг энэ малын индексжүүлсэн даатгалын талаарх сурталчилгаа, соён гэгээрүүлэх ажлууд маань хоцрогдолтой явагдаж байсан учраас энэ соён гэгээрүүлэх талын ажил бол нэлээн дутмаг байсан болов уу л гэсэн ийм ойлголттой байгаа.

Д.Амарбаясгалан: Энэ ч яах вэ соён гэгээрүүлэх ажил дутуудаа биш л дээ. Малын индексжүүлсэн даатгалын талаар ойлголт мэдээлэлгүй малчин гэж байхгүй, бүгд мэдэж байгаа. Гол нь хэрэгцээ шаардлагыг нь хангахгүй байна л гэдэг ойлголт байхгүй юу. Тэгэхээр энэ төслийг боловсруулж орж ирж ажлын хэсэгт сууж байгаа өөрөө маш буруу ойлголттой байна шүү дээ. Өөрөө ер нь хөдөө явж үзсэн үү? Тэр малчны хотонд очиж индексжүүлсэн даатгалд хэдэн төгрөгөөр даатгуулчихаад, хохирлоо хэдэн төгрөгөөр барагдуулсан талаар ойлголт байна уу? Тэгэхгүйгээр тэгээд соён гэгээрүүлэх ажил дутуу байна гээд ингээд л суугаад байдаг. Өөрсдөө нэг мундаг амьтад, малчдыг соён гэгээрүүлнэ л гээд сүрхий юм яриад байдаг.

Ямар ч хүн хэрэгцээ шаардлагыг нь хангаж байгаа ямар ч бүтээгдэхүүнийг хэнээр ч хэлүүлэхгүй авна. Хэрэгцээ шаардлага хангахгүй байгаа тэр бүтээгдэхүүнийг хэн ч хэлээд авахгүй. Ийм л ойлголттой байх ёстой. Энэ нэг шүүмжлэл байгаад байгаа шүү дээ. Төрөөс гарч байгаа шийдвэр яагаад амьдрал дээр бүрэн бууж хэрэгжихгүй байна вэ гэдэг асуултыг хүн болгон асуудаг. Тэр талаасаа хариулахдаа бид дутуу тайлбарласан байна, бид дутуу ойлгуулсан байна, бид танилцуулах ажлаа дутуу хийлээ гэж өөрсдийгөө дүгнээд байдаг. Гэтэл яг амьдрал дээр юу гээч тэр хэрэгцээ шаардлагыг хангаж байгаа бол хэнээр ч хэлүүлэхгүйгээр тэр хүн тэр бүтээгдэхүүнийг аваад хэрэглэдэг. Тэрийг л ойлгох хэрэгтэй. Энийг чинь зах зээл гэдэг байхгүй юу.

Тэгэхээр энэ чинь өөрөө хэрэгцээ хангах хэмжээнд байна уу, үгүй юу гэдгийгээ та бүхэн дотроо маш сайн дүгнэж байх ёстой. Төрийн бүх түвшинд. Энэ аливаа төрлийн хуулийн төсөл өргөн барьж байгаа аливаа нэгж энэ хэлэлцүүлгийг эрх ашиг нь хөндөгдөж байгаа төлөөллийн бүрэн оролцоотойгоор өргөн хүрээнд хийж байж өргөн барьж байх ёстой. Энэ гишүүд чинь иргэдийг төлөөлөөд сууж байгаа учраас энэ асуудлуудыг ингэж гэдэс дотрыг нь онгойлгож асууж, саналаа хэлж, сайжруулах гэж хичээгээд байгаа шүү дээ. Тэгэхээр энэ дээр бодитой хариулж байна шүү. Далайн Батбаяр гишүүн тодруулж асууя.

Д.Батбаяр: Би сая Улсын Их Хурлын даргын хэлж байгаа бодит байдлыг яг хэлж байна л даа. Энэ даатгал хийж байгаа, нөхөн төлбөрийг авч байгаа энэ процесс маань өөрөө маш төвөгшилтэй байгаад байгаа учраас малчин иргэд маань энд хамрагдахгүй байгаад байгаа юм. Даатгал гэдэг өөрөө эрсдэлийг багасгадаг, амьдралыг амар болгож байдаг ийм процесс байхгүй юу. Хэрвээ энэ амархан, энэ нь өөрөө хөрсөн дээрээ буусан ийм систем байсан бол энийг хүн

болгон аваад хэрэгжүүлчихнэ. Хэн ингээд л төвөгтэй хэзээ зуд болчих бол, хэзээ хотоо харлуулчих бол гээд л бодоод явах юм бэ? Тэгээд энэ бүхэн маань өөрөө хөрсөн дээрээ буусан, хэрэглэхэд хялбар ийм байх учиртай. Энэ шинэчлэлийг одоо энэ оруулж ирж байгаа энэ 2, үндсэн 2 асуудлыг шийдэх гээд шийдэхээр оруулж ирж байгаа энэ өргөн мэдүүлсэн энэ төсөл хангахгүй байна гэж би харж байна. Тийм учраас буцаая гэсэн саналтай байгаа. Газар тариалан, мал аж ахуй өндөр хөгжсөн тэгсэн мөртөө Африкийн орнууд байна. Эд нар болохоор энэ шинжлэх ухааны.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Далайн Батбаяр гишүүнд нэг минут нэмж өгье.

Д.Батбаяр: Энэ технологийн дэвшлийг бүгдээрээ ашигладаг болчихсон байхгүй юу. Хиймэл дагуулаас бүгдийг нь харчихна. Бүх үйлчилгээ, бүх малаа бүгдээрэнг нь блокчэйн дээр бүгдээрэнг нь үндэслэсэн технологи ашиглаад бүгдийг нь бүртгэдэг болчихсон. Манайх шиг жилдээ 2 удаа тооллого хийгээд, багийн даргаар толгойлуулсан комисс гараад тооллого хийгээд наана уу, цаана уу гээд бодитой тоо гардаггүй ийм асуудал үүсдэггүй болчихсон. Өнөөдөр би хэдэн төгрөг төлж даатгуулчхаад жилийн дараа даатгал өгөгдөх болов уу, үгүй юу, нөхөн төлбөрөө авах уу гээд ингээд байх боломж байдаггүй болчихсон байхгүй юу. Тийм учраас энэ технологийн дэвшлийг ашиглах хэрэгтэй байна, өөр бүрэн хэмжээгээр нь өөрчилсөн ийм санал төсөл оруулж ирэх хэрэгтэй байна гэсэн ийм санал байна.

Д.Амарбаясгалан: Санал хэллээ. Сайнхүүгийн Ганбаатар гишүүн асуулт асууна. Алга байна. Хосбаяр гишүүн асуулт асууя.

Г.Хосбаяр: Монголын хөдөөд байгаа 200 мянган өрхийн малчин өрхийн гол хөрөнгө бол мал л даа. Тэгээд энэ өнөөдөр мэдээж малын үнэ цэн энэ гол хөрөнгийнх нь үнэ үнэлгээ муу байгааг бүгд мэдэж байгаа. Өнөөдөр Монголын хөдөөд 1000 хоньтой хүн 150-аас 200 мянган төгрөгөөр бодоход 150-аас 200 сая төгрөгийн л хөрөнгөтэй хүн гэсэн үг. Гэтэл Улаанбаатар хотод 2 өрөө байр 200 саяын үнэлгээтэй л байгаа юм. Даатгалын компаниуд үл хөдлөх, машин гэх мэт илүү эрсдэл багатай ийм зүйлийг даатгах, ийм зүйл дээр илүү давуу байдал үүсгэсэн бүтээгдэхүүнүүд ихээр байдаг юм байна лээ. Тийм учраас энэ малчин өрхийн гол хөрөнгийг үнэлгээг өсгөх, үнэтэй байлгах, мөн эрсдэлээс хамгаалах энэ бол Монгол төрийн гол бодлогуудын нэг байх ёстой.

Тэгээд би ийм зүйл бодож байгаа юм. Малчин хүний амь нас, эрүүл мэнд, өдөр тутмын үйл ажиллагаа, түрүүний Амарсайхан сайдын хэлдэг орлогыг нь даатгах, мөн энэ мал эд хөрөнгийг нь даатгах гээд ингээд ийм цогц даатгалын бүтээгдэхүүн гаргах талаар судалгаа шинжилгээ ийм зүйл ер нь хийсэн газар байдаг уу? Өнөөдөр барилга угсралтын даатгал гэж байдаг. Барилгыг барихаас эхнээс нь авхуулаад дуустал хүртэлх бүх үйл ажиллагааг нь даатгаад, явцын хяналтыг нь тавиад, эрсдэлээс хамгаалаад, эрсдэлээ хуваалцаад, эрсдэлийг нь бууруулаад явж байгаа. Үүнтэй адилхан малчин хүний тэр бүтээж байгаа баялаг, тэр өдөр тутмын амьдрал, энэ их байгаль цаг уурын эрсдэлтэй нөхцөлөөс хамгаалах, бас энэ үндэсний онцлогийг тусгаж шингээх ийм даатгалын шинэ бүтээгдэхүүн шинэ асуудал гаргаж ирэх ийм судалгаа байгаа юу гэж асуумаар байгаа юм.

2 дугаарт нь болохоор зэрэг энэ малын индексжүүлсэн даатгалд хамрагдсан малчин өрхийн сүүлийн 5 жилийн судалгааг харахад энэ жишээ нь Хангайн бүсийн Өвөрхангай аймаг даатгалд хамрагдалт муу байна л даа. Жишээлбэл 20 онд 4,1 хувь байснаа 24 онд ингээд 5,2 хувь болсон. Гэтэл Архангай аймаг 9,1 хувь байж байгаад 16 хувь болсон. Тэгтэл яг нэг бүсэд байгаа Баянхонгор аймаг 28 хувьтай 2020 онд байсан, 24 онд 20,8 хувьтай гэх мэт. Ингээд яагаад нэг бүсэд байгаа аймгуудын даатгалд хамрагдах энэ эзлэх хувь нь ийм харилцан адилгүй өөр байна вэ? Энэ яг тэр тухайн орон нутгийн аймаг орон нутгийн удирдлага ч юм уу, эсвэл тэнд ажиллаж байгаа даатгалын компаниуд ч юм уу, ер нь тийм хүний хүчин зүйл, тийм нөхцөл байдлаас шалтгаалж ийм хамрагдалт нь ийм хувь нь ийм зөрөөтэй байна уу, эсвэл малчдын тэр хамрагдах сонирхол нь ийм бага байна уу? Энэ дээр хийсэн судалгаа байна уу? Ийм 2 асуултыг асууя.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн 20 дугаар микрофон.

Б.Жавхлант: Үндэсний давхар даатгал ХК-ийн гүйцэтгэх захирал Жавхлант. Хосбаяр гишүүний асуултад хариулъя. Энд малын индексжүүлсэн даатгалын бүтээгдэхүүний хувьд дахин сайжруулах, ялангуяа энэ босго үзүүлэлтүүдийг өөр, өөр төрлийн босго үзүүлэлтүүдийг шинжлэх ухааны ололтод тулгуурласан индексүүдийг оруулах талаар олон улсын байгууллагуудтай судалгааны түвшинд хийгдэж байгаа ажлууд байна. Тухайлбал энэ хойд туйлын уур амьсгалын хүйтрэлийн индекс гэж нэг шинэ индекс төрөл явж байгаа юм байна лээ. Мөн түүнчлэн хур тунадасны хэмжээний индекс гэх мэтчилэн зөвхөн нэг төрөл босго үзүүлэлт биш 2, 3 төрлийн босго үзүүлэлтийг хавсарган тооцох боломж бий юу гэдэг дээр судалгааны ажил хийгдэж байгаа.

2 дугаарт нь нэг бүсэд байгаа Архангай, Өвөрхангай, Баянхонгор аймгуудын малын даатгалын хамрагдалтын түвшин өөр, өөр байгаа гол учир шалтгаан нь үндсэндээ даатгалын нөхөн төлбөр олгосны дараагаар энэ даатгалын хамрагдалт нэлээн өндөр түвшинд байгааг нэгд харуулж байгаа Архангай аймгийн хувьд. Баянхонгор аймгийн хувьд төсөл анх хэрэгжсэн 3 аймгийн нэг. Өөрөөр хэлбэл 2006 оноос хойш энэ малын индексжүүлсэн даатгалд хамрагдаж байсан гэсэн үг. Тэгэхээр зэрэг 2006 оноос хойш нийтдээ бараг 17, 8 жилийн хугацаанд энэ сумд энэ аймаг, сумын хэмжээнд малын индексжүүлсэн даатгалын талаарх мэдлэг мэдэгдэхүүн нэлээн сайн түвшинд очсон байдаг.

2 дугаарт нь Баянхонгор, Архангай аймгууд сүүлийн арваад жилийн хугацаанд зудын давтамж хохирлын тоо нэлээн өндөр гарсан байдаг. Ялангуяа 20, 21 оны түвшинд Баянхонгор аймагт ихээхэн хэмжээний малын гарз хохирол гарсан. Архангай аймагт ч бас төвийн аймгууд, төвийн сумуудаар нэлээн хохирол гарсан ийм дүр зураг ажиглагдаж байсан. Түүнтэй холбоотойгоор даатгалд хамрагдсан малчид маань даатгалынхаа нөхөн төлбөрийг хүлээж авсан. Үүнтэй холбоотойгоор ч энэ даатгалд хамрагдах сонирхол нэмэгдсэн байх магадлалтай гэсэн ийм тооцоол бид нарт байгаа юм.

Д.Амарбаясгалан: Хосбаяр гишүүн тодруулж асууя.

Г.Хосбаяр: Би тэр нэг эхний асуулт дээрээ нөгөө даатгалын тийм шинэ бүтээгдэхүүн гаргах боломж нөхцөл байна уу? Жишээлбэл тэр малчин хүний өдөр тутмын амьдрал, үйл ажиллагаа, малчин хүн чинь тэнд бизнес хийгээд, баялаг

бүтээгээд байна шүү дээ. Тэгэхээр тэр өдөр тутмын үйл ажиллагаа, орлого, мал тэр бүх зүйлийг ингээд нэг магадгүй эрүүл мэнд, амь насны даатгал ч гэсэндээ малчин хүн дээр тусгайлан авч үзэж болно шүү дээ. Энэ үнэхээр бүсчилж, эрсдэлийг нь тооцож, ингэж авч үзэх гэж байгаа бол. Тэгэхээр ийм энэ бүгдийг багтаасан, шингээсэн ийм даатгалын цогц бүтээгдэхүүний судалгаа юм хийдэг үү? Энэ талаар л асуугаад байгаа юм.

Д.Амарбаясгалан: Нэмж хариулъя 20 дугаар микрофон.

Б.Жавхлант: Батбаяр гишүүний асуултад нэмж хариулъя. Даатгалын шинэ бүтээгдэхүүн буюу зөвхөн малын индексжүүлсэн даатгал биш, малын индексжүүлсэн даатгалтай уялдуулаад хавсарган гаргах боломжтой даатгалын бүтээгдэхүүн бол яах аргагүй энэ эрүүл мэнд, гэнэтийн ослын даатгалын бүтээгдэхүүн уялдах боломжтой гэж бид харж байгаа. Энэ жилийн борлуулалтын түвшинд манай компани болоод даатгалын компаниудтайгаа хамтраад тодорхой түвшний эрсдэлийн түвшнээс илүү хэмжээгээр даатгуулсан малчдад малчдыг гэнэтийн осол болоод бусад ЭМД-д хөнгөлөлттэй үнэ тарифаар хамруулах энэ гэх мэтчилэн ингэж уялдуулсан ийм даатгалын бүтээгдэхүүн бол орох боломжтой. Ялангуяа малчид маань нөгөө байгаль цаг уурын хүндрэлтэй нөхцөлд ажиллаж амьдардаг учраас ялангуяа энэ аюулгүй байдлын тал дээр зайлшгүй ийм хамгаалалт байх шаардлагатай. Малаа гэж ярьсаар байж байгаад ерөөсөө хүнийхээ асуудлыг бид хаядаг ийм сул тал байгаа учраас даатгалын компаниудтайгаа хамтраад гэнэтийн осол ялангуяа энэ байгаль цаг уурын хүндрэлтэй хүндрэл.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Цагаанхүүгийн Идэрбат гишүүн асуулт асууя.

Ц.Идэрбат: Та бүхэнд өдрийн мэнд хүргэе. Энэ их чухал асуудал. Ер нь 2005-аас 2014 он, 14-өөс 24 он гээд ингээд 2 үечлэлтэй яригдах ийм асуудал юм байгаа юм. Тэгээд энэ хугацаанд ер нь ингээд малын индексжүүлсэн даатгалыг 2005 оноос эхлээд сумын орлогчоор эхэлж байхдаа л би энэтэй ноцолдож байсан хүний хувьд индексжүүлсэн гэдгийг нь ойлгуулах л гэж бид асар их хэцүү байдалд орж байсан шүү дээ. Тэгээд тэрнээс өөр нэг их айхтар тийм дэвшил ойлголт өгсөн зүйл ер нь харагдахгүй л байгаа юм. Одоо яг амьдрал дээрээ ингээд харахаар даатгуулсан иргэдийн тоо ингээд хэлбэлзэлтэй байгаа чинь магадгүй малын махны үнэ, малын өсөлттэй холбоотой. Дээрээс нь зээл авах, шагнал авах, хавартаа машины даатгал хийлгэхэд л энэ даатгалын компаниуд энэ МИД-н талаар нэг товчхон дурдаад, ганц нэг хүн даатгуулаад ингээд л явдаг юм руугаа орчихсон байхгүй юу энэ даатгал бол.

Тэгэхээр ер нь өнөөдрийн энэ зүйл дээр яг малчдын ярьдаг зүйлийг л хэлж байна л даа. Гэхдээ би бол сая Амарбаясгалан дарга хэлж байна. Төрийн ордонд малчид авчраад асуухаар яг л энэ 2-ыг л ярина. Хотонд нь очоод асуувал энэ чинь амьдрал ярих байхгүй юу. Яагаад бид даатгуулахгүй байгаа юм бэ гэдгийг. Тэгэхээр өнөөдрийн энэ өөрчлөлтийг би ингээд хараад байх нь яах вэ зүгээр малчдын саналыг аваад оруулж ирж байгаа юм шиг боловч яг углуургаараа хөдөө аж ахуй, мал аж ахуйн салбарыг эрсдэлээс хамгаалах тийм цогц утгаараа би бол бас хараахан учир дутагдалтай байна уу даа гэж ингэж харах гээд байгаа юм.

Тийм учраас ер нь хийхээр бид энэ зөвхөн энэ босго, нөхөн төлбөрийг уялдуулах биш, энэ үндэсний онцлогтой юмыг бид яриад байгаа байхгүй юу. Дэлхийд бид очоод үзье газар байхгүй. Ганцхан бэлчээрийн аж ахуй ийм эрс тэс уур амьсгалтай, тэгээд энэ өргөн уудам нутагт тарж амьдардаг, тэгээд эрсдэл ихтэй ийм зүйлийг бид хэрхэн зохицуулах вэ гэдгээ ярьж байгаа учраас яг өөрсдийнхөө энэ амьдралд буусан, хөрсөн дээрээ буусан тийм цогц хууль хийвэл яасан юм бэ гэж би хэлэх гээд байгаа юм. 2005 оноос хойш 20 жил ноцолдоод өнөөдөр бид нарын үр дүн энэ байгаа байхгүй юу. Тэгэхээр бид зөвхөн нөхөн төлбөрийг нь жоохон босгыг нь жоохон намсгана, яг багасгаж чадах уу, үгүй юү? Дээрээс нь урьдчилаад 5 төгрөг өгнө гэдэг энэ 2 үзүүлэлтээр дараагийн 10 жилийг бид явуулна гэвэл хөдөө аж ахуйн салбараа илүү л хүнд байдалд оруулчих байх.

Тэгэхээр энэ гишүүдийн хэлж байгаа Амарсайхан дарга хэлж байна, Их Хурлын дарга ярьж байна, манай Батжаргал гишүүн ярьж байна, энэ Хосбаяр гишүүн, Батбаяр гишүүдийн яриад байгаа энэ бүх зүйлийг бид ингээд цогцоор нь авч үзээд, энэ хэлэлцүүлгийг маш өргөн хүрээнд хийгээд, ингээд нэг үндэснийхээ онцлогт мал аж ахуйдаа тохирсон, малчиндаа ээлтэй, эдийн засагтаа хүндрэл учруулахааргүй, салбараа татаад унагаачихааргүй ийм өөрчлөлт хийхгүй бол бид ингээд 20 жил явсан юмаа яг энэ 2-оор өөрчилбөл болохгүй юм байна л гэж ингэж би бодоод байгаа юм. Тэгэхээр 2024 оны 4 сард Баянхутаг сумд байгалийн гэнэтийн гамшиг болоод, тэгээд миний бие очиж малчидтай уулзаж байсан. Толгойгоо эргэтэл загнуулсан би тэнд. Энэ индексжүүлсэн даатгалын асуудлаар, энэ хохирлын асуудлаар. Тэгээд харин Байнгын хороон дээр ингээд тухайн үед нь ирээд нөхцөл байдал ийм байна гэж байсан. Тэгээд өнөөдөр харин Засгийн газар энийг хөндөөд оруулаад ирж байгаа нь талархууштай.

Гэхдээ би Их Хурлын даргаас нэг зүйл асуухад хэрвээ бид хэлэлцэх эсэхийг дэмжээд ингээд явчих юм бол өргөн барьсан энэ хоёрхон нөхцөл дээр бид хэрвээ ярина гэвэл дэндүү өнгөцхөн юм болчих байх гэж би материалыг нь аваад нэлээн хэд хонолоо, нэлээн сайн уншлаа л даа. Тэгж харагдаад байгаа юм. Тэгэхээр энэ дээр бид хөрсөн дээрээ буусан, онцлогоо тохируулсан, энэ Монгол ахуйдаа буусан, эрсдэлээ тооцсон давхар, давхар юмнуудаа тооцсон ийм хуультай л болмоор байна даа л гэж.

Д.Амарбаясгалан: Харин тийм. Тэгэхээр ер нь бид өнгөц хэлбэрийн өөрчлөлт хийнэ гэхээсээ илүүтэйгээр сая Батжаргал гишүүн ч хэлчхэж байна, манай Идэрбат гишүүн сая хэлж байна. Ер нь орон нутагт, орон нутаг удирдаж ажиллаж байсан иргэдийн ахуй амьдралыг ялангуяа хөдөөгийн ард иргэдийн амьдралыг нэлээн гадарлаж байгаа гишүүд жоохон өргөн хүрээний, зөвхөн нэмэлтийн хүрээнд биш, нэмэлт, өөрчлөлт, бүр цаашлаад яривал шинэчилсэн найруулгын хэмжээний асуудал гишүүдийн энэ үгнээс гараад эхэлж байна шүү дээ. Хэрвээ тийм тохиолдолд бид энэ асуудлаа хэлэлцэх эсэхээсээ татгалзаж буцаагаад, харин шуурхай хаврын чуулган эхлэх хүртэлх хугацаанд Улсын Их Хурлын гишүүдийн өргөн хүрээний оролцоотой, аймаг, бүсийн хэмжээнд хариуцсан ажлын хэсгүүдийг илгээж, хэлэлцүүлгийг өргөн хүрээгээр малчдын дунд зохион байгуулаад, учир шалтгааныг энэ мэргэжлийн байгууллагатай хамтдаа зөв тодорхойлоод, эргээд хаврын чуулган эхлэхэд энэ хуулийн төслийг маш хурдтайгаар өргөн барьж, богино хугацаанд хэлэлцэж дуусгах дээр анхаарал хандуулбал бараг зөв болов уу гэж бодож байна.

Маш олон талын өндөр ач холбогдолтой байна шүү дээ. Ганцхан малын индексжүүлсэн даатгал гээд л сая Хосбаяр гишүүн ярьж байна. Бусад төрлийн даатгал яагаад малчдад байна, байхгүй байна, ЭМД-ын асуудлаас өгсүүлээд. Орлого тасалдахтай холбоотой асуудлыг хүртэл давхар даатгаж, бусад хот суурин газар ажиллаж, амьдарч байгаа иргэдтэй эрх тэгш байх тэр нөхцөлийн төлөө яагаад байж болохгүй вэ гэдэг асуудал яригдаж байна шүү. Тэгэхээр энэ дээр бүгдээрээ сайн ярилцъя, гишүүд маань сайн асуучих. Тэгээд төгсгөлд нь санал хураалтаар асуудлаа шийднэ. Зүгээр буцаая гэж буцааж байгаа биш, илүү өргөн хүрээгээр сайжруулж, ард иргэд, малчдынхаа амьдралд бүрнээ нийцсэн хуультай болъё гэдэг энэ санаачилгаар буцааж байгаа гэдэг ойлголт байж болно. Болохгүй зүйл байхгүй гэж бодож байна. Цэндийн Сандаг-Очир гишүүн асуулт асууя.

Ц.Сандаг-Очир: Би ч адилхан саналтай байна. Ер нь цаг агаарын эрс тэс уур амьсгалтай, бэлчээрийн мал аж ахуйтай манай улс орны хувьд даатгалын тогтолцоог хөгжүүлэх, бэхжүүлэхэд амаргүй л дээ. Тэгээд асуудлыг оруулж ирж байгаа салбарынхныг буруутгах аргагүй. Гэхдээ даатгалын тогтолцоо хууль 14 оноос хойш өнөөдрийг яваад ингээд тодорхой үр дүнд хүрэхгүй байгаа учир шалтгаан нь юу вэ гэхээр ерөөсөө л тухайн энэ малчин байгаль цаг агаарын эрсдэлд өртөөд л, хохирол амсаад, нөхөн төлбөрөө тухайн үедээ авч чадахгүй байгаа л гол шалтгаан нь энэ шүү дээ. Тэгээд энэ нэг Засгийн газраас шинэ хоршоо хөдөлгөөн, малчдын бүлэг байгуулах, зээл олгох төрөөс энийг нэг олж харангуутаа л энэ даатгалын тогтолцооныхоо эрчимжүүлэх хүрээнд нэг хөшүүрэг болгоод л энэ хуулийг оруулаад ирэх ийм л санаагаар орж ирж байгаа юм болов уу л гэж бодлоо.

Тэгэхээр ерөөсөө энэ хөшүүрэг болж чадахгүй. Тэгээд энэ сайн дурын даатгал байх ёстой. Тэр босго 6 хувь, сумын хэмжээнд 6 хувь тавина гэдэг чинь өөрөө болохгүй. Сум чинь өөрөө голын урд, хойдохоороо, баруун, зүүн талаараа газар нутгаараа хойд талын хангайн бүсийн сумын, хангайн бүсийн айлуудад газар нутгуудад өнөтэй дулаан өвөлжөөд өвөлжилт болж байхад, урд талын хээр тал бүсийн говийн бүсийн сумуудад өнөтэй сайхан юу гэдэг юм, эсвэл эсрэгээрээ эрсдэлтэй зуд турхантай байхыг үгүйсгэхгүй шүү дээ. Гэтэл малаа даатгуулчихсан байдаг. Танай сумын 6 хувийн босго хүрэхгүй байгаа учраас та даатгал авахгүй нь гэдэг ийм л шалтгаанаар өнгөрсөн хугацаанд даатгуулсан малчид нөхөн төлбөрөө авч чадахгүйгээс болж, тэгээд энэ даатгалын тогтолцоо чинь, энэ даатгалд итгэх итгэл чинь, иргэдийн ойлголт хандлага чинь энэ хууль чинь хэрэгжихгүй байгаа учир шалтгаан ерөөсөө энэ шүү дээ.

Ерөөсөө даатгуулсан л бол хаана байхаас үл хамаараад хохирол амссан бол тэр даатгалаа авдаг байдаг ийм тогтолцоо руу орж байж наад тогтолцоо чинь бэхэжнэ, хууль чинь явна, малчид итгэнэ. Тэгж байж малчид малаа даатгуулна. Тэрнээс сумын хэмжээний хохирлыг 6 хувийн босго тавиад, тэрэнд шингээгээд явна гэвэл танай сум та хэдийгээр хохирол амссан ч гэсэн танай сум нийтээрээ зуд турхан эрсдэлд ороогүй байна, тийм учраас та нөхөн төлбөр авах бололцоогүй байна гээд ингэж хуульчилж өгөх гэж байгаа бол энэ хууль хуулийн үзэл баримтлал явахгүй.

Тийм учраас цаашдаа энэ хуулийн үзэл баримтлалаар малчин хүн малаа даатгуулсан хэдэн хувь 100 хувь байна уу, 50 хувь байна уу тэр даатгуулсан хувьдаа л эрсэдсэн эрсдэлийнхээ нөхөн төлбөрийг авдаг байх хуулийн агуулга руу л цаашдаа явах ёстой. Өнөөдөр дэлхий дээр АНУ Лос Анжелес хот бүхэл бүтэн

хот шатаж байна. Тэнд даатгалын тогтолцоо маш өндөр хөгжсөн. Гэтэл өнөөдөр тэр том бэхэжсэн даатгалын компаниуд зугтаад алга болж байна шүү дээ. Алга болж байна шүү дээ. Яг түүнтэй адилхан өнгөрсөн 23, 22 онд 2 жил дараалан маш хүнд өвөл болсон улсын хэмжээнд. 10 гаруй сая мал, ДНБ-ий 16, 7 хувийн хохирол амсчхаад байж байгаа шүү дээ. Тэгэхээр ийм хэмжээнд эрсдэл учирлаа гэхэд наад даатгалын компаниуд чинь хэчнээн сайн байлаа гээд эрсдэлийг нөхөн төлж чадах юм уу, үгүй юм уу? Энэ даатгалын компаниудын чинь чадвар, чадавх ер нь хэр байдаг юм бэ?

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Ажлын хэсгийн 20 дугаар микрофон.

Б.Жавхлант: Үндэсний давхар даатгал ХК-ийн гүйцэтгэх захирал Жавхлант. Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя. 1 дүгээрт нь энэ сумын малын индексжүүлсэн даатгал буюу ялангуяа мал аж ахуйн салбар, хөдөө аж ахуйн салбарт олон улсын түвшинд хэрэгжиж байгаа энэ түгээмэл туршлага энэ индексэд суурилах параметрик арга хэрэгсэл байгаа юм. Өмнө нь бид малчны хотонд гарсан хохирлоор нөхөн төлбөр олгодог ийм систем бид нарт нэгдлийн үеэс байсан. Харамсалтай нь 1991 оноос хойш энэ төрлийн даатгал буюу малчны хотонд гарсан хохирлыг нөхөн төлөх даатгалын тогтолцоо маань үндсэндээ нуран унасан юм.

Учир нь юу вэ гэхээр зэрэг тухайн үед хувийн даатгалын компаниуд гарч эхэлсэн. Мөн түүнчлэн даатгалын тогтолцоо маань эхлэлийн шинж чанартай байсан. Үүнтэй холбоотой ч байсан байх. Нөгөө талаасаа эдийн засгийн хувьд үр ашиггүй гэдэг ийм дүгнэлтийг Дэлхийн банкны шинжээч мэргэжилтнүүд хийгээд, 2005 онд индексэд суурилсан малын индексэд суурилсан даатгалын тогтолцоог бий болгоё. Ингэхдээ төр, хувийн хэвшлийн хамтарсан зарчим дээр тулгуурлаж үүнийг хэрэгжүүлбэл илүү үр дүнтэй, цаашдаа хөгжих боломжтой тогтолцоо байх юм гэдэг ийм дүгнэлтэд хүрч, малын индексжүүлсэн даатгалын тогтолцоог анх бий болгосон юм.

Түрүүн хэлсэнчлэн Архангай, Сүхбаатар, Увс гэсэн 3 аймгийг сонгож аваад яг багийн түвшинд хохирол тооцохоор энэ тооцооллыг хийж үзэхэд нэг сумын түвшинд тэрбумаас багагүй хэмжээний нөхөн төлбөрийг олгох ийм тооцоолол яг гарч байгаа юм л даа 24 оны өвөл, 23 оны өвөлжилт, хаваржилтын хүндрэлийн тоон мэдээллийн дунджид харьцуулахаар. Тэгэхээр зэрэг энэ маань юу гэсэн үг вэ гэхээр зэрэг яг тэр түвшинд хэрэгжинэ гэх юм бол малын индексжүүлсэн даатгалын яг энэ даатгалын хураамжийн хэмжээ нэлээн өндөр хэмжээнд очно. 2 дугаарт нь ийм өндөр хэмжээнд даатгалын хураамж очсон тохиолдолд малчин тухайн хураамжийг төлөх чадвар байх уу, байхгүй юу гэдэг асуудал бий болно. Мөн түүнчлэн энэ олон улсын шинжээчид хэлдэг юм. Ер нь яах вэ малчны хотонд гарсан хохирлыг төлөх энэ системийг цааш нь үргэлжлүүлье гэвэл байж болохгүй гэвэл болохгүй юм бол биш. Гагцхүү тухайн хураамжийг төлөх санхүүгийн эх үүсвэр чадавх байна уу гэдэг асуудал дээр л хамгийн гол асуудал байна гэдэг ийм зүйл дээр тулгуурласан юм.

Дараачийнх нь болохоор зэрэг юу билээ, даатгалын компаниудын эрсдэл даах чадавхын хувьд өнөөдрийн хувьд дотоодын даатгалын компани болон үндэсний давхар даатгалын компани, олон улсын давхар даатгалын компани нийлээд энэ эрсдэлийн 3 түвшинд даатгалын эрсдэлийг хүлээж авч байгаа.

Нийтдээ нэг манай компани 400-аас 500 тэрбум төгрөгийн энэ хохирлыг, эрсдэлийг даах энэ бололцоог энэ системээрээ бий болгох боломжтой гэж харж байгаа.

Д.Амарбаясгалан: Цэндийн Сандаг-Очир гишүүн тодруулж асууя.

Ц.Сандаг-Очир: Та бүхний энэ хуулийн үзэл баримтлалд энэ нөхөн төлбөрийг урьдчилан олгоно, өмнөх хуулиар тооллогын дараа, статистикийн дүн мэдээний дараа олгодог байсан учраас ингээд хугацаа алдах юм байсан гэж ярьж байна. Тэгэхээр энэ шинэ хуулиар орж ирж байгаа чинь бололцоо боломж нь хомс л юм шиг харагдаад байна. Тухайн үед нь нөхөн олговрыг нь олгоно гэдэг чинь улс жилдээ мал тооллогыг нэг л удаа явуулж байгаа шүү дээ. Хагас жилийн тооллого гээд түрүүн Сангийн сайд ярьж байх шиг байсан. Тэгээд нөгөө 6 хувийн босго чинь хэрэгжиж байгаа юм. Тэгтэл 11 сард, 12 сард мал хорогдох нь ховор, харьцангуй авсан тэвээрэг, өвс тэжээлээрээ явчихна. 1, 2 сард малын хорогдол гарч ирнэ. Тэгтэл 1, 2 сард чинь сумын хэмжээний дүн мэдээ гараагүй, 6 хувийн босго чинь гараагүй байж байгаад та нар нөхөн төлбөрийг нь урьдчилж олгоно гэдэг тийм бололцоо, боломж байх уу, үгүй юу? Энэ дээр та бүхэн.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Ажлын хэсгийн 20 дугаар микрофон.

Б.Жавхлант: Үндэсний давхар даатгал Жавхлант. Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя. Одоогийн байдлаар яг хуульд байж байгаа хүчин төгөлдөр хуулийн дагуу хагас жилийн мал тооллогын түүвэр тооллогод суурилж малын хорогдлын тоог гаргаж байгаа. Ингэснээр малын хорогдлын хувийг гаргаснаараа нөхөн төлбөрийг тооцоолох боломж бүрдэж ингэж гарч байгаа юм.

ҮСХ-ноос явцын мэдээ буюу сар болгон, улирал болгон гаргадаг мал, том малын зүй бус хорогдлын тоон статистик мэдээлэлд тулгуурлаад нөхөн төлбөрийг урьдчилж олгох боломжтой гэж үзэж байгаа. Олон жилийн давтамжийг харахаар зэрэг аль тухайн жилийн 1-ээс 2 дугаар сард тэр жилийнхээ малын зүй бус хорогдлын 80 орчим хувь нь учирдаг ийм тодорхой, ийм олон жилийн давтамж байдаг юм байна лээ. Тэгэхээр үндсэндээ хамгийн өндөр хорогдолтой 1-ээс 2 сард энэ малын.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүн Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан асуулт асууя.

Л.Мөнхбаясгалан: Надад санал байна. Би үг хэлье дээ. Энэ индексжүүлсэн даатгалд хамрагдаж байгаа малчид хураамжийг бага төлөөд хамрагдахгүй байна гэж байна шүү дээ. 11-ээс 18 хувь нь л хамрагдаж байна. Энэ бол маш чамламаар тоо гээд. Үнэхээр чамламаар тоо. Яагаад хамрагдахгүй байна вэ гэвэл энэ даатгалаас чинь нөхөн төлбөр нь бараг ирэхгүй байгаа. Энийг ойлгохгүй байгаа.

2 дугаарт малчид орлогогүй байхгүй юу. Тэгээд сая Жавхлан даргын хэлж байгаагаар зудын эрсдэл, гангийн эрсдэл ихтэй говийн бүсийн аймгууд маш ихээр даатгуулах ёстой шүү дээ. Гэтэл 23 оны судалгаанаас харахад Дорноговь аймаг 33,3 хувиар даатгуулж байсан бол 24 онд 11,3 хувь болчихсон байна. Өмнөговь 16,3 хувьтай даатгуулж байсан бол 3,3 хувь болчихсон. Би өөрийн сонгогдсон зөвхөн говийн бүсийг ярьж байгаа шүү. Малчид очоод ярихаар юу ярьж гэхээр энэ даатгалыг ярьдаг, вакциныг ярьдаг, бэлчээрийг ярьдаг байхгүй юу.

Тэгэхээр энэ малын индексжүүлсэн даатгал гэдэг чинь сайн малчин, шилдэг малчин болох нэг баримт бичгийн бүрдүүлбэр мэт яваад байсан. Одоо банкны зээл авах, банкны зээл авахад явдаг бүрдүүлбэр болох гээд байгаа юм биш үү? Тийм учраас энэ хуулийг заавал энэ намрын чуулганы бөгсөн дээр ингэж яаран нэмэлт өөрчлөлтөөр баталмааргүй байна. Шинэчилсэн найруулгын хэмжээнд өөрчлөөд, Улсын Их Хурлын даргаа одоо ингээд чуулган завсарлаж байгаа юм чинь гишүүд тойрог руугаа явна, малчидтайгаа уулзана. Сайтар хэлэлцээд, буцаж ирээд хаврын чуулганд бид шинэчилсэн найруулгын хэмжээнд өргөн барьж болно шүү дээ.

Тэгэхгүй бол одоо ингээд зөвхөн сумаараа нөхөн олговор авдаг 6 хувийг нь байхгүй болгож байна гэж байна. Тэгсэн хэр нь 6 хувийн босгыг байхгүй болгонгуутаа тэр хэн нь авч, хэн нь авахгүйг яаж тодорхойлох юм бэ? Тэр Засгийн газрын эрх хэмжээ болох ёсгүй байхгүй юу даа. Тийм учраас өмнө нь шагнал авах материалын бүрдүүлбэр байсан бол одоо банкны зээл авахын бүрдүүлбэр болгомооргүй байна даатгалыг хэдүүлээ. Даатгал байх нь зүйтэй. Энэ хуулийг дэмжиж байгаа. Гэхдээ арай л хөнгөн хуумгай байх шиг байна. Гуравхан үндсэн заалт дээр нэмэлт, өөрчлөлт оруулж өргөн барьж байна шүү дээ. Тэгэхээр шинэчилсэн найруулгын хэмжээнд хаврын чуулган руу оруулъя. Гишүүд тойрогтоо ажиллаж, малчидтайгаа дахин сайн ярилцъя. Ийм саналыг оруулж байна.

Д.Амарбаясгалан: Үг хэлчихлээ, санал хэлчихлээ. Лхагвасүрэнгийн Соронзонболд гишүүн асуулт асууя.

Л.Соронзонболд: Ер нь өнгөрсөн 2 жилийн зудыг харахаар энэ малын индексжүүлсэн даатгал хийлгэсэн малчид аягүй эрсдэлээ бүрэн нөхөөд авчихсан шүү дээ. Өөрөөр хэлбэл тэр хүмүүс болохоор 100 малаа даатгуулсан бол 100 малаа нөхөөд авчихсан л гэсэн үг мөнгөө. Тэгэхээр малын индексжүүлсэн даатгал ач холбогдол өндөртэй байгаад байгаа юм. Гол нь энэ бид нөгөө хөнжлийнхөө хэрээр хөлөө жийхгүй бол энэ Үндэсний давхар даатгалын компани чинь өөрөө 70 тэрбум төгрөгийн л хөрөнгөтэй компани байгаад байхгүй юу. Тэгээд энэ жил гэхэд чинь ингээд 14,7 тэрбум төгрөгийг нөхөн төлбөрт өгчихлөө. Тэгэхээр энэ хэмжээгээр чинь компанийн хөрөнгө багасаж л байгаа.

Тэгэхээр энийг нөгөө талд нь энэ малын энэ индексжүүлсэн даатгалын хураамж чинь болохоор энэ компанийн нийт орлогынх нь ердөө 20-хон хувь байгаад байгаа байхгүй юу. Тэгсэн мөртөө нөхөн төлбөрийг нь бараг 70, 80 хувь нь болчихдог. Тэгээд эдийн засгийн талаас нь бодохоор энийг цааш нь яаж явуулах вэ гэдэг дээр зөвхөн энэ 3 заалтаас гадна, энэ малын индексжүүлсэн даатгалыг болж өгвөл бүх малчид хийлгэх ёстой байхгүй юу 1 дүгээрт.

2 дугаарт болохоор төрөөс өгч байгаа бүх төрлийн энэ урамшууллууд байна. Ноосны урамшуулал байна, сүүний урамшуулал байна эд нарыг нь эргүүлээд малын индексжүүлсэн даатгалынх нь хураамжид тооцдог байж болно шүү дээ.

3 дугаарт нь болохоор Үндсэн хуульдаа тэртээ тэргүй мал төрийн хамгаалалтад байна гээд заачихсан байгаад байгаа. Тэгээд төрийн хамгаалалтад байна гэдэг чинь юу гэсэн үг юм бэ гэхээр даатгуулъя л гэсэн санаа байна шүү дээ.

Тэгэхээр малын индексжүүлсэн даатгал бол ер нь албан журмын даатгал байхад нэг их болохгүй юм бол байхгүй болов уу л гэж би бодож байна. Тийм учраас энэ малын индексжүүлсэн даатгалын оруулж байгаа 3 өөрчлөлт яах вэ харьцангуй чамлалттай байна. Илүү жоохон том зургаар нь хараад, өөрчлөлт оруулах талаасаа байвал яасан юм бэ гэсэн энэ бусад гишүүдийн саналтай санал нэг байна. Үг хэллээ.

Д.Амарбаясгалан: Санал хэллээ. Батын Батбаатар гишүүн алга байна. Чинбатын Ундрам гишүүн алга байна. Загджавын Мэндсайхан гишүүн асуулт асууя.

З.Мэндсайхан: Малын индексжүүлсэн даатгалын хуульд өөрчлөлт оруулах гээд орж ирж байгаа нь зөв. Ялангуяа тэр нөгөө хохирлыг тооцох, хугацааг мал тооллогын эцсээр гэж энэ хугацааг уян хатан болгоё гээд хуулийн үзэл баримтлал оруулаад ирсэн байна. Энэ нэлээн томоохон өөрчлөлт болно гэж харж байгаа юм. Гэхдээ хуулийн нэр томъёоноос өгсүүлээд эргээд харах асуудлууд байгаа. Юу вэ гэхээр зэрэг сая гишүүд ч гэсэн яриад байна л даа. Энэ даатгалд маань малчид төдийлөн хамрагдаагүй ямар нэгэн хөшүүрэг байхгүй байна гээд. Тэгэхээр индексжүүлсэн даатгал гэдэг чинь өөрөө яг бодит хохирлын хэмжээгээр биш босго тогтоосон буюу тухайн сум орон нутагт хорогдсон малын, бод малын босгын хэмжээгээр хорогдлыг нь тооцож өгч байгаа шүү дээ. Энэ чинь өөрөө малчид малаа даатгуулах тэр юуг нь өгч чадахгүй байгаа юм сэдэл санааг нь.

Юу вэ гэхээр зэрэг малчид маань хохирлоо бодитоор тооцоолоод явдаг болох юм бол энэ малчид маань малаа даатгалдаа хамруулаад явах нь өөрсдийнх нь эрсдэл хөрөнгийнхөө эрсдэлийг хамгаалж байгаа хэлбэр болчхож байгаа юм. Босго оноо тогтоочихоор зэрэг эргээд бодит хохирлоо нөхөж авч чадахгүй учраас энэ даатгалд хамруулах шаардлагагүй болчхож байгаа юм. Засгийн газар болон Их Хурлаас хөдөө аж ахуйн салбарыг дэмжих янз бүрийн хөнгөлөлттэй бодлого, зээлийн хүү, дэмжлэгийг явуулж, санхүүгийн дэмжлэг үзүүлнэ гэхээр зэрэг энэ хуулийг дагуулаад Малчны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах гээд малчин заавал индексжүүлсэн даатгалд даатгуулсан байна гээд ороод ирж байгаа юм. Энэ чинь юуг хэлж байна вэ гэхээр ерөөсөө арилжааны банкны эрсдэлийг энэ мал даатгалын хуулийн өөрчлөлтөөр дагалдуулж арилжааны банкны эрсдэлийг хаах ийм байдал руу орж, албан ёсны даатгал шиг болгож байгаа байхгүй юу.

Өнөөдөр бид амьдралаас тасарчихсан юм ярьж болохгүй байхгүй юу. Зуд яах вэ 2, 3 жилдээ нэг болдог байж болно. Малчин хүн эдийн засгийн харилцаанд байнга орж байгаа. Тэд харин мөнгөгүй учраас очиж банкнаас зээл аваад байгаа. Эдийн засгийн санхүүгийн эх үүсвэр хэрэгтэй учраас зээл авч байгаа. Бэлэн мөнгөтэй байсан бол тэр хүмүүс очоод зээл аваад байхгүй. Эдийн засгийн хувьд ашигтай байсан бол. Зээл авах гээд очихоор яг бодит байдал дээр яах вэ гэхээр малаа та индексжүүлсэн даатгалд даатгавал мөнгө байхгүй, зээлээс чинь тодорхой хувийг индексжүүлсэн даатгалд нь суутгаж авна гэсэн үг. Зээл авахдаа хүн зээлийн зарцуулалт нь эхний ээлжид малын индексжүүлсэн даатгал буюу тэр даатгал руу нь явах нь барьцаа хөрөнгийнх нь. Ийм байдал үүснэ.

Тэгэхээр зэрэг бид энэ индексжүүлсэн гэхээсээ илүүтэйгээр бид бодит хохирлыг тооцдог тэр даатгалын систем рүү нь эхлээд оруулах ёстой. Ингэж байж малчид маань энэ даатгалд чинь малаа өөрсдөө бидэнтэй, бидэнгүй сайн

дураараа даатгуулаад эхэлнэ. Хөдөө аж ахуйн салбар цаг уур, байгаль орчны эрсдэлээс өөрийгөө хамгаалах энэ систем нь бүрдээд явна. Энийг дагалдуулж байж тэр санхүүгийн асуудлаа шийдье. Тиймгүйгээр түрүүлээд Шинэ хоршоо хөдөлгөөн ч гэдэг юм уу, энэ Цагаан алт хөтөлбөр гээд энэ мал аж ахуйн салбарыг дэмжсэн хөнгөлөлттэй зээлийн бодлого арилжааны банкнуудаар хэрэгжих нь тодорхой болонгуут зөрүүлээд малчин бол малын индексээр даатгуулсан байх ёстой, индексжүүлсэн даатгалд, ингээд зээл авна гэдэг ийм байдлаар явах юм бол малчдын санхүүгийн дарамт болно энэ чинь.

Тийм учраас энэ хуулиа буцаагаад, илүү хэлэлцүүлэгтэйгээр, бид хэлэлцэх асуудлыг нь би бол хойшлуулъя гэдэг саналыг гаргаж байна. Ингээд малчдаараа бид хэлэлцүүлээд, өргөн хэлэлцүүлэг хийж байж, энэ асуудлуудаа нэгтгэж оруулж ирэхгүй бол ерөөсөө л гол даатгуулахгүй байгаа шалтгаан бол тэр босго чинь байгаад байгаа юм. Энэ хуулийн чинь төсөл дээр давхар даатгалын компаниуд босго тогтооно гэдэг бол даатгалын компани эрсдэлээ бодоод энэ дээр багаар тогтооно гэсэн ойлголт угаасаа байхгүй. Ингээд энэ асуудал чинь бүр хумигдаад явна. Харин хүрээг нь яаж тэлэх вэ гэхээр санхүүгийнх нь хэрэгцээ дээр буюу банкин дээр очиж механикаар даатгадаг ийм байдал руу орох гэж байна. Тийм учраас энэ хуулийг хэлэлцэх эсэхийг нь буцаасан нь дээр байх гэсэн ийм саналтай байна.

Д.Амарбаясгалан: Мэндсайхан гишүүн ийм юм байна лээ. Энэ Дэгийн тухай хуулийн 34.4, 34.5 дахь заалтуудаар хуулийн төслийг хэлэлцэх эсэхийг дэмжээгүй тохиолдолд дахин нэг жилийн дотор, үзэл баримтлалын хүрээнд нь дэмжээгүй тохиолдолд дахин нэг жилийн дотор өргөн барихыг хуулиар хориглох байгаа юм. Хууль санаачлагч буцаан татаж аваад, энэ саналын хүрээнд боловсруулаад оруулж ирж болно. Гэхдээ бид тэгж асуудлыг хүндрүүлэхгүйгээр Улсын Их Хурлын гишүүдийн идэвх оролцоо их өндөр байх нөхцөл байгаа учраас энэ төслийг хэлэлцэх эсэхийг нь дэмжчихээд, харин Улсын Их Хурал дээр ахиад шинэчилсэн найруулгын төсөл бэлтгэх ажлын хэсэг байгуулагдаж ажиллаад, хаврын чуулган эхлэхээр энэ 2 төслөө хамтад нь хэлэлцээд явах замыг сонгох нь цаг хугацааны хувьд өндөр ач холбогдолтой байх гэж бодож байна. Тийм ээ. Тэгж ажиллах нь байна.

Тэгэхгүй бол гишүүдийн хүсэж байгаа хүсэл, өргөн барьсан төсөл дээрээс илүү өргөн хүрээгээр хандах гээд байгаа учраас. Өргөн барьсан төсөл мэдээж энийг хөндөж оруулж ирж байгаа нь маш зөв, цаг үеэ олчихсон нөхцөл байдал байна. Харин илүү өргөн хүрээгээр авч үзье гэж байгаа учраас тийм шийдэл рүү явах нь зөв байх гэсэн бодолтой байна. Шижир гишүүн санал нэгдэж байна уу? Маш сайн байна. Чинбатын Ундрам гишүүн асуулт асууя.

Ч.Ундрам: Энэ хууль үнэхээр манай Монгол Улсын хувьд маш чухал хууль. Манай хамгийн гол салбар болох хөдөө аж ахуй маш олон ард иргэдийн амьдралтай холбоотой ийм хууль учраас гишүүд маань нэлээн сайн анхаараасай гэж бодож байгаа юм. Өнөөдөр 10 малчин айлын 6 нь арилжааны банкнаас зээлтэй байгаа. Тэгээд энэ малчдыг хэрвээ зээл авах юм бол заавал энэ малын индексжүүлсэн даатгалд хамрагдсан байх ёстой гэдэг ийм шаардлагыг тавих юм бол дахиад энэ хүмүүсийн зардал нь нэмэгдэнэ. Тэгэхээр бид энэ заавал нэн хөнгөлөлттэй гэж байгаа юм. Гэхдээ хөнгөлөлттэй зээл ч гэсэн энд орж байгаа байхгүй юу. Тэгэхээр бидний хэрэгжүүлээд байгаа хүнсний хувьсгал, шинэ хоршоо

хөтөлбөр шууд энэтэй хамааралтай болж байгаа юм. Ер нь заавал ингэж даатгуулдаг болох биш, малчин хүн өөрөө би даатгуулах юм бол миний эрсдэл буурна, надад хэрэгтэй гэж боддог тийм тогтолцоог бид бүрдүүлэх ёстой гэж үзээд байгаа юм.

Тэгэхээр энэ хуулийн өөрчлөлтөөр нөхөн олговор олгодог босго үзүүлэлтийг давхар даатгалын компанийн саналаар тогтоодог болох юм бол энэ дээр чинь нөгөө таазны үзүүлэлт байхгүй болоод магадгүй сая хариулж байна. Зарим сумдад бид 4 хувь болгоно гээд. Зарим сумдыг нь аягүй бол 10 хувь, 15, 20 хувь болгох боломж нь бүрдчихэж байгаа байхгүй юу. Тэгээд энэ даатгалын компаниуд чинь ашигт ажиллагаагаа бодоод, яваандаа энэ босгыг өндөр болгож л таараа шүү дээ. Энэ хууль дээр та бүхний эрх зүйн байдал чинь ашгийн төлөө ийм байгууллага байгаа байхгүй юу ашгийн төлөө. Тэгээд даатгалын компаниудын оролцоотой. Энэ ташрамд хэлэхэд энэ 126 гишүүн дотор даатгалын компанитай, даатгалын компанийн ашиг сонирхолтой ийм хүмүүс зөндөө байгаа шүү. Энэ хүмүүс энэ хуульд санал өгөх эрхгүй шүү гэдгийг би хариуцлагатайгаар хэлмээр байгаа юм.

Миний асуулт энэ 37 тэрбум төгрөгийн хураамж аваад, 29, 7 тэрбум буцааж төлсөн гэдэг түрүүн ийм хариултыг хэлсэн л дээ. Та бүхний тарааж өгсөн материал дээр арай өөр дүн байгаа юм. Тэгэхээр энэ буцааж өгсөн 29 тэрбумын хэдийг нь Үндэсний давхар даатгал төлсөн юм бэ, гаргасан юм бэ, хэдийг нь даатгалын компаниуд гаргасан юм бэ, хэдийг нь олон улсын давхар даатгадаг компани чинь гаргасан юм бэ яг надад тэр задаргааг хэлээд өгөөч. Тэгээд Их Хурлын даргын саналыг бүрэн дэмжиж байна. Бид энэ дээр ажлын хэсэг байгуулаад эрс өөрчлөлт хийх ёстой. Мэдээж энэ хуулийг өөрчилье гэсэн санал санаачилга Сангийн сайдын санаачилгыг дэмжиж байна. Гэхдээ яг энэ орж ирсэн төслийг дэмжихэд учир дутагдалтай байна гэж үзэж байгаа.

Д.Амарбаясгалан: Асуултад хариулъя. Ажлын хэсгийн 2 дугаар микрофон Жавхлант.

Б.Жавхлант: Үндэсний давхар даатгал ХК Жавхлант. Ундрам гишүүний асуултад хариулъя. Үндэсний давхар даатгалын компани 7 даатгалын компанитай хамтраад хамтын эрсдэлийн сан буюу гамшгийн эрсдэлийн санг удирдаж явдаг. Өнгөрсөн хугацаанд нийт 29 тэрбум төгрөгийн нөхөн төлбөрийг олгосон. Үүнээс Үндэсний давхар даатгал компани олон улсын давхар даатгалын төлсөн нөхөн төлбөр 25 тэрбум төгрөг байж байгаа. 23 тэрбум төгрөг байж байгаа. Үлдсэн 6 орчим тэрбум төгрөг нь болохоор даатгалын компаниудын бүрдүүлсэн хамтын эрсдэлийн сангийн мөнгөн дүн байгаа.

Давхар даатгалаас бид ойролцоогоор 11 орчим тэрбум төгрөг олон улсын давхар даатгал 11 орчим тэрбум төгрөгийн нөхөн төлбөрийг авсан байгаа. Малчны малын индексжүүлсэн даатгалыг борлуулахтай холбоотой гардаг зардлын түвшин нэлээн өндөр байдаг. Бид 30-аас илүү хэтрүүлэхгүй байх шаардлага тавьдаг. Ингээд тооцоод үзвэл үндсэндээ давхар даатгалын сая өнгөрсөн 10 жилийн хугацаанд гарч байгаа энэ давхар даатгалын үзүүлэлт нэлээн хасах үзүүлэлттэй ийм даатгалын бүтээгдэхүүн байгаа юм. Хэрвээ босго үзүүлэлтийг илүү бууруулсан тохиолдолд мэдээж даатгалын нөхөн төлбөрийн хэмжээ нэлээд их өсөх ийм магадлал дүр зураг байгаа.

Д.Амарбаясгалан: Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн асуулт асууна. Алга байна. Хүрэлбаатарын Булгантуяа гишүүн асуулт асууя.

Х.Булгантуяа: Энэ их чухал хууль юм. Би энэ бараг хуулийн нэрээс нь авхуулаад ер нь бараг өөрчлөх ёстой гэж бодоод байгаа юм. Малын индексжүүлсэн даатгал гээд хуулиа яриад энд, тэнд очихоор бараг индексжүүлсэн гэж юу гэж байгаа юм гэдгээ тайлбарласаар байгаад энэ хуулийн ач холбогдол нь олон нийтэд таниулах ажил нь ч гэсэн уначхаад байгаа юм. 2018 онд Монголд гамшгийн эрсдэлийг бууруулах Азийн сайд нарын чуулган Монгол Улсын болсон Нэгдсэн Үндэстний Байгууллагын шугамаар. Тэгэхэд тэр олон улсын хурал дээр 1 дүгээрт ер нь байгалийн гамшиг улам их цаашдаа нэмэгдэнэ. Тэнд ялангуяа Ази хамгийн их өртөмтгий байна. Гэтэл Ази тивийн улс орнуудын хувьд 1 дүгээрт иргэдийнх нь амьжиргаа нь цаг агаараас ийм үүдэлтэй салбаруудад маш их ажиллаж байна. Амьжиргаанд нь их эрсдэлтэй байна.

2 дугаарт дахиад дээрээс нь нэмээд даатгалын тогтолцоо их муу байна. Тэгэхээр төр засаг дээр маш их ачаалал ирнэ. Үүнийгээ сайжруулмаар байна гэж хэлж байсан. Тэгээд бид түүнээс хойш яг үнэнийг хэлэхэд олигтой алхам ерөөсөө хийж чадсангүй. Ингээд л ганцхан байгалийн гамшиг зуд гэлтгүй бусад эрсдэлүүд гарахад хүртэл амь даатгал, үл хөдлөх хөрөнгийн даатгалаас авхуулаад манай даатгалын тогтолцоо бол төдийлөн сайн болж чадаагүй байна.

Дээрээс нь нэмээд зудын дараа ядуурал нэмэгддэг, халамж нэмэгддэг, хот руу нүүдэл нэмэгддэг. 2020 оны зудаар гэхэд бараг түүний дараагаар 40 орчим мянган иргэд хот руу нүүж ирсэн ийм тоон үзүүлэлтүүд байдаг. Тэгэхээр уг нь энэ үүнийг нэг бодлын эрсдэлийг хаах хамгийн том тогтолцоонуудын нэг. Гэтэл харамсалтай нь өнөөдөр энэ хууль бас орж ирээд л манай Улсын Их Хурлын гишүүд хүртэл үүнийг олон нийтэд очоод, малчдад яриад ач холбогдол, нэмэлт, өөрчлөлтийн ач холбогдлыг таниулахад аягүй хэцүү байна гэдэг чинь. Би нэг ийм хэдэн асуултууд асуух гэсэн юм. 1 дүгээрт малын индексжүүлсэн даатгалыг сумд хэн хариуцах вэ? Даатгалын компаниуд бүгдээрээ сумд энийг бол хувийн хэвшил л хийж таарах байх эсхүл. Тэгэхээр даатгалын компаниуд би сумд ажилтантай байна гэдэгт эргэлзэж байна. Сум болгоноос тэр хүнийг цалинжуулаад байх төдий дайны хэмжээний орлого олоод, ингээд үйл ажиллагаа тогтмол явуулна гэдэгт эргэлзэж байна. Тэгэхээр үүнийг хэн хариуцах хариуцах вэ? Тэр битгий хэл манай сумын татварын байцаагч зарим хүмүүс хүртэл зарим сумд үнэнийг хэлэхэд өөрийнхөө цалинг олохгүй байгаад байгаа байхгүй юу. Нэг ийшээ хараад хэдэн төрийн албан хаагчдынх нь цалинг нь тэртээ тэргүй систем дээрээс ХХОАТ-ыг нь суутгаад авчхаж байгаа юм. Аж ахуйн нэгж гээд байх юм нэг их байхгүй. Тэгээд хэдэн бууны татвар, тэр айлын машины татварын араас гээд хөөцөлдөөд явж байдаг. Тэгэхээр энэ даатгалыг чинь цуглуулах ажлыг, таниулах ажлыг хэн хариуцах вэ суман дээр?

Дээрээс нь нэгэнт би даатгалд даатгуулчихсан юм бол нөгөө талдаа надад өөр нэг эрсдэлээс үүсвэл авахаас өөр надад ямар нэгэн давуу байдал үүсэх үү? Жишээлбэл магадгүй вакцины эрүүлжүүлэх ч байдаг юм уу, вакцинжуулах ч байдаг юм уу ийм юманд малыг нь хамруулах, малчдыг нь эрүүл мэндийн үйлчилгээнд илүү их хөнгөлөлттэйгөөр хамруулах ч гэдэг юм уу ийм давуу байдал үүсэх үү?

Дээрээс нь нэмээд энэ түрүүн хэлсэн энэ нэрээсээ авхуулаад та бүхэн маань хараач. Жишээлбэл малын хөлийн татвар гэдгийг малчид ойлгоод байдаг байхгүй юу. Гэтэл энийгээ жишээлбэл малын эрсдэлийн даатгал ч гэдэг юм уу, арай нэг энэ сууж байгаа бид хэд хүртэл нэг арай ойлгохоор байчхаж болдоггүй юм уу? Ингээд 2016 оноос хойших бол би санаж байна. Жилд Засгийн газрын нөөц хөрөнгөөс 2, 3 тэрбум төгрөг гардаг байсан. Одоо бараг зудад 10 орчим тэрбум төгрөг гардаг бараг болж байгаа жилд. Дандаа эрсдэлээс үүдээд. Малын тоо толгой ч нэмэгдэж байна. Дээрээс нь нэмээд эрсдэл давхар нэмэгдээд байгаа учраас үүнийг бид хамруулахаас өөр арга байхгүй. Харин үүнийгээ дагаад ноос, ноолуурын урамшуулал, сүүний урамшуулал гэдэг энэ урамшууллуудтайгаа та бүхэн маань уяж өгөхгүй юм уу асуулт нь?

Тэгээд мал сүрэг бол үндэсний баялаг бөгөөд төрийн хамгаалалтад байна гээд Үндсэн хуульдаа оруулсан мөртөө мал бол гамшигт өртөх юм бол нөхөн төлбөр олгоно. Хүн болохоор.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Ажлын хэсгийн 20 дугаар микрофон.

Б.Жавхлант: Үндэсний давхар даатгал ХК гүйцэтгэх захирал Жавхлант. Булгантуяа гишүүний асуултад хариулъя. Малын индексжүүлсэн даатгалын бүтээгдэхүүнийг сум, сумын түвшинд хуулийн дагуу Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн 27 дугаар зүйлд заасны дагуу бүх шатны Засаг дарга хуулийн хэрэгжилтэд хяналт тавих үүрэг хүлээдэг. Хувийн хэвшлийн яг энэ борлуулалтын түвшинд даатгалын компаниудад 330 сумд даатгалын төлөөлөгч ажиллаж байгаа. Даатгалын төлөөлөгч маань орон тооны бус өөрийнхөө орлогоос тодорхой хувь хэмжээгээр санхүүжиж цалинждаг ийм даатгалын төлөөлөгчид 330 сумд ажилладаг байж байгаа. 7 даатгалын компанийн давхар ойролцоогоор 1000 гаруй даатгалын төлөөлөгч 330 сумд ажиллаж байгаа. Эдгээр нь болохоор зөвхөн малын индексжүүлсэн даатгалын бүтээгдэхүүн төдийгүй нөгөө жолоочийн албан журмын даатгал болоод бусад төрлийн даатгалыг борлуулж, борлуулсан орлогоосоо тодорхой хувь хэмжээгээр цалинждаг ийм төлөөлөгчид ажилладаг.

2 дугаарт нь даатгалд хамрагдсан тохиолдолд өнөөдрийн хувьд хүчин төгөлдөр байж байгаа хууль тогтоомжийн хүрээнд ямар нэгэн хөнгөлөлт, урамшууллын тогтолцоо бол хараахан бүрэлдээгүй байгаа. Энэ жилийн хувьд бид даатгалын компаниудтайгаа ярьж байгаад түрүүн хэлсэнчлэн малчдын гэнэтийн осол, ялангуяа энэ цаг уур амьсгалын хүндрэлтэй, бэрхшээлтэй үед амьдардаг малчдыг гэнэтийн осолд энэ даатгалыг хажууд нь хавсарга болгож хамруулах энэ боломжийг бий болгох тал дээр даатгалын компанитай хамтарч ажиллаж байгаа. Энэ нь бол нөгөө талаараа бас нэг төрлийн хөнгөлөлт болох болов уу гэсэн ийм хүлээлттэй байгаа.

3 дугаарт нь ноос, ноолуурын болоод бусад төрлийн төсвөөс олгож байгаа хөнгөлөлт, татааснууд дээр малчдын хувьд бид малчдын хувьд татгалзах зүйлгүй гэсэн хариултыг ихэнх малчид өгдөг. Яг одоогийн байдлаар хүчин төгөлдөр байж байгаа хууль тогтоомжийн хүрээнд малчдын ноос, ноолуур болон бусад төрлийн тэтгэвэр, тэтгэмжийн урамшууллаас шууд суутган тооцох энэ хууль, эрх зүйн орчин хараахан бүрдээгүй байгаа.

Д.Амарбаясгалан: Булгантуяа гишүүн тодруулж асууя.

Х.Булгантуяа: Тэгвэл та хэд чинь хууль дээрээ болохоороо банк бол олгох зээлдээ үүнийг нэг нөхцөл болгоно гэхихсэн байж байгаа. Гэтэл хувийн хэвшил олгож байгаа өөрийнхөө зээллэгт та нар оруулчихсан байгаа мөртөө төрөөс олгож байгаа бүх дэмжлэг, янз янзын татаасанд энэ бол нөхцөл болохгүй юм байна шүү дээ. Тэгвэл энэ хэрэгжих хөшүүрэг муутай л юм байна нөгөө талдаа. Нэгэнт би малын даатгалд хамрагдахгүй байлаа гээд надад ямар нэгэн бараг л эрсдэл үүсэхгүй. Би авдаг үйлчилгээгээ аваад л, банк үүнийг заавал дагаж мөрдөх албагүй, хувийн хэвшил л өөрөө өөрийнхөө зээлийг олгодгоороо олгоно. Тэгэхээр наадах чинь ер нь бараг хэрэгжих юу бага юм биш үү 1 дүгээрт?

2 дугаарт энэ түрүүний би асуусан нөгөө даатгалд хамрагдлаа гээд давуу тал малчин хүнд ч гэсэндээ үүсэхгүй бол энэ тэгээд л хэрэгжих боломж их муутай шүү дээ. Одоо та бүхэн 1000 орчим хүмүүс сумд ажиллаж байна л гэж байна. Одоо дөнгөж 7-гоос 10 хувь даатгалд хамрагдсан байна гэдэг чинь 1000 орчим хүн хүний чинь.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Асуултад нэмж хариулъя. Ажлын хэсгийн 20 дугаар микрофон.

Б.Жавхлант: Булгантуяа гишүүний асуултад нэмж хариулъя. Энэ банкны Малчны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орж байгаа хууль бол банкны хувийн эх үүсвэрээр олгож байгаа зээл, зээлтэй бол огт хамааралгүй. Улсын төсвөөс санхүүжилт олгогддог нэн хөнгөлөлттэй зээл, зээлд хамрагдсан малчин даатгалд хамрагдах ийм зохицуулалтыг оруулж өгч байгаа. Ингэснээрээ зэрэг төсөвт эргэн төлөгдөх зээлийн эх үүсвэрийн баталгаа болж байгаа мал сүргийг л даатгалд хамруулах ийм үндсэн зорилго, төсвийн эрсдэлийг бууруулах л ийм үндсэн зорилгыг агуулж байгаа.

Д.Амарбаясгалан: Мэндбаярын Мандхай гишүүн асуулт асууя.

М.Мандхай: Хөдөө аж ахуйн ажлын хэсгийн хүрээнд орон нутагт бид явж малчид шинэ хоршооны малчидтай уулзалт хийгээд, саяхан жишээлбэл Төв аймагт бид ажиллаад ирсэн. Малчдын ярьж байгаа гол хөндөж байгаа сэдвийн нэг нь яах ч арга байхгүй энэ малын индексжүүлсэн даатгалтай холбоотой асуудал байгаа. Ер нь нэлээдгүй бухимдалтай, нэлээдгүй бухимдалтай хүлээж авч байгаа. Тэгээд гол хэлж байгаа, захиж хэлж байгаа зүйл ерөөсөө энэ сумдын малын хорогдол 6 хувьд хүрсэн тохиолдолд нөхөн төлбөрт хамрагдах асуудал. Малчид бид малаа хорогдуулъя гэж мал малладаггүй. Хэрэглээний өндөр хүүтэй зээлээ аваад, хашаа хороогоо, мэдээж өвс тэжээлээ бэлтгэж ажиллаж байгаа. Тэгэхээр малын хорогдол мэдээж үүсэхээс сэргийлж энэ өндөр хүүтэй зээлийг авдаг. Тэгэхээр энэ 6 хувь хэт өндөр амьдралд нийцэхгүй байгаа учраас бид ер нь даатгуулах сонирхол ч байхгүй байна гэдгийг удаа дараа хэлж ирсэн.

Би тэгээд энэ хуультай холбоотой нэг хэдэн анхаараач гэсэн асуудлуудыг хөндмөөр байна. Тэгээд тодруулж асуух зүйл байна. Энэ төсөл дээр болохоор малын давхар даатгалын компани гэх тодотголыг хасаж байгаа тийм ээ, малын гэдэг үгийг хасаж байна. Тэгээд энэ өөрчлөлт нь болохоор энэ давхар даатгалын компаниудыг зөвхөн малын даатгалд биш, бусад даатгалын бүтээгдэхүүн, үйлчилгээнд өргөн хүрээнд ажиллах ийм боломжийг олгож байгаа юм байна гэж

ойлгож байна. Тэгэхээр энэтэй холбоотой нэг ийм асуудал байгаад байгаа юм. Үндсэндээ үйл ажиллагааны тодорхой чиглэл, хариуцлагын төвлөрөл сулрах ийм эрсдэлтэй харагдаад байгаа. Илүү малын гэдэг нэр томъёог аваад хаячихаар. Тэгэхээр энэ малын даатгалын үйлчилгээг нь сулруулахгүй байх дээр яг ямар зохицуулалт хийж, яаж ажиллаж байгаа юм бэ гэдэг дээр хариулт өгөөч?

2-т нь болохоор энэ урьдчилан нөхөн төлбөр олгох зохицуулалт орж ирсэн. Яах вэ нэг талдаа сайн талтай боловч нөгөө талдаа эрсдэлтэй зүйл харагдаж байна. Малчдад шуурхай санхүүгийн дэмжлэг үзүүлэхээр байгаа юм байна тийм ээ. Малчид урьдчилан нөхөн төлбөрөө аваад өвс тэжээлээ бэлтгэх, хашаа хороогоо засварлах ч гэдэг юм уу энэ дээр цаг алдахгүй хийх юм байна.

2 дугаарт даатгалын компанийн бас эрсдэл буурахаар юм байна гэж харж байна. Нэг талдаа даатгалын компаниуд ирээдүйд гарах тэр өндөр хэмжээний нөхөн төлбөрөө урьдчилаад өгчих юм бол бууруулж байгаа юм байна. Ийм санхүүжилтийн механизмыг та бүхэн олгож байгаагаараа давуу талтай гэж харж байгаа. Тэгэхдээ нэг эрсдэл байгааг анхаармаар байна. Тухайн сумдын малын хорогдол хуульд заасан босго үзүүлэлтэд хэрвээ хүрээгүй тохиолдолд урьдчилан олгосон нөхөн төлбөрийг буцаан нэхэмжлэх ийм төвөгтэй асуудал үүсэх вий дээ. Ийм асуудал үүсэх магадлал харагдаж байгаа юм. Тэгээд энийг шийдвэрлэхэд ямар зохицуулалттай хуулийн төсөлд илүү нарийвчлан тусгасан юм бэ? Энэ дээр нэг хариулт өгөөч.

Түрүүн босго үзүүлэлтийг хэлсэн. Энэ дээр яах вэ давхар даатгалын компанийн санал олгож байгаагаар босго үзүүлэлтийг ЗГ тогтоож байгаа. Гэхдээ нэг зүйлийг хэдүүлээ анхаарахгүй бол давхар даатгалын компани өөрөө төрийн өмчит бөгөөд Сангийн яамны шууд оролцоотой байдаг. Тэгэхээр энэ өөрөө нөгөө хараат бус оролцоог хангахын тулд илүү СЗХ болон мэргэжлийн энэ актуарчдын тооцоолол дээр үндэслэж, тэдний авсан санал дээр үндэслэж байгаад энэ босго, босгыг тогтоодог яасан юм бэ гэдэг саналыг хэлмээр байна. Тэгээд эцэст нь хуулийн төсөлд энэ мэдээж тусгагдаж байгаа өөрчлөлтүүдийг бол мэдээж бид малчдын эрх ашгийг хамгаална. Нөгөө талдаа даатгалын системийг уян хатан.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Ажлын хэсгийн 20 дугаар микрофон.

Б.Жавхлант: Үндэсний давхар даатгал ХК гүйцэтгэх захирал Жавхлант. Мандхай гишүүний асуултад хариулъя. Хуулийн төсөлд орж байгаа өөрчлөлтөөр малын гэдэг үгийг хасаж байгаа. Ингэснээрээ яах вэ одоо бол үндэсний давхар даатгалын тогтолцоог хөгжүүлэх, бэхжүүлэх, цаашдаа гамшгийн эрсдэлийн давхар даатгалын тогтолцоог бэхжүүлэх энэ асуудал манай улсын урт хугацааны хөгжлийн баримт бичгүүдэд тусгалаа олсон байдаг. Ийм учраас Монгол Улсад байж байгаа төрийн өмчийн оролцоотой цорын ганц давхар даатгалын компанийн хувьд энэ гамшгийн эрсдэлийн давхар даатгалын тогтолцоог бэхжүүлэх, үндэсний давхар даатгалын тогтолцоог зөвхөн малын биш бусад төрлийн гамшгийн эрсдэлүүдийг давхар даатгахад бэхжүүлэх энэ чадавхаа бэхжүүлэх зорилгоор энэ Үндэсний давхар даатгал ХК 2019 онд өөрчлөн зохион байгуулсан юм.

Тэгээд үүнтэй холбоотойгоор бусад төрлийн гамшгийн эрсдэлийг нь даатгах ийм боломж бололцоо бүрдэж байгаа. Харин малын гэдэг үгийг хассанаараа энэ

малын индексжүүлсэн даатгалд тавигдах хяналт сулрах уу гэдэг асуудлын хувьд бол тийм зүйл огт байхгүй. Малын индексжүүлсэн даатгалын тухай хуульд зааснаар Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн хэрэгжилтэд Үндэсний давхар даатгалын компани нь хяналт энэ 18-д, 18.1-д заасан давхар даатгалын компани хяналт тавих үүрэгтэй гээд хуульд байгаа. Тэр хууль маань хэвээрээ үргэлжлээд цаашаа явна.

2 дугаарт нь хагас жилийн мал тооллогын дүнгээр урьдчилж олгосон тоо буюу буцаахаар болох тийм тохиолдол байх уу гэдэг ийм юм асууж байгаа. Яг одоо өргөн мэдүүлсэн хуулийн төсөл дээр олгосон нөхөн төлбөрийг буцаан нэхэмжлэх ямар нэгэн зохицуулалт буюу буцаан нэхэмжлэхгүйгээр энэ асуудлыг хуульчлан оруулсан байж байгаа.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Хууль тогтоолын төслүүдийн талаар Байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг дэмжсэн, эсрэг байр суурьтай намын бүлгийг төлөөлж болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу үг хэлнэ. Байр сууриа илэрхийлж. 3 гишүүний нэр ирсэн байна. 3 гишүүнээр тасална. Ренчинбямбын Сэддорж гишүүн үг хэлнэ. Алга байна. Ганбаатар гишүүн, Батын Батбаатар гишүүн алга байна. Үндсэндээ асуулт дээр үг давхардсан гэж байна. Үг хэлэх асуудал дууслаа.

Санал хураана. Одоо тэгэхээр ингэе, манай гишүүд танхимдаа орж ирж байна уу? Санал хураалт явна. Засгийн газраас уг хуулийн төслийг өргөн барьсан нь өөрөө цаг үеэ олсон зөв алхам гэж Улсын Их Хурлын гишүүд нийтдээ дүгнэж байна. Гэхдээ яг энэ үзэл баримтлалынх нь хүрээнд хэлэлцээд явахаар учир дутагдлууд бас байна гэж бас гишүүд дүгнэж байна. Тэгэхээр бидэнд 2 сонголт байгаа. 1 дүгээрт нь үзэл баримтлалынх нь хүрээнд хэлэлцэхгүй гээд дэмжихгүй байх нэг сонголт байна. Хэрвээ бид үзэл баримтлалынх нь хүрээнд хэлэлцэхгүй гээд шийдчих юм бол Улсын Их Хурлын дэгийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 13, 14 дэх заалтын дагуу дахин нэг жилийн хугацаанд өргөн барихгүй байх нөхцөл үүсэх юм байгаа юм.

Тэгэхээр гишүүдийн сая гаргаж байсан саналын дагуу өргөн баригдсан төслийг үзэл баримтлалынх нь хүрээнд дэмжих нь зүйтэй гэж шийдвэрлээд, харин Улсын Их Хурлын зүгээс Улсын Их Хурлын даргын захирамжаар уг хуулийн төслийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах Улсын Их Хурлын гишүүдээс бүрдсэн ажлын хэсгийг яаралтай байгуулаад, хаврын чуулган эхлэх хүртэлх хугацаанд төсөл дээр ажиллуулна. Ажиллахдаа орон нутгаас сонгогдсон гишүүд, дан ганц орон нутгаас сонгогдсон гэлтгүй гишүүд малчидтай газар дээр нь хэлэлцүүлгийг зохион байгуулж, саналыг нь энэ индексжүүлсэн даатгалын нөхцөл байдал ер нь амьдралд хэр нийцэж байгаа юм, нийцэхгүй байгаа учир шалтгаанууд нь юу талаар өргөн хүрээний хэлэлцүүлгийг зохион байгуулсны үндсэн дээр хуулийн төслийн шинэчилсэн найруулгыг бэлтгэж, чуулганаар өргөн барина. Ингээд хаврын чуулган эхлэх үе дээр энэ хуулийн дэмжигдсэн байгаа хуулийн төслийн үзэл баримтлалын хүрээнд болон шинээр Улсын Их Хурлын гишүүдээс өргөн барих шинэчилсэн найруулгын төсөл хоёрыг хамтад нь хэлэлцээд, хаврын чуулгандаа багтаж баталъя гэсэн ийм саналыг Улсын Их Хурлын гишүүд гаргалаа гэж ингэж ойлгож байгаа юм.

Тийм учраас Улсын Их Хурлын гишүүд уг хуулийн төслийн хэлэлцэх эсэх дээр дэмжих байр суурьтай оролцох нь зүйтэй болов уу гэсэн ийм саналтай байна. Ингээд ирц бүртгэлийн санал хураалт явуулаадахъя, байна уу? Ирц бүртгэлийн санал хураалт явуулаадахъя. Ирц бүртгэлийн санал хураалт. Гишүүд санал хураалтад идэвхтэй оролцъё. Дахин санал бүртгэлийн, ирц бүртгэлийн санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад орж чадаагүй 1, 2, 3 гишүүн байна. Тэгэхээр санал хураалт явуулах боломжтой гэж үзээд Байнгын хорооны саналаар Малын индексжүүлсэн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх талаар санал хураалт явуулна.

Санал хураалт. Байнгын хорооны саналаар Малын индексжүүлсэн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт. 51,7 хувиар санал дэмжигдлээ.

Хамт өргөн мэдүүлсэн Малчны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт. 53,9 хувиар санал дэмжигдлээ. Малын индексжүүлсэн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг гишүүдийн олонх дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүллээ. Ажлын хэсэг 2 түвшний ажлын хэсэг байгуулагдана. Гишүүд саналаа өгөөрэй. 1 дэх нь энэ хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн учраас энэ дэмжигдсэн хуулийн төслийг хариуцаж ажиллах ажлын хэсэг нэг тусдаа. Дахиад гишүүдийн санаачилгаар Малын индексжүүлсэн даатгалын хуулийн төслийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах Ажлын хэсэг байгуулагдана. Энэ ажлын хэсэгт орох саналыг Улсын Их Хурлын гишүүд өнөөдрийн дотор ирүүлээрэй. Ажлын хэсгээ өнөөдөр байгуулна.

12.34 цаг

Гурав. “Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд хийх төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглавар батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Хэлэлцэх асуудал дараагийн асуудалд оръё. Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд хийх төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглавар батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ. Төслийн талаарх ТББХ-ны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Баярмагнайн Баярбаатар танилцуулна. Индэрт урьж байна.

Б.Баярбаатар: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу Байнгын хороодоос ирүүлсэн саналуудыг тусган ТББХ Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд хийх төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглавар батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулж, 2025 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн хуралдаанаараа дээрх

тогтоолын төслийг хэлэлцээд дараах санал, дүгнэлт, Улсын Их Хурлын тогтоолын төслийг нэгдсэн хуралдаанд оруулж байна.

Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд хууль тогтоомжийн биелэлтийг хянан шалгах, хууль тогтоомжийн биелэлтийн үр дагаварт үнэлгээ хийх, тайлан, илтгэл, мэдээлэл хэлэлцэх, төсвийн биелэлтийг хянан шалгах, хяналтын шалгалтын бусад асуудал зэрэг нийт 34 асуудлыг төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглаварт тусгасан болно.

Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд хийх төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглавар батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжиж, Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж батлуулах нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд хийх төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглавар батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцсэн талаарх ТББХ-ны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж, тогтоолын төслийг баталж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал хандуулсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Байнгын хорооны санал, дүгнэлт танилцуулсан Баярбаатар гишүүнд талархал дэвшүүлье. Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгье. Алга байна. Гишүүд, Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд хийх төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглавар батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Ирц боломжийн байгаа тийм ээ? Санал хураалт. Би өөрөө санал өгч чадсангүй шүү дээ. Дүнгээ танилцуулаагүй юм чинь санал хураалтаа цуцалчхаж болно тийм ээ, төхөөрөмж, дэмжигдчихсэн юм уу? 55,1 хувиар санал дэмжигдлээ. Тогтоолын төсөл батлагдлаа. Улсын Их Хурлын гишүүддээ талархал дэвшүүлье. Одоохон ганцхан санал хураалт. Засгийн хурал эхлэх гээд гишүүдийг дуудаад байгаа юм байна.

12.39 цаг

Дөрөв. “Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Дараагийн асуудалд оръё. Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ. Төслийн талаарх ТББХ-ны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Ёс зүй, дэгийн байнгын хорооны дарга Баярмагнайн Баярбаатар танилцуулна. Индэрт урьж байна.

Б.Баярбаатар: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.4 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5, 45 дугаар зүйлд заасны дагуу Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг ТББХ-ноос боловсруулж, 2025 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцлээ.

Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулахдаа Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад батлах хугацааг нь хуульд тусгайлан заасан болон Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг оруулна гэж заасны дагуу хэлэлцэх асуудлын жагсаалтад 6 хууль, тогтоолын төслийг тусгасан болно.

Тогтоолын төсөлд Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүд, Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн тогтоолын нэг дэх заалтад зааснаас бусад хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслүүдийг Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцүүлэх эсэх асуудлыг тухай бүрд нь Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсэгт заасны дагуу шийдвэрлэж байхаар зохицуулсан байна. Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанд хэлэлцүүлж, батлуулах нь зүйтэй гэсэн саналыг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх ТББХ-ны санал, дүгнэлтийг хэлэлцэн тогтоолын төслийг баталж өгөхийг та бүхнээсээ хүсье. Анхаарал хандуулсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Баярбаатар гишүүнд талархал дэвшүүлье. Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асуух, үг хэлэх гишүүд байна уу? Алга байна. Гишүүд нэг бүрчлэн саналаа бичгээр ирүүлчихсэн юм чинь. Жигжидсүрэнгийн Чинбүрэн гишүүн, өөр гишүүд байвал нэр авчихъя, авчихъя. Жигжидийн Батжаргал гишүүн 2. Үг хэлье, асуулт асууж, үг хэлнэ.

Ж.Чинбүрэн: Эрхэм гишүүддээ энэ өглөөний мэнд хүргэе. Их Хурлын даргад бүр онцгойлон би энэ хэлэх гэсэн зүйл байна. Бид түр хороо байгуулаад л олон нийтийн сонсгол хийгээд, тогтоол гаргаад л, тэр тогтоолынхоо хэрэгжилтийг сонсож чаддаггүй Их Хурал болчихоод байна. Нэг ёсондоо Их Хурлын өөрийнх нь чадамж энэ Засгийн газарт өгч байгаа тогтоол шийдвэрүүд, үүрэг даалгаврын биелэлтийг сонсож чаддаггүй ийм байдал үүсэж байгаа учраас энэ дээр Даргын зөвлөл дээрээ нэг онцгой анхаараач. Ялангуяа өнгөрсөн хавар хийсэн эмийн сонсголтой холбоотой 2 ч тогтоол гарсан. Тэгтэл энэ 2 тогтоолын асуудлыг энэ намрын чуулганд багтааж Нийгмийн бодлогын байнгын хороонд танилцуулах ёстой байтал нэг ч танилцуулаагүй. Нэхээд байхад л энэ байхгүй. Бүлгийн даргаар дамжуулаад хүртэл би асуулгасан. Ерөөсөө хариу байхгүй таг чиг.

Ингэхээр чинь энэ Их Хурлын гаргаж байгаа шийдвэр, тогтоолууд чинь өөрөө үнэ цэнгүй байгаад байгаа. Эмийн сонсгол дээр болсон явдлыг би хэлэх юм бол бүр АТГ дээр хүртэл яллагдагчаар татагдаж байсан хүнийг аваачаад л Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын даргаар томилж байна шүү дээ. Ийм байж болох юм уу Их Хурлын даргаа? Энэ Эрүүл мэндийн сайд хаана байна вэ? Ийм байдлаар ийм улсуудыг томилж, эрүүл мэндийн салбарыг хөгжүүлэх биш хоцроосон ийм улсуудын албан тушаалыг тавиад байдаг, нэг ёсондоо энэ чинь улс төрийн албан тушаал хашдаг эрхтэн мэдэлтнүүдийн сэлгээд суудаг ийм талбар болчихоод байгаа юм уу? Эрүүл мэндийн салбараар ингэж тоглож болохгүй. Хамгийн мөнгөний авдрыг нь сахиад суух хүнийг нь ингээд тавьж байна гэдэг чинь ямар учиртай юм бэ? Энд хариулт авмаар байгаа юм. Иймэрхүү байдлууд гарч байгаа нь өөрөө Их Хурлын өөрийнх нь легитив чанарыг алдагдуулж байна шүү дээ.

Би ахиад нэг юм Тэмүүлэн гишүүн бид хэдийн бас нэг санаачлаад баталсан энэ Монгол хүний удмын сангийн аюулгүй байдлыг хамгаалах, хүн амын өсөлтийг дэмжих талаар авах арга хэмжээний тухай тогтоол баталсан, 22 онд. Нэг ч асуудлаа ярьж шийдээгүй, өнөөдөр 25 онд ургийн удмын сангийн нөгөө дэвтэр хөтлөлт энэ тэр чинь хаана байгаа юм бэ гэх мэтчилэнгээр энэ бол ерөөсөө төрийн үйл ажиллагаа өөрөө алдагдаад, хариуцлага тооцдоггүй энэ байдал чинь ард иргэдийн бухимдаад байгаа зөв шүү дээ. Ийм байдалтай бид байж болохгүй. Тийм учраас энэ хаврын чуулганаар та бүр энийг онцгой анхаарч өгөөч. Энэ олон тогтоолуудынхаа хэрэгжилтийг бид шаардъя, нэхье. Одоо бид утааны сонсгол нийтийн сонсголыг 2 сарын 3, 4-нд хийе. Иргэд асууж байгаа шүү дээ. Тэгээд та нар сонсгол хийгээд үр дүн юу гараад байгаа юм бэ л гээд асуугаад байна. Бид мундаг, мундаг тогтоолууд гаргаж байна. Үнэхээр амьдралд хэрэг болохоор. Тэрнийхээ хэрэгжилтийг сонсож чаддаггүй ийм Их Хурлын гишүүд байж болох юм уу, ийм Их Хурал байж болох юм уу даргаа? Энийг бүр онцгой анхаарч өгөөрэй.

Д.Амарбаясгалан: ТББХ-ны дарга Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн.

Ж.Бат-Эрдэнэ: Чинбүрэн гишүүнтэй санал нэг байгаа юм. Бид нэлээн олон сонсгол хийсэн. Сонсголын үр дүнгүүд ерөөсөө гарч ирэхгүй байгаа. Уг нь бид Хяналт шалгалтынхаа тухай хуульд, Улсын Их Хурлын хяналт шалгалтын хуульд оруулаад, сонсгол хийдэг, аливаа олон нийтийн анхаарлын төвд байгаа асуудлуудыг татаж авч сонсгол хийдэг, үүгээрээ бол ард иргэдэд мэдээлэл өгдөг. Тэгээд энэнийхээ үр дүнг хууль хяналтын байгууллагуудад өгдөг ийм их зарчим руу орсон шүү дээ. Энэ бол жишээ нь Улсын Их Хурлын хяналт шалгалтын энэ үйл ажиллагаанд асар том алхам хийсэн ийм өөрчлөлтийг бид хийж чадсан юм.

Гагцхүү энэний үр дүн нь гарч ирэхгүй байгаад байгаа юм. Тийм болохоор Чинбүрэн гишүүнтэй би энэ талаар ярилцаж байсан. Ер нь сонсголуудаар гарсан энэ бүх тайлангаа хууль хяналтын байгууллагад өгөөд, хууль хяналтын байгууллага буцаад Улсын Их Хурал дээр нэг тайлан тавьдаг хуульдаа нэг ийм байдлаар өөрчлөх зайлшгүй шаардлага гарч ирээд байгаа юм. Тэгээд сонсголын үр дүнгээр ийм, ийм асуудлуудад эрүүгийн хариуцлага татсан, ийм, ийм асуудлуудад хэрвээ шаардлагатай бол бид цагаатгасан байдаг юм уу, юу байдаг юм, ямар нэгэн байдлаар энэ сонсголтой холбоотой асуудлууд дээр хууль хяналтын байгууллагууд тодорхой хэмжээний дүгнэлтээ гаргаж ирээд, тайлангаа

юм уу, жишээ нь тайлан сонсгол ч байдаг юм уу буцаад Улсын Их Хурал дээр тайлан тавьж байдаг, тэр нь ард иргэдэд мэдээллээ өгч байдаг байдлаар хуульдаа өөрчлөлт оруулъя гэсэн байдлаар ТББХ-н дээр нэг ярилцаад явж байгаа юм шүү. Энийг мэдээлэл өгчихье.

Тэгээд хаврын чуулган дээр орж ирээд бид энийг хуульд нь өөрчлөлт оруулаад явъя гэсэн ийм бодолтой байж байгаа шүү. Тэгвэл бид бүх мэдээллээ хууль хяналтын байгууллага дээр яагаад тэр хүмүүст хариуцлага тооцохгүй ингээд бултаад алга болчихдог юм, эсвэл тавиад явуулчихдаг юм гэдэг нэг ард иргэдийн хүлээлтэд бол хариулт өгөх ёстой юм гэсэн нэг ийм байдалтайгаар шийдэх зүйтэй юм гэж үзэж байгаа юм.

Д.Амарбаясгалан: Жигжидийн Батжаргал гишүүн асуулт асууя.

Ж.Батжаргал: Улсын Их Хурлын хаврын чуулганаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөөг дэмжье. Гэхдээ бүрэн эрхийн хугацааны энэ гарааны жилүүд дээр энэ бүрэн эрхийн хугацаанд дэвшүүлсэн тэр хөгжлийн том зорилтуудынхаа суурийг хангаж чадах салбарын суурь хуулиудаа эхэлж оруулж ирмээр байна. Бид хэд чинь өргөн баригдчихсан гэдэг юм уу, хэлэлцүүлгийн шатад яваа гээд тэр салбарын суурь хуулиудын мөчир болох хуулиудыг яриад ерөөсөө болж өгөхгүй байгаад байна шүү дээ. Байдаг цаг тэр лүү явчхаад байдаг.

Өмчийн харилцаа, үндсэн суурь хууль нь орж ирдэггүй. Тэрний нэг мөчир хууль орж ирчхээд ингээд яваад байдаг ч гэдэг юм уу. Байгаль орчны багц хууль бараг 3, 4 жил яригдаад орж ирэхгүй байгаа. Энийгээ хэзээ оруулж ирэх юм бэ? Энэ газрын харилцааны шинэтгэлийн асуудал байна. Энэ хэзээ орж ирэх гээд байгаа юм бэ? Энэ хөдөө аж ахуйн салбарыг хөгжүүлэе гэж яриад байгаа. 3 том хуулийн төсөл хоорондоо уялдаатай гарч ирэх юм уу гэж хараад байгаа. Хөдөө аж ахуйн салбарын хөгжлийн хууль байх гээд байх шиг байгаа юм, Хөнгөн үйлдвэрийн хууль байх гээд байх шиг байгаа юм, Хүнсний хуулийн асуудал байх гээд байх шиг байгаа юм. Энийг системтэй гэдэг юм уу даа, салбарын системтэй хуулийн шинэтгэлийн асуудал байгаад байна л даа бидэнд.

Тэрнээс хэн нэгний өргөн барьчихсан янз бүрийн хуулиуд яриад байхын оронд салбараа нэг бүхэл бүтнээр нь харж, системтэй эрх зүйн шинэтгэлээ тэр хөгжлийнхөө концепцтой нийцүүлж хийх тухай асуудал бидний хамгийн гол зүйл байгаад байгаа юм биш үү? Энэ рүү яаж асуудал чиглэгдэх вэ гэдэг зүйл л байгаад байна. Би энэ талынх нь асуудлыг илүүтэй энэ 25 оны хаврын чуулганы хугацаанд хараасай. Тэгж чадах юм бол 26, 27, 28 оны эхний хагаст энэ нэг яриад байгаа юмнууд чинь нэг жоол зүг чигээ зөв олж, цэгцэрсэн хөдөлгөөн рүүгээ явах болов уу гэж бодоод байх юм.

Д.Амарбаясгалан: Батжаргал гишүүнтэй ёстой нөгөө 100 хувь санал нэг гэдэг шиг санал маш өндөр хувиар нэг байгаа юм. Энэ Хууль тогтоомжийн хуулиар хуулийн төсөл санаачлах эрх боломжуудыг нэлээдгүй Улсын Их Хурлын гишүүдийг нэлээдгүй хязгаарлаад, ихэнх хуулийн төслүүдийг Засгийн газраас л санаачилж өргөн барих ийм зохицуулалт байгаад байгаа юм. Тийм учраас Батжаргал гишүүн асууж байна шүү дээ. Оруулж ирэхгүй юм уу гэж асуугаад байгаа юм. Одоо бол бид өөрсдөө оруулж ирэх ёстой байхгүй юу. Олон нийт биднийг яг л тэгж шүүмжилж байна. Яриад л байх юм, яриад л байх юм.

Тэгээд өөрчлөлтөө хийгээч гэхээр дахиад гишүүд нь танхимд орж ирэхээрээ оруулж ирэхгүй юм уу гээд ингээд асуугаад шахаад сууж байдаг ийм байдал байгаа учраас Дамдины Цогтбаатар гишүүнээр ахлуулсан ажлын хэсэг нөгөө Их Хурлын даргын захирамжаар олон ажлын хэсэг байгуулагдсан гээд зарим хүмүүс шүүмжилдэг юм. Гэхдээ энэ ажлын хэсгийн хамгийн том хуулийн төслийг боловсруулж байгаа ажлын хэсэг одоо хуулийн төслөө өргөн барьж байна. Тэр бол Хууль тогтоомжийн хуулийн төсөлд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг өргөн барьж байгаа юм. Энэ нэмэлт, өөрчлөлтийн төслөөр Улсын Их Хурлын гишүүд хууль санаачлах бүрэн эрхээ бүрэн олж авч, олон томоохон хуулиудыг хамтарч санаачилж, өөрчлөлт оруулах боломжуудыг хийхийг зорьж байгаа юм.

Энийгээ бид хийж авсны үндсэн дээр энэ суурь болсон том хуулиудыг Засгийн газартайгаа зөвшилцөж, Засгийн газрын мэргэжлийн яамны зөвшөөрөл дэмжлэгтэйгээр хамтарч ажиллах нөхцөлөө бүрдүүлж, эдгээр хуулиудын өөрчлөлт рүү алхам хийж эхэлнэ. Яалт ч байхгүй сууриар нь асуудалд өөрчлөлт шинэчлэлтийн асуудалд хандахгүй бол өнгөц хэлбэрийн өөрчлөлт шинэчлэлтүүд үр дүн гаргаж чадахгүй байна. Хуулиас давсан журам, хэм хэмжээ тогтоож байгаа актуудыг цэгцлэхгүйгээр цаашдаа энэ олон нийтийн уур бухимдлыг бид дарж чадахгүй нь. Нийгэмд үүсгээд байгаа ялгавартай байдал, төрд үүсээд байгаа хүнд суртал, төрийн албанд байгаад байгаа одоог хүртэл амьд байгаад байгаа энэ авлигын асуудлыг бид энэ хууль, эрх зүйн орчны том өөрчлөлт, шинэчлэлтийг хийж байж цэгцлэхгүй бол болохгүй гэдэг нэгдсэн дүгнэлттэй болсон.

Тийм учраас энэ Улсын Их Хурлын даргын захирамжаар байгуулагдсан 60 гаруй ажлын хэсэг, мөн дээрээс нь энэ Засгийн газраас өргөн баригдаж байгаа хуулийн томоохон төслүүд зэрэг дээр бүгдээрээ идэвхийлэн хамтарч ажиллах ёстой. Мэдээж өнгөрсөн хугацаанд Улсын Их Хурлын гишүүд өөрсдөө хэлэлцэх асуудлын тов дараалалд саналаа оруулж, өнөөдөр энэ хэлэлцэх асуудлын дараалал батлагдах гээд ингээд явж байна. Цаашдаа өнөөдөр энд багтаагүй гээд орхигдоно гэсэн ойлголт бол байхгүй. Цаг тухай бүрд нь ТББХ-нд өргөн баригдаж байгаа хуулийн төслүүдийг хаврын чуулганаар хэлэлцэх асуудлыг шийдээд явдаг энэ дэгийн зохицуулалт байгаа учраас энэ дээрээ бүгдээрээ анхааралтай хандъя гэж ингэж бодож байна.

Чинбүрэн гишүүний хэлж байгаа Улсын Их Хурлаас батлагдсан хууль, тогтоолуудын хэрэгжилтийн араас явах ёстой, хэрэгжилтийг бүрэн хангахын төлөө ажиллах ёстой. Мэдээж энэ дээр бидэнд хууль байхгүй байна, хуулийн заалт алга байна гээд зүгээр гараа хумиад сууж болохгүй. Улсын Их Хурал Улсын Их Хурлаас батлагдсан хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавьж байх үндсэн чиг үүрэг нь байж л байгаа. Тэгэхээр мэргэжлийн Байнгын хороод, Улсын Их Хурлын гишүүд өөрсдийн санал санаачилгаар энэ батлагдсан хууль тогтоомжийн хэрэгжилтийн араас ажил хэрэг болгож явцгаах нь зүйтэй.

Одоо бүгдээрээ хэн нэгнээс ганц нэг хүнээс хамааралтай хариуцлага хүлээгээд сууж байхаасаа илүүтэйгээр араас нь ажил хэрэг болгохын тулд шаардлагатай ажлын хэсгүүдийг байгуулаад, бүх шатад нь ажиллах боломжийг бүрэн дүүрэн ашиглая гэдгийг хэлье. Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууслаа.

Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 55,7 хувиар санал дэмжигдлээ. Тогтоолын төсөл батлагдлаа. Улсын Их Хурлын гишүүдэд талархал дэвшүүлье.

12.52 цаг

Үдээс өмнөх чуулганы нэгдсэн хуралдааныг завсарлуулъя. Үдээс хойших хуралдаан 15 цагт эхэлнэ. 15 цагт.

*2025 оны 01 дүгээр сарын 17, Баасан гараг,
Төрийн ордон “Их хуралдай” танхим
15 цаг 05 минут.*

ҮДЭЭС ХОЙШИХ НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Д.Амарбаясгалан: Үдээс хойших чуулганы нэгдсэн хуралдаанаа эхлүүлье. Гишүүдэд мэдээлэл хүргээрэй. Үдээс хойших чуулганы нэгдсэн хуралдаанаар 5 асуудал хэлэлцэнэ. 1 дүгээрт Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хууль тогтоомжийн төслийн талаар нэгдсэн хуралдаанд мэдээлнэ. 2 дугаарт Улсын Их Хурлын чуулганаар хуулийн төслийг яаралтай хэлэлцэх эсэхийг шийдвэрлэнэ. 3 дугаарт Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Экспорт-Импорт банк хоорондын зээлийн хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн төсөл хэлэлцэнэ. 4 дүгээрт Нийслэл Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна. 5 дугаарт баталсан хууль, тогтоолын эцсийн найруулгыг сонсоно.

Тав.Өргөн мэдүүлсэн хуулийн төслийг танилцуулах

Хэлэлцэх асуудалд оръё. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1-д Улсын Их Хурлын дарга хууль санаачлагчаас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх Байнгын хороог, хэрэв тухайн төсөлд хэд хэдэн Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарахаар бол Зөвлөлтэй зөвшилцөн холбогдох болон бусад Байнгын хороог тогтоож, нэгдсэн хуралдаанд мэдээлнэ гэж заасан. Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хуулийн төслийг холбогдох Байнгын хороонд хуваарилсан талаар танилцуулъя.

1.Монгол Улсын Засгийн газар Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Экспорт-Импорт, банк хоорондын зээлийн хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг Засгийн газар 2025 оны 1 сарын 17-ны өдөр өргөн мэдүүлсэн. Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд хуваарилсан.

15.07 цаг

Зургаа. “Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Экспорт-Импорт банк хоорондын Зээлийн хэлэлцээр”-ийг соёрхон

**батлах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Хууль
хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.01.17-
ны өдөр өргөн мэдүүлсэн, яаралтай хэлэлцэх эсэх, Монгол Улсын Их Хурлын
чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1-д заасны
дагуу/**

Дараагийн асуудалд оръё. Улсын Их Хурлын чуулганаар хуулийн төслийг яаралтай хэлэлцэх эсэхийг шийдвэрлэнэ. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1-д Засгийн газрын хуралдааны шийдвэрийг үндэслэн Ерөнхий сайд Үндэсний эдийн засгийн аюулгүй байдлыг хангахтай холбогдуулан хуулийн төслийг яаралтай хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд бичгээр хүсэлт тавьсан бол Улсын Их Хурлын дарга төслийг чуулганаар яаралтай хэлэлцэх эсэхийг нэгдсэн хуралдаанд оруулж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар шийдвэрлэнэ гэж заасны дагуу Засгийн газраас 2025 оны 1 дүгээр сарын 17-ны өдөр Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Экспорт-Импорт банк хоорондын зээлийн хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг Улсын Их Хурлын чуулганаар яаралтай хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн.

Төслийг Улсын Их Хурлын гишүүдэд танилцуулахаар тараасан байна. Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Экспорт-Импорт банк хоорондын зээлийн хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг Улсын Их Хурлын чуулганаар яаралтай хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулахаар байгаа. Гишүүд суудлаа эзэлье. Гишүүд ирц бүртгэлийн санал хураалт явуулъя. Ирц бүртгэл, шууд санал хураалт байгаа учраас эхлээд ирцээ бүртгээдэхье. Санал хураалт. Санал хураалтад орж чадаагүй гишүүн хэд байна вэ? 1, 2. Гишүүд чуулганы танхимд ирье. Учрал сайд Засгийн газрын гишүүд рүү бичээрэй. Гадаад томилолттой олон сайд явчихсан байгаа тийм ээ, Ерөнхийлөгчийн айлчлалаар.

Ирц бүртгэлийн санал хураалт дахиад нэг явуулъя. Санал хураалт. Дахин нэг ирц бүртгэлийн санал хураалт явуулъя. Алив гишүүд анхаарлаа төвлөрүүлъя. Эсхүл нэг дэх өдөр чуулганы хуралдааныг үргэлжлүүлъя. Саналаа өгье. Ирц бүртгэлийн санал хураалт. 15 цагаас үдээс хойших чуулганы хуралдаан зарласан, гишүүд хоцорч орж ирж байна. Чуулганы нэгдсэн намрын чуулган хаах дөхсөнтэй холбоотой асуудлаа шуурхай хэлэлцье.

Санал хураалт. Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Экспорт-Импорт банк хоорондын зээлийн хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг Улсын Их Хурлын чуулганаар яаралтай хэлэлцэх эсэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт. 52,8 хувиар санал дэмжигдлээ. Сангийн сайд Болдын Жавхлан, Улсын Их Хурлын гишүүн Жигжидийн Батжаргал нарыг дэмжсэнээр протоколд тэмдэглэе. Хуулийн төслийг Улсын Их Хурлын чуулганаар яаралтай хэлэлцэхийг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Экспорт-Импорт банк хоорондын зээлийн хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн төсөл

болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд шилжүүллээ.

15.22 цаг

Чуулганы нэгдсэн хуралдааныг 15 минут завсарлана. Энэ хооронд Байнгын хороо хуралдаж, бичиг баримт, санал, дүгнэлтээ боловсруулж орж ирнэ. 15 минутын хугацаа өглөө.

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо хуралдах тул хуралдаан 15 цаг 22 минутад завсарлав.

Хуралдаан 17 цаг 37 минутаас үргэлжлэв.

Д.Амарбаясгалан: Чуулганы хуралдаанаа үргэлжлүүлье. Дараагийн асуудалд орно. Хэлэлцэж байгаа асуудал үргэлжилж явж байна.

Долоо. “Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Экспорт-Импорт банк хоорондын Зээлийн хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.01.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах/

Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Экспорт-Импорт банк хоорондын зээлийн хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцэнэ. Хууль санаачлагчийн илтгэлийг Засгийн газрын гишүүн, Сангийн сайд Болдын Жавхлан танилцуулна. Индэрт урьж байна.

Б.Жавхлан: Эрхэм Монгол Улсын Их Хурлын дарга, Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын ЗГ-аас Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Эксим банкны хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтээр хэрэгжүүлж буй Газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл нь хамтарсан Засгийн газрын 2024-өөс 28 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан 14 мега төслөөс хамгийн түрүүнд үйл ажиллагаа нь хэрэгжиж, үр өгөөжөө өгч эхлэх эдийн засаг стратегийн өндөр ач холбогдолтой төсөл юм. Улсын Их Хурлын зүгээс төслийн санхүүжилтэд шаардлагатай нийт 1 тэрбум 236 сая ам.долларын зээлийн хэлэлцээрийг 2017, 2019 онуудад тус тус соёрхон баталсан бөгөөд 2024 оны жилийн эцсийн байдлаар төслийн хүрээнд 268,8 сая ам.долларын эх үүсвэрийг ашиглаж, төслийн нийт ажлын гүйцэтгэл 23,5 хувьтай байна.

Ковидын дараах тээвэр логистик, бараа материалын үнийн өсөлт, түгээлт, тээвэрлэлтийн дэд бүтцийг манай орны цаг уурын нөхцөлд тохируулах зэрэгтэй холбоотой техникийн зарим нэмэлт, өөрчлөлт оруулах болсон нь төслийн хэрэгжилтэд явцад төслийн зардлыг өсөхөд нөлөөлсөн бөгөөд хариу нарийвчилсан ТЭЗҮ-г, ТЭЗҮ-гийн тодотголыг Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны харьяа Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөл 2023 оны 9 дүгээр сард хэлэлцэн төслийн нийт өртгийг 1 тэрбум 698 сая ам.доллар буюу хуучин төсөвт өртгөөс 462,2 сая ам.доллаар нэмэгдэхээр баталгаажуулсан. Үүний дагуу Засгийн газрын зүгээс газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөлд шаардлагатай

нэмэлт санхүүжилтийн хүсэлтийг 2023 оны 10 дугаар сард Энэтхэгийн талд хүргүүлэн зээлийн хүсэлтийг шийдвэрлүүлэхээр ажилласны үр дүнд Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Засгийн газрын зүгээс зээлийн хүсэлтийг 24 оны 11 сарын 26-ны өдөр албан ёсоор шийдвэрлэж, Эксим банкандаа шилжүүлсэн байдаг, шийдвэрлэж зээлийн гэрээний төслийг Эксим банкнаас 12 сарын 24-ний өдөр манайд ирүүлсэн.

Монгол Улсын Засгийн газар Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Эксим банк хооронд байгуулах зээлийн хэлэлцээрийн эцэслэсэн төслийг 2025 оны 1 дүгээр сарын 8-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн дэмжсэн бөгөөд улмаар Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны хуралдаан болон Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо, Төсвийн байнгын хорооны 25 оны 1 дүгээр сарын 13-ны өдрийн хамтарсан хуралдаанаар хэлэлцүүлэн зээлийн гэрээнд гарын үсэг зурах эрхийг Монгол Улсын ЗГ-т олгосон. Үүний дагуу Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Эксим банкны хооронд газрын тос боловсруулах үйлдвэрийн санхүүжилтийн нэмэлт санхүүжилтийг зээлийн хэлэлцээрт 2025 оны 1 дүгээр сарын 16-ны өдөр гарын үсэг зураад байна.

Газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн нэмэлт санхүүжилтийн зээлийн хэлэлцээр нь өмнөх 236 сая ам.долларын зээлийн дүнг нэгтгэснээр 700 сая ам.доллар зээлийн нөхцөл нь өмнөх зээлүүдийнхээ нөхцөлийг үргэлжлүүлж байна. 1,75 хүүтэй, баталгаажуулсны шимтгэл 0,5, 5 жилд үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөөд нийт 20 жилийн хугацаанд эргэн төлөгдөх нөхцөлтэй зээл болно. Тус зээлийн хэлэлцээр байгуулагдсанаар газрын тос боловсруулах, барих төслийг бүрэн хэрэгжүүлж төсөвлөсөн хугацаанд ашиглалтад оруулах, жилд 1,5 сая тонн түүхий тос боловсруулж шинээр 700 гаруй ажлын байр бий болгох, дотоодын шатахууны хэрэгцээний 55 хувиас доошгүй хувийг хангаж жил бүр 1 тэрбум гаруй ам.долларын гадагшлах урагшлахыг зогсоон, төлбөрийн тэнцлийг сайжруулах замаар Монгол Улсын эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэх, санхүүгийн тогтвортой байдлыг хангахад чухал ач холбогдолтой юм.

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын ЗГ-аас 2025 оны 1 дүгээр сарын 17-ны өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Экспорт-Импорт банк хооронд байгуулсан зээлийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Хуулийн төслийн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Байнгын хорооны дарга Ганзоригийн Тэмүүлэн уншиж танилцуулна. Индэрт урьж байна.

Г.Тэмүүлэн: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын ЗГ-аас 2025 оны 1 дүгээр сарын 17-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Экспорт-Импорт банк хоорондын зээлийн хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай

хуулийн 78 дугаар зүйлийг үндэслэн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо 2025 оны 1 дүгээр сарын 17-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Ганбаатар хуулийн төслийн ТЭЗҮ хийгдсэн эсэх, газрын тосны хангамж, олборлолт, түүхий эдийн эх үүсвэр хангалттай эсэх талаар, усны хангамж нөөцийн талаар, Улсын Их Хурлын гишүүн Энхтүвшин, Тэмүүлэн нар төсөв хэлэлцэх үед уг хэлэлцээрийг оруулж ирэх боломжтой байсан эсэх ямар учраас төсөвт суулгаагүй талаар, нэмэлт санхүүжилттэй холбоотойгоор үндсэн зээлийн эргэн төлөлтийн талаар, хэрэгжих өөр том төсөл байгаа эсэх тухай, Улсын Их Хурлын гишүүн Номтойбаяр гүйцэтгэлийн аудит байхгүй байгаа тухай, хэлэлцээрийн санхүүжилттэй холбоотой төсөв санхүүгийн дарамт үүсэх эсэх төсөл хэрэгжсэнээр санхүүжилтээ нөхөх эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Жаргалан ТЭЗҮ-ийн өртөг нэмэгдэх талаар, төсөл хэрэгжсэн хугацаанд бүтээн байгуулалтын ямар ажил хийгдсэн тухай, шимтгэлд эргэн төлөлт хийгдэж байгаа эсэх, 13,1 сая ам.доллар төлсөн эсэх, эргэн төлөлтийн нөхцөлд хүүгийн тооцоолол байхгүй байгаа талаар, жилд хүүгийн төлбөрт ямар хэмжээтэй төлбөр төлдөг, рефолт хүүгийн талаар гэрээнд тусгагдсан эсэх асуудлуудыг тодруулан асуулт асууж, хариулт авлаа.

Улсын Их Хурлын гишүүн Батбаатар дэмжих шаардлагатай төсөл боловч үйл явц алдаатай, төслийн талаарх мэдээлэл хангалтгүй, эргэлзээтэй нөхцөл байдал үүсэхгүй байхад анхаарах, Улсын Их Хурлын гишүүн Ганбаатар ТЭЗҮ, тооцоо судалгаа хангалтгүй, байгаль орчинд нөлөөлөх нөлөөллийн үнэлгээ байхгүй, газрын тосны хангамж, график төлөвлөгөөг тодорхой болгох, Улсын Их Хурлын гишүүн Бадамсүрэн төслийг дэмжиж байгаагаа илэрхийлээд тэр төсөлд улсын төсвөөс болон бусад эх үүсвэрээс ямар ч санхүүжилт хийхгүй байхад анхаарах, зээл дахин авахгүй байх, хэлэлцээрт заасан хугацаанд ашиглалтад оруулах, явцыг тухай бүр дүгнэх мэдээлэх, худалдан авалт нээлттэй байх, үйлдвэрийн түүхий эдийн нөөцийг судлах талаар ажиллах шаардлагатай, Улсын Их Хурлын гишүүн Цогтбаатар төсөл улс орны хөгжилд хэрэгтэй эсэх талаар дүгнэх хэрэгтэй талаар, төслийг хэрэгжүүлэхдээ хариуцлагатай хандах, баримт тооцоотой байхад анхаарах талаар тус тус үг хэлсэн болно.

Монгол Улсын Засгийн газар Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Экспорт-Импорт банк хоорондын зээлийн хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн төслийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжин соёрхон батлах нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Экспорт-Импорт банк хоорондын зээлийн хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцсэн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж, хуулийн төслийг эцэслэн баталж өгөхийг та бүхнээс хүсье. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Болдын Жавхлан Сангийн сайд, Л.Сонор Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга, Л.Гантогтох Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Өрийн удирдлагын хэлтсийн дарга, Цэвэгжавын Туваан Эрдэс баялаг, эрчим хүчний

сайд, Ч.Хишигдалай Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Газрын тосны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, Д.Алтанцэцэг Монголын газрын тос боловсруулах үйлдвэр ТӨХХК-ийн гүйцэтгэх захирал, У.Чинзориг Монголын газрын тос боловсруулах үйлдвэр ТӨХХК-ийн Гэрээ, эрх зүйн газрын дарга. Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгье. 8 гишүүнээр тасаллаа. Энэ гишүүд хурууныхаа хээг уншуулаарай, нэр гарахгүй байна. Номтойбаяр гишүүнийг нэмж оруулъя, ингээд 9 гишүүнээр тасаллаа. Пунсалмаа гишүүнийг нэмж оруулъя, 10 гишүүнээр тасаллаа шүү. 10 гишүүн. Гомбын Ганбаатар гишүүн асуулт асууна. Хурууныхаа хээг уншуулчих.

Г.Ганбаатар: Оройн мэнд. Яаралтай горимоор орж ирнэ гэдэг чинь үнэхээрийн яаралтай явдаг юм байна. Өнөөдөрт нь өргөн мэдүүлээд, өнөөдөрт нь ингээд ийм том хэлэлцээрийг үнэхээрийн хурдтай явж байна. Их Хурлын гишүүдийг мэдээллээр хангах асуудал дутмаг байна. Гэхдээ яалт ч үгүй энэ улс орны үнэхээрийн чухал төсөл. Бид том төслүүдээ явуулахгүй байсаар байгаад өнөөдөр ямар байдалд улс орон хүрснийг бүгдээрээ л мэдэж байгаа. 10 гаруй жилийн өмнө бид шинэ нисэх буудал, нефтийн үйлдвэр, нүүрсний төмөр зам гээд 3 том төсөл хэрэгжихэд энэ эдийн засагт их чухал нөлөө болно гэж байсан. Өнөөдөр болтол тэр төмөр замынх нь төсөл саяхан л энэ Их Хурлаар орлоо. Одоо нефтийнх нь үйлдвэр ингээд л яригдаад л явж байна.

Гэхдээ энэ төсөл эхэлснээсээ хойш ингээд үндсэндээ 8 жилийн дараа бид дөнгөж 20 гаруйхан хувьтай, ахиад 400 гаран сая долларын зээл авах гээд л явж байна. Асуулт ерөнхийдөө өнгөрсөн хугацаанд Commitment Fee буюу ашиглагдаагүйнхээ зээлийн хүүд 20 гаруй сая доллар төлсөн юм байна. Ахиад энэ хугацаанд ингээд гүйцэтгэгч талууд нь хариуцлагагүй байгаад бид ашиглагдаагүй зээлдээ хүү төлөөд явбал цаашдаа 36 сарын дотор энэ үйлдвэр ашиглалтад оруулж чадахгүй бол хариуцлагыг нь хэн үүрэх вэ?

Дараагийн нэг гол зүйл үндсэндээ энэ нефтийн үйлдвэр ч бай, саяхан батлагдсан тэр Орано ч бай, манай говийн бүс ялангуяа манай Дорноговь аймагт хэрэгжиж байгаа төслүүд яг бодит байдал дээр үнэхээрийн ажил явахгүй байгаа шүү. Тэр 21 хувь гээд байгаа юм тэрэндээ хүрч байгаа ч юм уу, үгүй юм уу? Яг ингээд Дорноговь аймгийн иргэдийн ярьж байгаа, орон нутагт ажиллаж амьдарч байгаа бид нарын мэдэж байгаагаар энэ нефтийн үйлдвэр чинь яг үндсэндээ яаж ажил хийдэг, Энэтхэггүй тэгж хийдэг юм уу яаж хийхээрээ нэг хийдэг юм би үнэхээрийн гайхаад байдаг байхгүй юу. Тэгээд энэ 36 сардаа ашиглалтад оруулахгүй бол тэр гүйцэтгэж байгаа ЕРС нөхцөлөөр оруулж ирж байгаа Энэтхэг компани нь ямар гэрээний үүргийн биелэлт байгаа юм бэ, ямар хариуцлага үүрэх юм бэ? Зөрөөд нь бид ингээд өнгөрсөн хугацаанд ингээд ашиглагдаагүй зээлийнхээ хүүг төлөөд яваад байх юм уу? Энэ дээр л хариулт авъя. Зүгээр зарчмын хувьд яалт ч үгүй л нефтийн үйлдвэрийг дэмжиж байгаа.

Ер нь манай нутгийн гаралтай Монгол Улсын Ерөнхий сайд байсан Содном гуай хэлсэн шүү дээ. Хуурай худаг ухаад байна шүү та нар нөөц чинь хаана вэ гэж. Думаагийн Содном гуай бол том эдийн засагч хүн. Тэгээд энэ нефтийн үйлдвэр дээр хүн болгон санаа зовж байгаа юм. Гэхдээ нөгөө талдаа энэ нефтийн үйлдвэр ингээд олон жилийн дараа нэг их мөнгө үрээд дэлхий даяар бий болдог нөгөө нэг

цагаан заан гэдэг нэг төсөл байдаг шүү дээ. Нэг их бэлгэдлийн чанартай, олон тэрбум доллар.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Уул уурхайн яамнаас хэн байгаа билээ? Ажлын хэсгийн 18 дугаар микрофон уу? Наад дугаараа өргө дөө. Ажлын хэсгийн 18 дугаар микрофон.

Ч.Хишигдалай: Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Газрын тосны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Хишигдалай. Өнөөдөр энэхүү зээлийн хэлэлцээрийн нэмэлт санхүүжилт батлагдсанаараа энэ 1 дүгээр сарын сүүл, 2 дугаар сарын эхээр хамгийн сүүлийн ЕРС 4 ажлын гэрээнүүдийг баталгаажуулж дуусгая. Уг гэрээ баталгаажиж дууссанаас хойш 36 сарын хугацаанд энэхүү үйлдвэрийн ЕРС 4-ийн бүх бүтээн байгуулалтууд дуусна. ЕРС-1 бол 100 хувь бүтээн байгуулалт дууссан байгаа. ЕРС-2 25 хувьтай явж байна. ЕРС 3 мөн 20 орчим хувьтай үйл ажиллагаа явуулж байна, явагдаж байна Зээлийн эргэн төлөлттэй холбоотой асуултыг Сангийн яамнаас хариулна.

Д.Амарбаясгалан: Сангийн яамнаас ажлын хэсгийн 19 дүгээр микрофон.

Л.Гантогтох: Сангийн яамны Өрийн удирдлагын хэлтсийн дарга Гантогтох. Ганбаатар гишүүний асуултад хариулъя. Зээлийн гэрээний, зээлийн гэрээ дээр заагдсанаар хөрөнгө баталгаажуулсны шимтгэл буюу Commitment Fee 0,5 хувийн шимтгэл төлөхөөр байгаа. Энэ дүн гэрээний дүнгээс ашиглагдаагүй дүн дээр бодогддог ийм шимтгэл байгаа. 2024 оны жилийн эцсийн байдлаар Commitment Fee-д Монгол Улсын ЗГ-аас нийт 10,1 сая ам.долларын төлбөрийг төлөөд байна. Үндсэн төлбөр дээр 2023 онд нийт 26 сая ам.долларын төлбөрийг Энэтхэгийн зээл дээр төлөөд байна.

Д.Амарбаясгалан: Болчихсон уу?

Л.Гантогтох: Болчихлоо.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүд гадагшаа томилолт, дотоод томилолт гээд жоохон ирц тааруу байгаад байгаа. Энэ асуудлыг хэлэлцсэний дараа Даргын дэргэдэх зөвлөл хуралдаж ирэх долоо хоногийн чуулганы хуралдааны тов дарааллын асуудал хэлэлцэхээр болж байгаа гэдгийг та бүхэндээ анхааруулж хэлье. Тэгэхээр энэ асуудлууд дээр ирцээ шахаад, асуудлаа өнөөдөр яаралтай хэлэлцээд явах юман дээрээ анхаарал хандуулах нь зөв байх гэж бодож байна. Нямтайширын Номтойбаяр гишүүн асуулт асууя.

Н.Номтойбаяр: Энэ асуудлыг Даргын зөвлөлийн хурал дээр холбогдох салбарын сайд Туваан танилцуулга хийснээс хойш богино ч гэсэн багагүй хугацаанд мэргэжлийн хэд хэдэн улсуудтай уулзаж, үгийг нь нэлээн сонслоо. Технологийн хувьд, эдийн засгийн шийдлийн хувьд үнэхээр олон асуудлууд байгаа энэ дээр. Тэгэхээр би асуулт гэхээсээ илүү хэдэн асуудал дээр баталгаа авчихмаар байна. 1 дүгээрт юу вэ гэхээр ингээд нийт 2,2 тэрбум долларын хөрөнгө оруулалттай энэ төсөл маань өөрөө, өөрөө хөрөнгө оруулалтаа нөхөж төсөвт ямарваа нэгэн санхүүгийн дарамт учруулахгүй байна гэсэн баталгааг сонсмоор байна. Тэгээд өнгөрсөн хугацаанд яах вэ энэ салбарын сайд хүндэтгэн үзэх шалтгаантай юм шиг байна. Энэ Туваан сайд л уг нь баймаар байгаад байгаа юм.

Дээрээс нь энэ төсөл одоо сунгагдаж байгаа 30 сарынхаа, 36 сарынхаа хугацаанд ашиглалтад орж, эхнийхээ бүтээгдэхүүнийг гаргах баталгаа байна уу? Эцсийн бүтээгдэхүүн маань ер нь ямар үнэтэй байх вэ? Техник, эдийн засгийн үндэслэлдээ бол их итгэлтэй байна лээ. 1 литр бензинийг, 1 литр дизель түлшийг 3 жилийн дараа бид яг хэдэн төгрөгөөр авах юм бэ? Магадгүй энэ 36 сарын хугацаанд янз бүрийн үндэслэлтэй, үндэслэлгүй шалтаг тоочоод, магадгүй дараагийнх нь сайд ч байдаг юм уу ийм, ийм учир дутагдалтай юм болчихжээ, энэ 1,7 чинь нэмэгдэхээс өөр аргагүй боллоо гээд гоншигноод ороод ирэх вий. Нэмэгдэхгүй байх баталгааг авмаар байна. Энэ дээр л тодорхой хариулаад өгчих.

Яг үнэндээ хэлэхэд Даргын зөвлөлийн хурал дээр худлаа ярьсан шүү. 268 сая долларын гүйцэтгэл хийгдчихсэн байгаа аудит нь хаана байна вэ? Бүхэлдээ энэ Энэтхэгийн Эксим банкнаас авч байгаа 1,7 сая доллар дээр хөндлөнгийн аудитууд юу гэж хэлээд байгаа юм бэ? Мэргэжлийн шүү, мэргэжлийн, хөндлөнгийн. Яагаад гэхээр эргэлзээтэй маш олон асуудлууд гарсан. ЕРС-1-ийнхээ хүрээнд менежментийнх нь зардал гээд 73,9 сая доллар байгаа, лицензийн төлбөр гээд 30 сая доллар байгаа. Үгүй ээ анхнаасаа яагаад тэгвэл ЕРС... гэрээ байгуулчхаагүй юм бэ? Тэгээд констракшны ажлыг хөндлөнгийн компаниудаар хийлгэдэг бизнесийн хамгийн эрүүл жишиг тогтолцоо байдаг. Менежментийг.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Нэмэлт 1 минут өгье.

Н.Номтойбаяр: Ингээд эрсдэлийг бууруулах, энэ төсөл амжилттай хэрэгждэг, олон улсын жишиг бүхий энэ стандарт тогтолцооноос асар хол зөрөөтэй ийм жишгээр явж байгаа шүү. Тэгэхээр энэ баталгаануудыг л авчихмаар байна маш тодорхой. Энэ чинь 1 тэрбум долларт босно гээд л явж байсан, одоо 700 сая доллароор нэмэгдсэн явж байгаа. Дээрээс нь нөгөө дамжуулах хоолой, Хөгжлийн банкнаас авсан зээл гээд энэ чинь 2,2 сая, усны асуудал огт хөндөгдөөгүй байгаа. Усных нь нөөц тодорхойгүй байгаад байгаа. Тэгээд энэ дээр л баталгаа аваадахъя. Тэгээд энд гишүүддээ хандаж нэг үг хэлье. Энэ түүх болж үлдэнэ шүү. Энэ эргээд маш том асуудал болох вий. Тэгэхээр энэ дээр хариуцлагатай байхыг хүсэж байна. Тэгээд яах вэ олон улсын харилцаа элдэв гээд л, яг ний нуугүй хэлэхэд янз бүрийн шалтаг яриад л ингээд гөлөг төөрүүлж байгаа юм шиг л энд яваад байна л даа.

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Ажлын хэсгийн 21 дүгээр микрофон уу? Уул уурхайн яам.

У.Чинзориг: Монгол газрын тос боловсруулах үйлдвэрийн Гэрээ, эрх зүйн газрын дарга Чинзориг. Гишүүний асуултад хариульъя. Асуулт гэхээсээ илүү баталгаа бид нараас юу яаж байгаа юм. Тэгэхээр төсөл хэрэгжүүлэгч компанийн хувьд үйлдвэрийг цаг хугацаанд нь багтсан, үнийн дүн, төсөвт нь багтааж ашиглалтад оруулах хамгийн том зорилго, зорилт болгоод тэрнийхээ төлөө хамаг хичээл зүтгэлээ гаргаж ажиллана. Тэгэхээр үйлдвэрийн эдийн засгийн хувьд өөрөөрөө өртгөө нөхөх үү гэсэн энэ баталгаа дээр 2018 онд үйл үйлдвэрийн ТЭЗҮ батлагдсан. Тэгээд 23 онд ТЭЗҮ-д тодотгол орсон. Тэгэхээр яах вэ үйлдвэрийн эдийн засаг ТЭЗҮ-д маш тодорхой л үйлдвэрийн эдийн засгийн тоонууд маш тодорхой л ТЭЗҮ-д тусгагдсан явж байгаа.

Тэгээд үүний дагуу үйлдвэр болон өртгөө бол энэ нэмсэн зээлийн дүнг оруулаад өртгөө 8 жилийн дотор, 7-гоос 8 жилийн дотор нөхнө гэсэн ийм эдийн засгийн тооцоотой явж байгаа. Эцсийн бүтээгдэхүүний үнийн хувьд ерөнхийдөө нэгж үнийн, нэгж бүтээгдэхүүний өртөг 1100, 2100 уучлаарай, 2100 төгрөг гэж явж байгаа. Тэгээд ер нь юун дээр ч гэсэн ТЭЗҮ дээр ч гэсэн үйлдвэрийн үйлдвэрээс гарах бүтээгдэхүүний үнийн урьдчилсан тооцоо эд нарыг маш тодорхой урьдчилсан байдлаар тооцсон байгаа.

Цаашид энэ нэмэлт зээлийн санхүүжилтийг батлаад, тэгээд цаашид ер нь төслийн өртөг өсөхгүй байх баталгаа гэсэн. Энэ дээр бид 2017 оноос хойш л шаардлагатай бүх л гэрээнүүдээ байгуулаад явж байгаа. Төсвийн менежментийн зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулагдсан. Дараа нь ЕРС-1, ЕРС-1-ийн гэрээ байгуулагдаад, энэ жил энэ ЕРС-1-ийн хүрээнд хийгдсэн бүх ажлууд барилга угсралтын ажлууд хийгдэж дуусаад улсын комисст хүлээлгэж өгсөн байгаа. ЕРС 2, 3 гэрээ ингээд байгуулагдчихсан. Мөн үйлдвэрийн технологийн лицензийн гэрээнүүд нийт 28 гэрээ байгуулагдчихсан. Цаашид мөн лиценз эзэмшигчтэй байгуулах гэрээнүүд байгаа. Ингээд энэ нэмэлт зээлийн санхүүжилт батлагдаад, үүний хүрээнд ЕРС 4-ийн гэрээ байгуулагдаад, үйлдвэрт энэ төслийн хүрээнд байгуулах ёстой бүх гэрээнүүд ингээд байгуулагдаад дуусаж байгаа гэсэн үг.

Тэгэхээр яах вэ энэ байгуулагдсан гэрээний хүрээнд бид гүйцэтгэгч компаниудад захиалагчийн зүгээс бүх шаардлагуудыг тавьж, хугацаанд нь төсөвт нь багтаан төслийг дуусгаж, үйлдвэрийг ашиглалтад оруулах ийм гол зорилт үлдэж байгаа юм. Болсон.

Д.Амарбаясгалан: Тодруулж асууя. Нямтайширын Номтойбаяр гишүүн.

Н.Номтойбаяр: Их хэцүү ч юм даа. Нөгөө яг улс төрийн хариуцлагатай албан тушаалтан салбарын сайд нь байхгүй байхад ажлын албаны эдгээр хэдэн залуучууд ингээд л хатуу хөтүү үг хэлээд байх. Яг үнэндээ саяын үгүй ээ, гишүүд ээ, та хэд сонс л доо. Аягүй ойлгомжтой баталгаа асуулаа шүү дээ. Цаг хугацаандаа орох уу? Анх 1 гэж яригдсан, 1,2 тэрбум доллар гэсэн одоо ингээд даруй 500 сая доллар нэмэгдчихээд байна. 1,7 сая долларын энэ зээл дахиж 1 центээр нэмэгдэхгүй байх баталгаа л асуулаа шүү дээ. Ер нь ойлгомжтой биз дээ тийм ээ? Нэмэгдэхгүй бол нэмэгдэхгүй гээд л энийг хэлчих л дээ. Нэмэгдэх бол үнэхээр хэлж мэдэхгүй байна гээд хэлчих л дээ. Төсөвт дарамт учруулах юм уу, энэ төсөл маань өөрөө өөрийнхөө хөрөнгө оруулалтыг нөхөх юм уу? ТЭЗҮ гэдэг чинь сая тодотгол хийсэн юм байна. Үгүй ээ тэгээд 36 сарын дараа нэг.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Асуулт авч, хариулт авлаа. Сайнхүүгийн Ганбаатар гишүүн асуулт асууя.

С.Ганбаатар: Энэ төсөл Монгол газрын тостой болох ёстой, газрын тос заавал Монголд нэрэгдэж газрын тосны үйлдвэр баригдаасай гэж Монгол хүн болгоны мөрөөдөл. Тэгэхдээ өнөөдрийн энэ үүлэн чөлөөний нар шиг олдож байгаа энэ боломжийг бид гоомой алдаад, хэзээ ч босхооргүйгээр унаж болохгүй. Хэдэн луйварчдын аманд унаад, ямар ч тооцоо судалгаа, үндэслэлгүйгээр гаргаж, шийдвэр гаргаж болохгүй. Өнөөдрийг хүртэл 18 онд батлагдсан ТЭЗҮ гэж яриад

байгаа. Үзсэн гишүүн байна уу энэ 5 жилийн хугацаанд, үзсэн сайд байна уу? Өнөөдрийн ингээд олон зуун сая долларыг ингээд зарцуулчихлаа гээд байгаа. Тэр тооцоо судалгаа, үндэслэлүүдийг нь гаргасан хүн байна уу, харсан хүн байна уу та нарт? Тэр 34 хувийн өсөлттэй үнэ өсчихлөө, та орж ирж байна. Жип өнөөдөр 5 хувь өсөөгүй байгаа. Тоног төхөөрөмжүүд яагаад тэр нефтийн тоног төхөөрөмжүүд тэгж өсөхгүй, энийг үзсэн хүн байна уу хамгийн гол нь? Үгүй ээ энэ чинь ингээд зах дээр нэг ийм цагаан сарын гурилаа авах гээд наймаа хийж байгаа ам пигүүрний наймаа биш шүү дээ. Миний тодруулж байгаа асуулт 1 дүгээрт та нар технологийн лиценз байгаа юу, ТЭЗҮ-ээ яг гишүүдэд хэнд нь үзүүлсэн бэ 1 дүгээр асуулт? Ямар сайдад үзүүлсэн бэ? Би тэрэнд чинь итгэх гээд байна шүү дээ. Алтанцэцэг даргаа тэрийг хэнд үзүүлсэн юм бэ, нууцын гэрээтэй юм уу?

2 дугаарт газрын тосны нөөц хангалтгүй, энэ үйлдвэр хуурай худаг ухаж байгаа, яг үнэн, түрүүн зөв хэлж байна. Газрын тосны тэр нөөц өнөөдөр Дачин Тамсагаас л авна гээд байгаа. Дачин Тамсаг энэ жил 500 мянган тонныг олборлосон. Манай энэ үйлдвэр чинь 1,5 сая тонны үйлдвэр. Тэгээд тэр бусдыгаа хаанаас нь өгөх гэж байгаа юм бэ? Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөр гаднаас нефть, түүхий нефть оруулж ирэхгүй шүү гээд заачихсан байгаа энд. Одоо хаана юм бэ, хаана судалгаа хийсэн юм бэ? Байхгүй ээ, зүгээр надад асуулт хариулж өгөөрэй та нар.

2 дугаарт нефтийн үйлдвэр маш их ус хэрэглэдэг, маш их ус хэрэглэдэг. 4 литр ус тутмаас 1 литр нефтийн бүтээгдэхүүн гарна гэж ярьдаг. Та нар энэ дээр байгаль орчны нарийвчилсан шинжилгээ дүгнэлт гаргасан уу? Хэн, хэн гэдэг эрдэмтэн байгаа юм бэ? Үзье л дээ, хамгийн гол нь үзье, одоо байгаа гээд л гоё ярьж болно л доо. Норинкогийн тэр хоолой байна. Та нараас хэн мэдэж байгаа юм бэ? Улсын Их Хурлаас хэн баталсан юм бэ? 500 сая долларын тэр хоолой. Дачин Тамсаг цаашаа өөрсдөө машинаар зөөгөөд, дараа нь вагонд юүлээд, вагоноор цаашаа явж байгаа шүү дээ. Наашаа 500 сая доллар гэдэг чинь 500км зам шүү дээ. Үгүй ээ тэгвэл ядаж өвсөө зөөе л дөө Дорнодоос. Үгүй ээ ийм тооцоогүй, судалгаагүй, хяналтгүй юман дээр та нар гарын үсэг зур, Оюу толгойгоос долоон дор бид тэнэгтэнэ шүү.

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Сангийн сайд Болдын Жавхлан эхэлж хариулъя.

Б.Жавхлан: Тийм Ганбаатар гишүүний асуултад хариулъя. Ийм том төсөл ТЭЗҮ-гүй байна гэж юу байх вэ. Тэгэхдээ таны санаа зовж байгааг бид ойлгож байна. Харин тийм энэ манай төслийнхөн энэ ТЭЗҮ-г нь нэг бүрэн эхээр нь энэ бүх гишүүдэд өгчхөөч, өгчхөөч ээ гэж удаа дараа хэлээд байгаа шүү дээ. Энийг нь та нэг өгчхөөч. Тийм. Тэгэхээр ТЭЗҮ-гүй байна гэж юу байх вэ. Ер нь яах вэ 18 онд хийгдсэн ТЭЗҮ, 23 онд тодотгол хийгдсэн юм байна лээ. Би бол үзсэн, тийм тодотгол хийгдсэн. Сая энэ зээлийн хэлэлцээр дээр гол үндэслэж байгаа бичиг баримт ТЭЗҮ учраас. Ингээд сайд нар бол үзсэн, үзэх ёстой сайд нар маань бүгдээрээ ингээд үзээд явж байгаа. Тэгэхээр бүх гишүүдэд л маш сайн мэдээлэлжүүлж, энэ ТЭЗҮ энэ бүх юмаа өгмөөр байна шүү манай ажлын хэсгийнхэн. Уул уурхай яамныхан. Та нар өмнө нь тэр Даргын зөвлөл дээр уг нь хэлсэн шүү дээ, тэгээд тэрнээс чинь хойш бараг долоо хоночхоод байхад чинь.

Тэгээд бусад тэр технологийн лиценз, нөөц хангалтгүй байна гэж байна. Усны асуудлуудаар мэргэжлийн яам хариулт, жоохон мэдээлэл өгчих үү.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн 18 дугаар микрофон. Уул уурхайн яам хариулт өгье.

Ч.Хишигдалай: Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Газрын тосны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Хишигдалай. Газрын тосны нөөцтэй холбоотой асуултад хариулт өгье. Өнөөдөр Монгол Улсын газрын тосны салбарт ашиглалтын үйл ажиллагаа явуулж байгаа 4 талбай байна. Гол газрын тосны олборлолт явуулж байгаа 19, 21 дүгээр талбай дээр БНХАУ-ын хөрөнгө оруулалттай Петрочайна Дачин Тамсаг компани 2012 онд хайгуулын ажлын дүнд нийт 330 сая орчим сая тонн геологийн нөөцийг тогтоосон бөгөөд уг тогтоосон нөөцөөс 13 хувийг олборлохоор орд ашиглалтын төлөвлөгөөг батлуулсан. Өөрөөр хэлбэл 40 орчим сая тонн газрын тосны бүтээгдэхүүнийг олборлохоор. Үүнээс одоогийн байдлаар өнгөрсөн 12 жилийн хугацаанд 10 гаруй сая тонн газрын тос олборлоод, БНХАУ руу экспортолсон байна. Олон.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Гүйцээж хариулах уу? Гүйцээж хариулъя.

Ч.Хишигдалай: Олон улсын жишгээр газрын тосны орд ашиглалт 15-аас 40 хувь хүртэл байдаг. Энэ жишгээр тооцвол бид үйлдвэрийг дор хаяж 20 жил газрын тосоор хангах боломжтой байгаа. Зүгээр өнөөдөр Петрочайна Дачин Тамсаг компани олборлолт яагаад буураад байна гэвэл бүтээгдэхүүн хуваах гэрээ, түүнтэй холбоотой татварын маргаан зэрэг зүйлээс шалтгаалаад хөрөнгө оруулалтаа тодорхой хэмжээгээр бууруулсан байна. Газрын тосны орд ашиглалт нь өөрөө тогтмол хөрөнгө оруулалтыг шаарддаг, байнга ордыг хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, олборлолтыг нэмэгдүүлэх үйл ажиллагаа шаарддаг учраас хөрөнгө оруулалттай холбоотой олборлолт буурсан гэж үзэж болно. Технологийн лиценз байгаа. Устай холбоотой асуудлыг үйлдвэрээс хариулчих уу?

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн 21 дүгээр микрофон.

У.Чинзориг: Газрын тос боловсруулах үйлдвэрийн Гэрээ, эрх зүйн газрын дарга Чинзориг. Ганбаатар гишүүний асуултад нэмж хариулъя. Тэр юуны төслийн хүрээнд хийгдсэн, боловсруулагдсан, баталгаажсан эрх зүйн баримт бичгүүдийн хувьд ТЭЗҮ-ээс авхуулаад 18 онд батлагдсан ТЭЗҮ, 23 онд тодотгол орсон, мөн 17 оноос хойш байгуулагдсан бүх төслийн менежментийн зөвлөхийн гэрээ, түлхүүр гардуулах нөхцөлтэй ЕРС барилга угсралтын ЕРС гэрээ болон бусад хяналтын гэрээ, лицензийн гэрээ бүгд манай компани дээр хадгалагдаж байгаа. Жишээлбэл ЕРС 2-ын гэрээний хувьд 17 мянган хуудастай гэрээ байдаг. Тэгэхээр яах вэ бид энэ юуг нууж хаасан юм огт байхгүй. Энийг гишүүнд хүргүүлнэ, Ганбаатар гишүүнд хүргүүлнэ. Бусад гишүүдэд танилцуулахад бүрэн нээлттэй гэдгийг.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Тодруулж асууя. Сайнхүүгийн Ганбаатар гишүүн.

С.Ганбаатар: Намайг чинь нөгөө Рио Тинтогийн хөлсний алуурчид чинь нэг популист гээд нэр өгчихсэн. Би болохоор цагаан дээр хараар бичсэн зүйлийг тоо баримтыг асууж байгаа. Өөдөөс та нар амаараа хачин гоё гэж хариулдаг. Хэн нь

вэ? Популист гэдэг бол боломжгүй зүйлийг хүмүүсийн сайхан сэтгэлийг татах л гэж нэг орчуулаад байх шиг байгаа юм. Үгүй ээ би яг цагаан дээр хараар бичсэн зүйл ярьж байна. Тэгээд ТЭЗҮ-ийн үгүй ээ өгөх боломжтой гэж энэ гишүүдийг доромжилж байгаа юм уу, та нараас гуйх юм уу? Өг л дөө та нар. Гишүүдээ та нар тэрийг хараад, дүн шинжилгээ хийгээд, тэгээд дараа нь кноподоо хүрэх ёстой болохоос биш байгаа юм байна, хачин гоё байгаа юм байна гэж бодоод дарна гэвэл та хууль зөрчиж байгаа шүү.

2 дугаарт миний ахан дүүсээ ийм луйврын, би нефтийн үйлдвэртэй болох мөрөөддөг. Монгол хүн болгон мөрөөдөж байгаа. Гэхдээ мөрөөдлийг минь ашиглаж ямар ч тооцоо судалгаа.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: 18 цаг хүрсэн байна. Чуулганыхаа нэгдсэн хуралдааныг өнөөдөр хуралдаж энэ асуудлаа шийдвэрлэх үү? Ажлын цаг дууссан учраас завсарлаж ирэх долоо хоногт үргэлжлүүлж хуралдах уу? Гишүүдийн санал ямар байна вэ? Ганбаатар гишүүний асуултад хариулчих. ТЭЗҮ хэн өгөх юм бэ? Ажлын хэсгийн 21 дүгээр микрофон.

У.Чинзориг: ТЭЗҮ-г бол ямар ч хэлбэрээр хүргүүлж болох байх. Зүгээр эх хувиар гэх юм бол нэг асуудал энэ ТЭЗҮ-г яаман дээр албаны нууцад авчихсан. Тэгээд тэр журмынх нь дагуу ингээд танилцуулахад журмыг нь мөрдөөд, бид танд file-аар хүргүүлж болно.

Д.Амарбаясгалан: Болдын Уянга гишүүн асуулт асууя.

Б.Уянга: Энэ өдрийн мэндийг хүргэе. Газрын тос боловсруулах үйлдвэр маань баригдчихаасай, дуусчхаасай. 27 онд гэхэд бид дотоодоосоо бензинээ, түлшээ хангадаг болох юм сан. ОХУ-аас ингээд бараг 100 хувь хамааралтай байдаг нь ямар хэцүү байдаг. Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Газрын тосны бодлогын газрынхан тэр Оросоос авах хэмжээгээ тохироход хүртэл ямар төвөгтэй байдгийг нэлээн сайн мэдэж байгаа. Гэхдээ энэ гэрээ маань заавал батлагдах ёстой байгаад байдаг. Өнөөдөр тэгээд соёрхон батлах хууль нь ингээд орж ирж байна. Тэгэхээр соёрхон батлах хууль орж ирж байгаа гэдэг утгаараа ер нь гэрээнд дахиж өөрчлөлт орохгүй, хэлэлцээрт нь ямар нэгэн байдлаар өөрчлөлтүүд орохгүй гэж үзэх үү? Гэрээг нарийн уншихаар 2 зүйлийг заавал тодруулах хэрэгтэй байгаад байдаг. Тэгээд энийг асуухгүй байж чадахгүй нь асууя.

Бид энэ ашиглаагүй зээлийн үлдэгдэлтэй Commitment Fee буюу гэрээний 7.1-д зааснаар 0,5 хувийн хүү алданги төлөх юм байна. Хүү төлөх юм байна. Тэгэхээр бид нарт танилцуулсан танилцуулгаар болохоороо бид нийт зээлийн ашиглалтыг ашиглалтын хувь маань 15,8 хувь байгаа гээд, тэгээд өмнө нь байгуулагдсан гэрээнүүдийн нөхцөл нь яг адилхан гээд байх юм. Тэгэхээр энэ ашиглаагүй байгаа зээлдээ бид хэчнээн хэмжээний мөнгө одоогийн байдлаар төлөөд байгаа юм бол? Энэ 1 дүгээр асуулт байгаа юм.

2 дугаар асуулт нь болохоороо 3.1-ийн Д дээр зээлдэгчийн газар нутаг ноогдох бүх төрлийн татвар хураамжаас чөлөөлөх ийм заалт орсон байна. Энд нийгмийн даатгалын шимтгэл орно л гэж ойлгоод байна л даа. Тэгэхээр ажил олгогч болон ажилтнаас төлөх шимтгэлийг аль алиныг нь яриад байна уу? Хэрвээ хоёулаа яригдаж байвал яагаад энийг чөлөөлөх ийм нөхцөлийг анхнаасаа хүлээн

зөвшөөрсөн юм бол? Тэгээд богинохон байдлаар ямартай ч энэ хоёртоо хариулт авъя ажлын хэсгээс.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн 19 дүгээр микрофон хариулт өгье.

Л.Гантогтох: Сангийн яамны Өрийн удирдлагын хэлтсийн дарга Гантогтох. Уянга гишүүний асуултад хариулъя. Commitment Fee-тэй холбоотой заалт гэрээ дээр 0,5 хувь буюу бид ашиглагдаагүй зээлийн үлдэгдлээсээ төлөх хүүгийн хувь 0,5 хувь байгаа. Энэ хувийн дагуу 2018-аас 24 оны хооронд Засгийн газар нийт 10,1 сая ам.долларын төлбөр төлөөд байгаа. Энэ Commitment Fee болохоор зөвхөн энэ Энэтхэгийн зээлийн гэрээ дээр орж ирж байгаа биш, ер нь олон талт болон 2 талт бүх донор орнуудын гадаад зээлийн гэрээ дээр гэрээний ашиглалтыг түргэсгэх, төслийг хугацаанд нь оруулах зорилгоор ерөнхийдөө энэ жишиг 0,5 хувиар ингэж тусгагддаг ийм заалт байгаа. Тэгээд Засгийн газрын зүгээс нийт 10 сая ам.долларын төлбөрийг одоогоор энэ Энэтхэгийн зээлийн Commitment Fee дээр төлөөд байна.

Татварын, татвартай холбоотой заалт дээр таны зөв. 3.1-ийн, гэрээний 3.1-ийн Д хэсэг дээр гүйцэтгэгчийг Монгол Улсад байгаа ХХОАТ болон ААН-ийн орлогын татвар, нийгмийн даатгалын шимтгэл зэргийн татвар хураамжаас чөлөөлсөн ийм заалт байгаа. Энэ заалт 2017 болон 19 онуудад соёрхон батлагдсан энэ Энэтхэгийн зээлийн гэрээ дээр мөн тусгагдсан. Мөн Энэтхэгийн зээлийн гэрээ дээр зөвхөн тусгагдсан уу гэвэл бусад гадаад зээлийн гэрээ дээр ерөнхийдөө энэ татвар хураамжаас чөлөөлөх заалтууд тусгагдаад явдаг байгаа. Тэрний шалтгаан нь юу вэ гэхээр Монгол Улсын Засгийн газар буцаад энэ зээлийг авчхаад, эргээд төлдөг болохоор хэрвээ татвар хураамжийн зардал зээлийн нийт дүнд орох юм бол манай төлөх зээлийн маань нийт өртөг нэмэгдээд буцаагаад ялгаагүй адилхан төлнө гэсэн үг. Тэгэхээр татвар хураамжийн зардлыг нийт зээлийн дүнгээс суутган тооцсоноор энэ нийт төслийн өртөг маань ингэж гарч ирж байгаа. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Энэ яах вэ нөгөө микрофон хаачихсан байж байгаа. Өнөөдөр хуулиараа Улсын Их Хурлын намрын чуулган хаах нөхцөлөө бүрэн хангачихсан байгаа. Хэлэлцэх асуудлуудаа шийдвэрлэж чадвал хаая гэсэн ийм байдалтай байгаа. Гэхдээ гишүүдийн ирц хангалтгүй байна. Ер нь сүүлийн 2, 3 өдрийн ирц 92, 3-аас дээшээ гарахгүй байна. Албан ёсны чөлөө авсан 17 орчим гишүүн байгаа. Чөлөө аваагүй, гадагшаа, дотогшоо явчихсан 17, 8 гишүүн байх шиг байна. Надад өнөөдөр гадаад болон дотоод томилолтоор томилолт авч явах хүсэлт ирүүлсэн 30 орчим гишүүд байна ирэх долоо хоногос. Тэгэхээр ирэх долоо хоногт чуулган хуралдахад жоохон хүндрэл учрахын хувьд учирна. Өнөөдөр чуулганаа хаая гээд зүгээр гишүүд өөрсдөө санал нэгдээд, дээрээс нь энэ Газрын тосны үйлдвэрийн хуулийн төслийг чинь соёрхон батлах чинь 64 гишүүнээр батлагдах ёстой. Тэрийгээ баталж чадна гэвэл өнөөдрийнхөө чуулганыг үргэлжлүүлье. Үгүй ээ гэвэл чуулганыг даваа гаргийн өглөө 10 цагт үргэлжлүүлэн хуралдана.

Өнөөдрөөс эхлээд гадаад болон дотоод томилолтыг 14 хоногоор хориглож байгаад, бид энэ тавьсан зорилгоо хангаад, хэлэлцээд асуудлаа нэг талдаа шийдээд явах нь зүйтэй гэж бодож байна. Олон улсын яриа хэлэлцээр, мэдээж энэ ТЭЗҮ шаардаж байгаа, аудит хийлгэхийг шаардаж байгаа гишүүдийн байр суурь

нэг талдаа маш зөв. Хэрвээ бас энийгээ соёрхон батлахгүй бол энэ хүртлээ санхүүжилт, хөрөнгө оруулалт хийчихсэн байгаа төсөл ямар нөхцөл байдалд орох вэ гэдгийг бид үр дагавруудаа тал талаас нь бодох ёстой байх гэсэн ийм байдалтай байна. Тэгэхээр яах вэ гишүүд ээ? Даваа гарагт үргэлжлүүлэх үү? Гадаад, дотоод томилолтоо зогсоогоод. Ер нь чуулганы хуралдаан нэгэнт сунавал 14 хоног үргэлжилнэ. Яагаад гэхээр 2-оос 3 хуулийн төсөл хэлэлцэх шаардлагатай хуулийн төсөл хүлээж байгаа. Тэгэхээр сунасан тохиолдолд тэдгээр хуулийн төслийг дундаас нь орхихгүйгээр хэлэлцэж дуусаад чуулган завсарлах нь зүйтэй гэж бодож байна. Тэгэх үү? Ер нь сунгаж хуралдъя гэдэг рүүгээ орчих уу? Сунгаж хуралдъя гэж байгаа гишүүд гараа өргөчих. 14 хоног сунгаж хуралдъя гэж байгаа гишүүд.

Ер нь энэ өмнөө тавьсан зорилгоо бид хэлэлцэж ямар нэгэн байдлаар шийдэх ёстой. Түүнээс энэ төслөө хэлэлцээртэй холбоотой асуудлыг эхлүүлчхээд, дундаас нь дутуу орхиод явна гэж байхгүй. Олон гишүүдийн байр суурь ер нь сунгаж хуралдъя гэсэн байдалтай байна шүү дээ. Тэгэхээр өнөөдөр шийдвэр гаргаад гадаад, дотоодод томилолтуудаа цуцлаад, чуулганы хуралдааныг 14 хоногоор сунгана гэдгээ би мэдээлээд ингээд өнөөдрийн чуулганаа хаагаад явъя болж байна уу? Тэгье, юмаа нээчих.

Ажлын цаг дууссан учраас одоо асуулт асуухаар бүртгүүлсэн 6 гишүүн асуулт асуугаад, үг хэлэх гишүүдийн нэрийг авахгүйгээр өнөөдрийн чуулганы нэгдсэн хуралдааныг хаана. Улсын Их Хурал ирэх 2 долоо хоногийн хугацаанд үндсэндээ сунаж ажиллах нөхцөл рүү орно, 2, 3 асуудлаа хэлэлцэж амжаагүй байгаа учраас сунгаж хуралдах нөхцөл рүү орох байх. Гэхдээ яг хэд хоногоор сунгаж хуралдахтай холбоотой асуудлыг Даргын дэргэдэх зөвлөл дээр хуралдааны тов дараалалтай холбоотой асуудлыг хэлэлцэхдээ шийдвэрлэнэ. Тэгэхээр энэ 6 гишүүнийг асуулт асууж дуустал өнөөдрийн нэгдсэн хуралдааныг үргэлжлүүлье. Доржсүрэнгийн Үүрийнтуяа гишүүн асуулт асууя.

Д.Үүрийнтуяа: Энэ Эксим банкттай хийж байгаа хэлэлцээр дээр нэг хэд хэдэн асуулт байна. Нэгтгээд аль болох товчхон асууя. 1 дүгээрт анхны хэлэлцээрээр 19 оны хэлэлцээрээр тэрбум 236 сая гэрээ хийгээд, одоо 34 хувь нь үнийн өсөлт орж ирж байгаа гэж ойлгоод байгаа шүү дээ. Энэ яагаад 44 саяар нэмэгдчихэв? 34 хувь нь 420 сая баймаар харагдаад байх юм, 464 сая доллар 44 нь юуных вэ?

2 дугаарт энэ үнийн өсөлтийг хаана баталгаажуулсан юм бэ? Хэн баталгаажуулсан юм бэ? Аудит хийгдсэн үү, хөндлөнгийн хяналт хийгдсэн үү? 236 сая ам.долларыг одоо энэ дараагийн 464 рүү нэмж, 700 болгож энэ хэлэлцээрийг хийж байгаа. Өмнөх хэлэлцээрээс татаж 236-г татаж байгаа шалтгаан нь юу вэ? Энэ сүүлийн хэлэлцээр дээр хэд хэдэн заалтууд хатуу заалтууд нэмэгдэж орж ирж байгаа шүү дээ. Энэ заалт дээр 236-г татаж оруулж ирж байгаа үндэслэл нь юу юм бол?

Мөн энэ зээлийн хэлэлцээр дээр нөхөн төлбөрийн асуудал тусгагдсан байгаа. Ерөнхий нөхцөл дээр. Энэ нөхөн төлбөрийн заалт маш хатуу заалт. Ямар нэгэн нөхөн төлбөр энэ гэрээ хэлэлцээртэй холбоотой асуудал үүсэх юм бол үүнээс учирсан хохирлыг нөгөө зээл олгож байгаа талын буюу Эксим банкны тодорхойлсон баримтаар нь шууд төлөхөөр байгаа, хохирлыг шууд нөхөн

төлөхөөр байх. Энэ бид нарт ер нь ямар эрсдэлийг дагуулж байгаа бэ? Хугацаандаа төлчихвөл асуудалгүй л гэдэг юм яригдаад байгаа юм л даа. Гэхдээ хугацаа хэтрэхээс гадна өчнөөн олон заалтууд энэ гэрээнд орчихсон байна хэлэлцээрт орж ирээд байна.

Дараагийн нэмэгдсэн нэг заалт нь энэ шүүхтэй холбоотой маргаантай холбоотой асуудал байгаа. Монгол Улсад үүссэн энэ хэлэлцээртэй холбоотой аливаа асуудлыг хэлэлцэхдээ Энэтхэгийн хуулийг барина гэсэн ойлголт орж ирээд байх юм. Энэ зөв үү? Тэгээд энэ гарсан шийдвэрийг нь Монгол Улсын шүүх ямар нэгэн маргаангүй зөвшөөрнө гэсэн баталгааг бид гаргаж өгөөд байна шүү дээ. Энэ хэр үндэслэлтэй заалтууд ингэж орж ирээд байгаа юм бол? Энэ асуултууд дээр хариултаа авчхаад, тэгээд нэмж тодруулъя.

Улсын Их Хурлын дэд дарга Х.Булгантуяа 18 цаг 20 минутаас хуралдааныг даргалав.

Х.Булгантуяа: Ажлын хэсгээс хэдэн номерын микрофоноос хариулах вэ? Жавхлан сайд, тэгээд шаардлагатай нэмээд ажлын хэсэг.

Б.Жавхлан: Үүрийнтуяа гишүүний асуултад хариулъя. Ер нь уул уурхайн чиглэлийн энэ томоохон төслүүдийн ТЭЗҮ-г хийдэг бидэнд ерөөсөө ганцхан л институт байдаг. Төсөв хийдэг лиценз бүхий мэргэжилтнүүдээс, экспертүүдээс бүрдсэн Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөл гэж. Бидэнд ерөөсөө 3, 4 яаман дээр ийм ТЭЗҮ төсөв хийдэг 4 ийм институт байгаа. Барилга, хот байгуулалтын хөгжлийн төв, Эрчим хүчний хөгжлийн төв, Зам тээврийн хөгжлийн төв, Уул уурхай яамны Эрдэс баялаг мэргэжлийн зөвлөл гээд. Тэнд хийгдсэн ийм төсөв. Тэндээс гараад ирсэн төсвийг ямар ч байсан Засгийн газрын түвшинд бид ерөөсөө өөрчлөх, тэрийг засварлах ч гэдэг юм уу тийм хууль, эрх зүйн ямар ч зохицуулалт ер нь байдаггүй. Бид яах вэ нэг үсрээд л Аудитын ерөнхий газар луу явж аудитлуулдаг. Энэ төслийг ч гэсэн мөн шаардлагатай бол аудит руу явуулж аудитлуулна, ийм байна.

236 сая доллар бол ингэсэн юм.ы EPC 4-д зориулсан нэмэлт санхүүжилт гэж ойлгоод байгаа юм. Энэ 4 EPC 2, 3 дээр ч энэ нэмэлт санхүүжилтийн хэсгүүд орох юм байгаа юм. Тэгэхдээ 236 сая доллар сүүлд нэмж хийсэн гэрээ дээрээ бүх гэрээний нөхцөл юмнууд нь ижилхэн байгаа учраас ийм тусдаа гэрээ хийхгүй, энийг нэг гэрээ болгоод ингээд 700 гэсэн дүнтэй хийе гэдэг ийм саналыг Энэтхэгийн талаас тавьсан. Тэгээд энэ хугацаа, нөхцөлүүд нь ижил учраас энийг ингээд нэгтгээд явж байгаа гэсэн үг.

Нөхөн төлбөрийн хувьд тийм байгаа. Зээлдүүлэгч тал маш хатуу нөхцөл тавьж байгаа. Энийг бид нэлээд хэлэлцээр хийсний дүнд зарим нэг заалтууд нь өөрчлөгдсөн. Тэгээд энийг бид зөвшөөрөөд ингээд 2 талаасаа үзэглэсэн байгаа. Энийг одоо бид илүү их хариуцлагатай байхыг л бид нараас шаардаж байгаа. Энд нэг буруу зүйл би байхгүй болов уу гэж бодож байна. Зүгээр өөр байгалийн ч юм уу, дахин давтагдашгүй ийм нөхцөлүүд юу болж үүсэх юм байгаа юм. Болж өгвөл бид яг хугацаанд нь ингээд л ашиглалтад оруулаад, өөрөө өөрөөр нь энэ төсөл зээлээ төлөөд явах тэр хугацаандаа л бушуухан хүрмээр байгаа юм. Тэр маргаантай холбоотой тэр асуудлууд дээр ажлын хэсгээс нэмэлт мэдээлэл өгөөдөх.

Х.Булгантуяа: Ажлын хэсгийн 19 номерын микрофон.

Л.Гантогтох: Үүрийнтуяа гишүүний асуултад хариулъя. Гэрээ дээр бол холбогдох маргаан гарсан тохиолдолд хэлэлцээрийн хавсралт болон ерөнхий нөхцөл нь Энэтхэг улсын IDS-ийн журмаар зохицуулагддаг. Тус журамд нь болохоор хэрвээ маргаан гарах юм бол маргаан нь болохоор Бүгд Найрамдах Энэтхэг Улсын хуулиар зохицуулагдахаар ийм заалт байгаа. Тэгэхдээ ерөнхийдөө энэ заалтууд өнгөрсөн бүх 2017 болон 19 онуудад соёрхон батлагдсан гэрээнүүд дээр ингээд тусгагдаад явсан заалт. Маргаан гараад хэрвээ шүүхээр шийдвэрлэгдэх тохиолдолд олон улсын арбитрын шүүх дээр очиж ингэж шийдвэрлэгдэх ийм заалт мөн гэрээний 12 дугаар зүйл дээр байгаа.

Х.Булгантуяа: Микрофоноо нэмээд өгчхөөрэй. Хариулт нь дуусаагүй байгаад байна.

Л.Гантогтох: 236 сая ам.долларын өмнөх зээлийн гэрээг 700 болгож байгаа нь яг Энэтхэгийн Эксим банкнаас тавьсан санал. Яг Сангийн сайдын хэлсэнчлэн өмнөх 236 болон одоогийн нэмэлт авч байгаа 460 сая, 64 сая ам.долларын зээл бол нөхцөл нь ижилхэн, дүн нь ижилхэн, тэгээд тавигдаж байгаа нөхцөл нь ижилхэн, санхүүжүүлэх зорилго нь мөн ижилхэн болохоор Энэтхэгийн талаас 2 тусдаа зээл биш нэгтгэсэн нэг гэрээ хийе гэдэг ийм санал ирүүлсний дагуу 700 сая долларын зээлийн гэрээ байгуулагдаж байгаа.

Х.Булгантуяа: Үүрийнтуяа гишүүн нэмж тодруулъя.

Д.Үүрийнтуяа: Монгол Улс газрын тосны үйлдвэр хэрэгтэй юу гэвэл хэрэгтэй. Бид энийг нэн яаралтай барих ёстой. Гэхдээ өнөөдөр энэ орж ирж байгаа хэлэлцээр 19 оны хэлэлцээрийн нөхцөлүүд дээр нэмэгдэж байгаа л гэж байгаа юм. Монгол Улсад маш хатуу, маш хатуу нөхцөлтэй. Өмнө нь авчихсан бид тэрбум 236 сая ам.долларынхоо өнөөдөр дөнгөж 268 сая долларыг л зарцуулсан шүү дээ. Үлдэгдэл нь 968 сая доллар дээр үндсэндээ 0,5 хувийн хүү төлөөд явж байгаа. Гэтэл дээрээс нь үнийн өсөлтийн 464, тэр 44-ийг надад тайлбарласангүй. 464 гэдэг тоо орж ирээд байгаа юм, 420 юм шиг байгаа юм уг нь, нэмэгдэж орж ирээд. Тэгээд энэ үнийн өсөлтийн асуудлыг заавал өмнөх дүнгээ, өөрөөр хэлбэл 900 гаруй тэр сая долларын үлдэгдэл байхад яаран дааран оруулж авах шаардлага, үндэслэл нь юу байсан юм бол доо? Монгол Улсад үр ашигтай байх талаа л бодмоор байгаа юм.

Х.Булгантуяа: Үүрийнтуяа гишүүн сая үг хэллээ. Улсын Их Хурлын гишүүн Дашцэрэнгийн Энхтүвшин.

Д.Энхтүвшин: Газрын тосны төслийн хувьд бүгд эргэлзээгүй улсад хэрэгтэй төсөл байгаа. Тэгээд гол асуудал нь яах вэ өмнөх нөгөө асуулт, гишүүдийн асуултыг харахаар өмнөх яг энэ гэрээтэй нэлээн холбогдолтой асуудлууд байна. Тэгээд одоогийн яг энэ зээлийн хэлэлцээр маань болохоор ЕРС 4-тэй холбоотой асуудал байгаа. Тэгээд хэрвээ энэ төсөл маань энэ зээлийн хэлэлцээр маань батлагдахгүй бол ЕРС 4-тэй холбоотойгоор ямар эрсдэлүүд байгаа энэ талаар хэлж өгөөч? Бүгдээрээ нэг юмыг аягүй сайн тодорхой ойлгох хэрэгтэй гэж бодож байгаа. Мега төсөл бол зүгээр энгийн төслүүдийг одоо нэг жилийн дотор хэрэгждэг

ч юм уу, цөөн богино хугацаанд хэрэгждэг төслүүдтэй харьцуулахад ер нь асар олон эрсдэлүүд байдаг. Ялангуяа макро том эрсдэлүүд байдаг. Тэгэхээр энийг бид нэлээн сайн ойлгох хэрэгтэй байх гэж бодож байна. Тэгээд энэ дээр цаг хугацааны хувьд байнга хойшилдог. Энэ төсөл маань энэ жил анх эхэлж орно гэж байсан. Одоо дахиад 36 сарын асуудал яригдаж байна. Төслийн дүнгийн хувьд том төслүүд байнга нэмэгддэг. Энэ дүн маань анх эхэлж 1 тэрбум орчим доллар гэж байсан бол одоо 1,7 орчим болж байна. Тэгэхээр яах вэ ер нь ингээд төслийн менежментийг сайн явуулах нь нэлээн энэ эрсдэлүүдийг багасгах бололцоонууд байдаг. Тэгэхээр компанийн удирдлагууд энэ тал дээрээ нэлээн сайн анхаарч ажиллана биз.

Тэгээд гол нь нэг ийм асуулт байна. Саяын яг энэ зээлийн хэлэлцээр батлагдахгүй бол ямар эрсдэлүүд байна гэж Сангийн сайдаас асуумаар байна. Нөгөө талаас компанийн захирлаас ер нь ямар том эрсдэл, зовлонгууд байна, макро болон өөр компанийн түвшинд ямар эрсдэлүүд байна вэ? Энэ талаар мэдээлэл хуваалцаач гэж хүсэж байна.

Х.Булгантуяа: Жавхлан сайд хариулъя.

Б.Жавхлан: Энхтүвшин гишүүний асуултад хариулъя. Ер нь хэрвээ энэ удаа эх үүсвэр нь ингээд тодорхойгүй байдалд орчих юм бол төсөл өөрөө хэзээ ашиглалтад орох нь тодорхойгүй болно. Төслийн өртөг өөрөө бас тодорхойгүй болно. Ямар шалтгаан байгаа вэ гэхээр ЕРС 2, 3, 4-ийг хэрэгжүүлэхээр тендерт шалгарсан Мега инженеринг компани энэ нэмэлт эх үүсвэрээр хийгдэх гэрээнийхээ үнийн саналыг 23 оны 2 сарын 18-нд өгсөн үнэ юм байгаа юм. Үндсэндээ бараг 23 сарын өмнө гэсэн үг. Ингээд оны өмнө бидэнд мэдэгдсэнээр компаниар, компанид мэдэгдсэнээр хэрвээ нэг сардаа гэж байгаа нэг сардаа багтааж хэрвээ бид гэрээгээ үзэглэж чадахгүй бол бид нарын 2 жилийн өмнө өгсөн үнийн дүн, үнийн санал хүчингүй болж байгаа шүү. Бид энэ дүнгээрээ цаашаагаа хийж чадахгүй, гэрээлж чадахгүй. Аль хэдийн оны өмнө хэлэлцээр эхлэхээс өмнө энэ чинь бараг 2 жилийн өмнө өгсөн бидний үнийн санал, одоо аль хэдийн 14 хувиар төсөвт өртөг нь нэмэгдчихсэн байна шүү. Бид энийг ингэж өсгөж байж гэрээгээ хийхгүй бол бас хийхгүй гэдэг ийм нөхцөлтэй байсан.

Хэлэлцээр хийгээд тэр нэмэлтийг нь ямар ч байсан бид нэг сар гэхэд гэрээгээ хийнэ гэдэг ийм нөхцөлтэйгөөр тэрийг нь ямар ч байсан буулгасан. Тэгэхээр бид гэрээгээ дуусгах хамгийн сүүлийн том ЕРС 4 гээд хамгийн гол хэсгийнхээ гэрээг хийж чадахгүй ийм л эрсдэл үүснэ гэсэн үг. Тэгэхээр төсөл өөрөө бүхэлдээ тодорхойгүй, ашиглалтад орох хугацаа нь тодорхойгүй, үнэ өртөг нь ч дахиж нэмэгдэх ийм эрсдэлд орно гэсэн үг юм байгаа юм.

Х.Булгантуяа: Ажлын хэсгийн 21 номерын микрофон нэмж хариулъя.

Д.Алтанцэцэг: Алтанцэцэг Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ТӨК-ийн гүйцэтгэх захирал. Энхтүвшин гишүүний асуултад Жавхлан сайдын хариулт дээр нэмж хариулт өгье. Сая Жавхлан сайд хэллээ. ЕРС 4-ийн гэрээ болгон өөрийн гэсэн хэрэгжих хугацаатай байгаа. Бид дамжуулах хоолой, 4 инженерчлэл, худалдан авалт, барилга угсралтын гэрээ, төвөгшил, барилга байгууламж, тоног төхөөрөмжийн үйлдвэрлэлээсээ шалтгаалаад 28, 32, 36, 38 гэсэн саруудаар хэмжигддэг. Тэгэхээр өдөр бол тодорхой. Бид өнөөдөр энэ Улсын Их Хурлаар энэ

хэлэлцээрийг соёрхон баталчихвал бидэнд гэрээгээ байгуулах эрх үүсэж байгаа юм. Засгийн газар гэрээ байгуулах эрх өгнө. Түүнээс хойш л хугацаатай тоолно. Тийм учраас бидний өнгөрсөн түрүүн Жавхлан сайд хэллээ. Тендер шалгаруулалт 2023 оны 3 сард дуусчхаад, бид энэ өөрсдийн хичээл.../минут дуусав/

Х.Булгантуяа: Нэмж микрофон өгье.

Д.Алтанцэцэг: Өөрсдөөс шалтгаалахгүй ийм шалтгаанаар энэ чинь Энэтхэг улсын Засгийн газар ажиллаж байна. Энэ жил санхүүгийн жил нь 3 сард хаадаг энэ том орны сонгууль энэ тэр болсон, Засгийн газар нь шинээр бүрэлдсэн гээд ийм хүчин зүйлүүд төсөл хэрэгжих хугацааг эрсдэл дагуулдаг. Би ковидыг ярихаа больё. Мөн ЕРС 2, 3 тэр зээлийн хэлэлцээрүүдийг хувааж Монголын талд ашигтай хэлэлцээ хийхэд мөн 6-аас 8 сар орсон гэх мэтчилэн ийм эрсдэлүүд байгаа.

Одоо энэ гэрээг байгуулчихвал бидэнд яг бодитой эрсдэл байхгүй. Гадаадад гэнэтхэн дайн дажин, геополитикийн асуудал юу байдаг юм хямрал гарчихгүй л бол бид ингэж төр засгаас шууд хамаарах ийм юм зүйл ер нь байхгүй болно. Бэрхшээлийн талаар танд дэлгэрэнгүй танилцуулж, бидэнд олон бэрхшээл бий.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан.

Л.Мөнхбаясгалан: Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хороон дээр мэргэжлийн Байнгын хороон дээр Монголын газрын тос боловсруулах үйлдвэрийг хянан шалгах ажлын хэсгийг би өөрөө ахалж байгаа. Манай ажлын хэсэгт 11 гишүүн байгаа. 2 удаа газрын тосны үйлдвэрт очих гээд очиж чадсангүй. Бид хаврын чуулганд дүгнэлтээ танилцуулах ёстой байсан. Гэтэл энэ зээлийн асуудал ингээд яаралтай гээд ороод ирж байгаа. Би зүгээр товчхон хэлье.

Одоогоор авсан зээлүүд нь газрын тос дамжуулах хоолойн зээл 397 сая доллар, Эксим банкнаас Энэтхэгийн Эксим банкнаас одоо нээгдчихсэн байгаа нь 1 тэрбум 236 сая доллар, Монгол Улсын хөгжлийн банкнаас авсан зээл нь 248 тэрбум ийм зээлтэй компани байгаа. Гэтэл одоо дахиад зээлээ 1,7 тэрбумд хүргэх гэж байгаа байхгүй юу. Би зүгээр эндээс ЕРС 3 дээр гарсан ганц л үйл явдлыг хэлж өгье гэж бодож байна. Зүүн бүсийн Дулааны цахилгаан станц 50мвт-ын, энийг 81 сая доллароор Монгол Улс өөрөө барьсан. Гэтэл энэ газрын тосны үйлдвэр дээр 35мвт-ын дулааны цахилгаан станцыг 189 сая доллароор барих гэж байгаа. Эхний санхүүжилт нь орчихсон байгаа. Ийм л тэнгэр газар шиг ялгаатай ганцхан жишээ л байгаа. Энэнээс цаашаа ярих юм бол зөндөө юм ярьж болно.

Мега инженеринг гээд компани байгаа. ЕРС 2, 3, 4-ийг тендерт ялсан байгаа. Энэ компани дахиад газрын тосны олборлолт, хайгуул дээр нь орж ирэхээр саналаа өгсөн байгаа. Энэ компанид өгөхөөс өөр аргагүй нөхцөл байдал үүссэн. 19 орны 56 компанид санал болгосон байгаа. Манай улсын газрын тосны энэ хайгуул, олборлолт дээр хөрөнгө оруулж ажиллаач гэсэн. Ямар ч санал ирээгүй. Тийм учраас арга буюу энэ Энэтхэгийн Мега инженеринг компанитай дахиад гэрээ байгуулах гэж байгаа. Одоо энд ингээд 431 сая долларыг бид баталж өглөө гэхэд дахиад 28 ондоо, 27 он ашиглалтад орно гэсэн баталгаа байхгүй. Багц

болгон дээр тендер зарладаг, хэд дахин даблдсан үнэ ирдэг, тэрийг нь дахиад буулгаач гэдэг санал тавьдаг. Энэ дээр ер нь ихэнх цагаа зарцуулсан болов уу гэж бодож байна. Тэгэхээр ажлын хэсгийг ажиллах боломжийг олгож өгөөч. Хэрвээ чуулган дахиад 14 хоногоор хойшилж байгаа бол Ажлын хэсэг дахиад ажиллая. Бид уг нь хуулиараа хаврын чуулганд ажлаа тайлагнах ёстой ажлын хэсэг. Наана нь тайлагнах гээд хичээе. Энэ зээлийг бид нэлээн сайн бодож, соёрхон батлах ёстой юм. Надад асуулт байхгүй та нараас, зөндөө асуусан. Ажлын хэсгийн ажиллах боломжийг л хангаж өгөөч гэж санал оруулж байна.

Х.Булгантуяа: Мөнхбаясгалан гишүүн үг хэллээ. Гончигдоржийн Уянгахишиг гишүүн.

Г.Уянгахишиг: Бүх гишүүд л ерөнхийдөө хэлж байна. Энэ өөрөө нөгөө яаралтай горимоор буюу гэнэт орж ирсэн учраас бид яг энэ гэрээ хэлэлцээ, гэрээний төсөлтэй танилцаж, бүрэн танилцаж амжсангүй. Тэгээд ямар ч байсан нэг ийм шууд бодогдож байгаа ямар ч байсан 3, 4 асуулт байна. 1 дүгээрт түрүүн Үүрийнтуяа гишүүн ч гэсэн хэлсэн, энэ гэрээ маань өөрөө Энэтхэг улсын хуулиар зохицуулагдаж байгаа. Тэгэхээр энэ яг гэрээ дээр хуулийн дүгнэлт хийлгэж авсан юм уу? Өөрөөр хэлбэл хэрвээ Энэтхэг улсын хуулиар хийгдэж байгаа гэрээ бол энийг яг Энэтхэг улсын хууль мэддэг хуульч эсвэл хуулийн компани хуулийн дүгнэлт гаргасан байх ёстой. Тэр нь бид нарт одоо танилцуулагдаж байх ёстой байхгүй юу. Тэгэхгүй бол яг энэ гэрээний агуулга яг ямар үр дүнг бий болгож байгаа юм бэ, жишээлбэл дефолт үүссэн тохиолдолд ямар хамгаалалт байгаа юм бэ?

Нөгөө талаасаа энэ гэрээ дээр чинь яг Энэтхэгээс заавал авах ёстой бараа материалын квоттой байж байна. Гэтэл энэнээс хамаараад болон гүйцэтгэгч нь Энэтхэг тал. Тэгэхээр энэ контрактор болон бараа нийлүүлэгчээс, үйлчилгээ үзүүлэгчээс хэрвээ дефолт болоход нөлөөлсөн бол энэ зээлийн эргэн төлөлт дээр яаж нөлөөлөх юм бэ? Энэ талаар жишээлбэл ЕРС контрактад нь тусгаж байгаа юм уу, үгүй юм уу? Түүн дээр контрактрын хариуцлага нь яаж бууж ирж байгаа юм гэдэг юмыг мэдмээр байна давхар. Энэ чинь өөрөө багц гэрээнүүд яваад байна шүү дээ. Тэгээд үүнээс гадна одоо бид ингээд зээлийнхээ хэмжээг нэмчихлээ. Бид өмнө нь яагаад зээлээ ашиглаж чадахгүй байсан гэхээр төсөв хэлэлцэх үеэр хэлж байсан. Нөгөө таазандаа тулаад ашиглаж чаддаггүй.

Гэтэл одоо энэ зээлийн гэрээ чинь 260 биш, 700 болоод өсөөд ороод ирэхээр нөгөө ашиглаагүй зээлийн үлдэгдэлд тооцогдох хүүгийн хэмжээ чинь бүүр өндрөөр бодогдож эхэлнэ. Тэгэхээр бид яг энэ 700-гийнхаа гэрээг хийчхээд, нөгөө таазандаа тулгаад дахиад л ашиглаж чадахгүй удах юм биш биз дээ? Хэдэн жил, одоо яг Сангийн сайдаас асуумаар байна л даа. Өнөөдөр бид энэ 700 сая долларыг зээлийн гэрээгээ зурчхаад тэр даруйд нь хэрэглээд эхлэх боломж бидний нөгөө төсвийнхөө шаардлагын хүрээнд байгаа юм уу? Тэгэхээр ингээд базаад хэлэх юм бол 3 асуулт байгаад байна шүү дээ. 1 дүгээрт хуулийн дүгнэлт Энэтхэг улсын хуулиар мэргэшсэн хуульчаас дүгнэлт гаргуулсан уу? 2 дугаарт яг ЕРС контрактор тэр Энэтхэгийн талаас үйлчилгээ үзүүлэгч, бараа нийлүүлэгчээс ямар нэгэн байдал гэрээний зөрчил гаргасан тохиолдолд бид энэ дефолт, төлбөрийн дефолтоос буюу энэ төлбөрийн хуваарьт өөрчлөлт орох уу? 3 дахь нь яг энийг шууд бид ашиглах боломж нь байгаа юу гэсэн ийм 3 асуулт.

Х.Булгантуяа: Гэрээтэй холбоотой асуулт Жавхлан сайд хариулъя.

Б.Жавхлан: Тийм. Уянгахишиг гишүүний асуултад хариулъя. Ирэх 2025 оны төсөв дээр энэ зээлийн ашиглалт тусгагдсан байгаа учраас ямар ч асуудалгүй бид ашиглаад эхлээд явж болно. Харин хугацаандаа ашиглалтад оруулахын тулд энэ жилийн батлагдсан зээлийн ашиглалт хүрэлцэхгүй байх эрсдэлтэй, хүрэлцэхгүй байх эрсдэлтэй. Тийм учраас нэмж байж, өөрөөр хэлбэл 1,7-гийнх чинь бид 236, 268-ыг нь ашиглачихсан гэдэг чинь цаана нь ингээд 1 тэрбум 440-өөд сая доллар ашиглах болно шинээр тийм ээ. Энэ чинь одоогийнхоо ханшаар бараг 4,2 их наяд төгрөг байхгүй юу. Тэгэхээр 4,2 их наяд 38 сарын хугацааны дотор бид ашиглаж дуусгах хэрэгтэй байхгүй юу 38 сарын дотор. Тэгэхээр одоо 25 он, 26, 27 онуудад дор хаяж 1,5-аас 6 их наядын ашиглалт гаргаж байж, хэдүүлээ энэ яригдаж байгаа энэ хугацаандаа ашиглалтад орохыг нөгөө гүйцэтгэгч компаниас шахах л ийм асуудал үүснэ. Тийм. Тэгэхдээ ямар ч байсан бүгдээрээ соёрхон баталж аваад, эх үүсвэрээ батлаад авчих юм бол тэр бол дараагийн ажил нь болж байгаа. Энэ жилдээ 350-аас 400 тэрбум төгрөгийн ашиглалт одоо бол батлагдсан төсөв дээр бидэнд боломж байгаа.

Х.Булгантуяа: Нөгөө 2-т ажлын хэсгийн 21 номерын микрофон.

У.Чинзориг: Гишүүний асуултад нэмээд хариулъя. Гүйцэтгэгч компани гэрээлэгч гүйцэтгэгч компанийн инженерчлэл, барилга угсралт, худалдан авалт барилга угсралтын гэрээгээр хүлээсэн үүрэг хариуцлага бол манай олон улсын гэрээгээр хүлээж байгаа энэ зээлийн нэмэлт зээлийн гэрээгээр хүлээж байгаа үүрэг хариуцлагатай бол ямар ч холбоогүй. Яах вэ зүгээр энэ ЕРС гэрээгээр гүйцэтгэгч ямар хариуцлага хүлээж байна хугацаандаа ашиглалтад оруулахгүй бол ямар хариуцлага хүлээх вэ гэдэг асуудал дээр бол хугацаандаа энэ ЕРС 4-ийн хувьд жишээлбэл 38 сарын дотор ажлаа бүрэн дуусгах ёстой. Энэ 38 сарын дотор ажлаа дуусгаагүй тохиолдолд 1 дүгээрт алданги торгууль төлөх ийм заалттай. Дээрээс нь гүйцэтгэгч компани барьцаа хөрөнгө суутгуулж байгаа, барьцаа суутгуулж байгаа. Дээрээс нь гүйцэтгэл.../минут дуусав/

Х.Булгантуяа: 21 номер нэмж хариулъя. Ажлын хэсгийнхэн нэрээ, ажлынхаа юунд протоколд үлдээх ёстой байгаа шүү албан тушаалаа.

У.Чинзориг: Монгол газрын тос боловсруулах үйлдвэрийн Гэрээ, эрх зүйн газрын дарга Чинзориг. Нэмээд хариулъя. Тэгэхээр энэ гүйцэтгэгч компани нь энэ ЕРС гэрээгээр хүлээсэн үүргийнхээ хүрээнд хугацаандаа ажлаа дуусгаагүй бол 1 дүгээрт энэ алданги торгууль төлнө. Цаашлаад энэ компаниас барьцаа суутгуулсан байгаа. Дээрээс нь гүйцэтгэлийн баталгаа банкнаас гаргаж өгсөн байгаа. Тэгэхлээр яах вэ хугацаандаа дуусаагүй бол алданги торгууль төлөх нь юунаас гэрээний үүргээсээ бол хариуцлагаас чөлөөлөгдөхгүй. Цаашаа гэрээнийхээ дагуу ажлаа заавал хийж дуусгах ёстой гэсэн гэрээтэй.

Х.Булгантуяа: 19 номерын микрофон. Энэтхэгийн хуулийг мэддэг компаниар дүгнэлт гаргуулсан уу хуулийн фермээр гэсэн.

Л.Гантогтох: Сангийн яамны Өрийн удирдлагын хэлтсийн дарга Гантогтох. Уянгахишиг гишүүний асуултад хариулъя. Хууль зүйн дүгнэлтийн хувьд Сангийн яаман дээр зээлийн хэлэлцээрийн төсөл бол 2024 оны 12 сарын 25-ны өдөр ирсэн. Үүний дараа Сангийн сайдын тушаалаар ажлын хэсэг байгуулагдан зээлийн

хэлэлцээрийг түүнээс хойш 1 сарын 8-нд Засгийн газрын хуралдаанд танилцуулах хүртэл хийсэн. Уг ажлын хэсэгт Хууль зүйн яамнаас, холбогдох газрын тос болон Уул уурхайн яам зэрэг холбогдох байгууллагуудаас ингэж орж ажилласан байгаа. Тэгэхээр Хууль зүйн яамнаас яг энэ гэрээний төсөл дээр суугаад ингээд холбогдох дүгнэлтээ тухай болгон өгөөд ингээд явсан. Яг олон улсын гэрээ хэлэлцээрийн тухай болохоор яг энэ Энэтхэгийн зээл болон бусад гадаад зээлийн гэрээ дээр хууль зүйн дүгнэлтийг соёрхон батлагдсаны дараа байгуулах Энэтхэгийн талд болон холбогдох зээлдэгч талд гаргаж.../минут дуусав/

Х.Булгантуяа: Үгүй ээ гэрээгээ байгуулчхаад дараа нь хууль зүйн дүгнэлт гаргуулна гэж юм байхгүй байлгүй дээ энэ чинь. Байгуулах гэж байгаа гэрээ ингээд байгаа шүү дээ. Жавхлан сайд нэмж хариулах уу?

Б.Жавхлан: Гишүүний асуултад зүгээр нэмэлт мэдээлэл өгье. Бид бүх гадаад гэрээ хэлэлцээ дээр Засгийн газар Засгийн газрын өөрийн хуульч буюу Хууль зүйн яам энэ институт өөрөө дүгнэлт гаргадаг. Гэрээ хэлэлцээр дээр ч ажлын хэсэг дээр Хууль зүйн яамаа төлөөлж хүмүүс оролцоод явна. Наана нь ажлын хэсэг дээрээ байнга л энд чинь дүгнэлт гаргаад явна. Соёрхон баталсны дараа дахиад дүгнэлт гаргадаг. Бүх гэрээ хэлэлцээр дээр. Тэгээд тэрийгээ Засгийн газарт танилцуулдаг. Тэрнээс биш гэрээ хэлэлцээр болгон дээр цаад талын юм уу, хөндлөнгийн тийм гэрээ хуулийн дүгнэлт хийх тийм институт гэрээ хэлцэл хийх тийм юм бол байдаггүй.

Х.Булгантуяа: Уянгахишиг гишүүн тодруулъя.

Г.Уянгахишиг: Тэгэхээр ийм байна. 1 дүгээр асуултын хариултын хувьд болохоор энэ төслийн хувьд мэдээж зарцуулалт нь ойлгомжтой. Тэгэнгүүт бусад төслүүд бас аягүй том төслүүд бид төлөвлөчихсөн байгаа шүү дээ. Тэгэхээр тэр төслүүдтэйгээ ингээд чихцэлдээд, нөгөө гаргаж чадах биз дээ? Тийм, түгжрэл үүсээд, энийгээ дахиад нөгөө ашиглаагүй үлдэгдэл жилийн 0 5 хувийн хүүтэй байгаа шүү дээ. Тэгэхээр энэ чинь өөрөө аягүй том дүн байхгүй юу 700 сая доллар дээр гээд л бодоход тийм ээ. Тэгэхээр энэ талаасаа асуумаар байгаа юм нэмж.

2 дугаар асуултын хувьд болохоор ЕРС гэрээ огт хамааралгүй биш л дээ. Өөрөөр хэлбэл ЕРС гэрээнийхээ алданги торгуулийн хэмжээг энэ гэрээнийхээ Засагт оногдох хариуцлага байгаа шүү дээ дефолт хүү байгаа. Тэд нартайгаа уяж оруулж ирж байгаа юу? Түүн дээр бид сайн ажиллах ёстой. Тэгэхгүй бол энэ чинь өөрөө буцаад алдагдал болоод орж ирнэ шүү дээ. Тэрийг нэмж асуумаар байна. Гуравдугаархын хувьд Хууль зүйн яаманд Английн хуулиар мэргэшсэн хуульчид байж магадгүй.../минут дуусав/

Х.Булгантуяа: Нэмж, шаардлагагүй юутай, хангалттай биш гэвэл нэмж тодруулж болохоор байгаа. Тэгэхээр хариултаа эхлээд авчхаад, тэгээд тодруулчих, тэгэх үү? Энэтхэгийн хуулиар мэргэшсэн хуульч Хууль зүйн яаманд байхгүй байж магадгүй шүү гэж Уянгахишиг гишүүн хэлж байх шиг байна. Эхлээд хэн хариулах вэ? Жавхлан сайд хариулах уу? Зээлийн ашиглалт чинь гацаад бас л хий хүү төлөөд байх юм биш үү?

Б.Жавхлан: Ер нь бид одоо 1900, сүүлийн, 2000 оноос хойш гэрээ нь соёрхон батлагдсан Их Хурлаас эрх өгөөд төслүүд нь хэрэгжээд явж байгаа 84

төслийн 10 их наяд төгрөгийн ийм зээлийн ашиглалт хүлээгдэж байгаа. Энэ жил бид 1,5 хувийг л ашиглана 2025 онд. Уг нь бид нэлээн том дүнтэй орж ирж байсан. Ингээд бид алдагдалгүй төсөв гэдэг нэг ийм том бодлогын шилжилт хийсэн. Тийм учраас 25, 26 он дээр томоохон жишээ нь энэ төслийг бид амжилттай хугацаанд нь хэрэгжүүлэхийн тулд нэмэлт дор хаяж 1,5 их наядын зөвхөн энэ төсөл дээр зээлийн зарцуулалт хийх шаардлагатай болж байгаа. Яах вэ 350-аас нь 400 орчмыг бол одоо байгаа дээр гаргачихна. Тэгэхээр зөрөө 1.1, 1.2 орчмыг бид нэмж гаргахаас өөр.../минут дуусав/

Х.Булгантуяа: Ажлын хэсгээс 21 номерын микрофон.

У.Чинзориг: Монгол газрын тос боловсруулах үйлдвэрийн Гэрээ, эрх зүйн газрын дарга Чинзориг нэмээд хариулъя. Ер нь аливаа ялангуяа энэ барилга угсралтын ажлын гэрээгээр торгууль алданги гэдэг нь нэг талдаа ажлаа хугацаандаа хийж дуусгах нэг хэрэгсэл мөн. Нөгөө талаараа торгууль алдангийг тооцсоноор ажлаа хугацаандаа дуусгаагүй бол захиалагч талд Монголын талд үүсэж болзошгүй эрсдэлийг хаах бас нэг юу л болж байгаа юм л даа хэрэгсэл. Тэгэхээр яах вэ таны хэлж байгаа саналыг бид ойлголоо. Энийг ингээд эргэн төлөлт дээр ингээд юу яах боломжийг бид Сангийн яамтайгаа ярилцана.

Х.Булгантуяа: Уянгахишиг гишүүн хариулт хангалттай биш байна гэж үзвэл 1 минут асуухаар байгаа.

Г.Уянгахишиг: Сангийн сайдаас дахиад нэг тодруулга авчих гээд. Дээр төсөв хэлэлцэж байхад бид яригдаж байсан шүү дээ. Ингээд нэгэнт Засгийн газар дээр түгжрээ үүсээд байдаг юм бол өөр бүтцээр явах боломж байдаг юм уу? Өөрөөр хэлбэл Эксим банк хооронд гэрээ хийгдэх боломж байдаг уу? Манай Хөгжлийн банк ч юм уу оролцоод явах боломж нь байдаг уу? Заавал Засгийн газар орж нөгөө өөрийнхөө зарцуулалтын түгжрээндээ орох хэрэг байна уу, үгүй юү гэдэг.

2 дахь дээр болохоор тэр хууль зүйн дүгнэлттэй холбоотойгоор ер нь бид ийм том гэрээ хэлцлүүдэд орж байхад дандаа аягүй том үнийн дүнгүүд явж байгаа. Хариуцлагын хэмжээнүүд ч өндөр явж байгаа. Энэ тохиолдолд хэрвээ яг энэ хууль гэрээ өөрөө Монгол Улсын хуулиар биш, Англи улсын хуулиар биш буюу түгээмэл биш хуулиар зохицуулагдаж байгаа тохиолдолд заавал хуулийн дүгнэлтийг урьдчилж авч байх ёстой гэж би харж байна. Яагаад гэхээр бид юу гэдэг юм Сангийн яаманд байгаа хуульч мэргэжилтнүүд эсвэл.../минут дуусав/

Х.Булгантуяа: Уянгахишиг гишүүний асуултад Жавхлан сайд хариулъя.

Б.Жавхлан: Уянгахишиг гишүүн их зөв санал хэлж байна. Цаашаагаа бид төсвөөр санхүүжүүлдэг боломж маань улам л хязгаарлагдмал болж байна. Тэгэхээр Эксим банк to Эксим эсвэл Эксим банк to манай Хөгжлийн банк иймэрхүү хэлэлцээрүүдийг цаашаагаа бид энэ рүүгээ шилжинэ. Эсвэл бид value exchange баялгийн солилцоо ч гэдэг юм уу бусад өөр шууд хөрөнгө оруулалт, төр, хувийн хэвшлийн түншлэл гээд энэ бүх боломжуудаараа бид цаашаагаа явах хэрэгтэй болж ирж байгаа юм. Тийм л бодлогын шилжилт хийж байна гэсэн үг. Энэ гэрээний хувьд энэ аль 19 онд хэлэлцсэн гэрээ. Цаад талаас өгөхдөө танай Засгийн газарт өгнө гээд ингэчихсэн. 2 талт гэрээ олон улсын хөгжлийн институт биш, 2 талт

гэрээгээр явж байгаа ийм зээлүүд дандаа ер нь цаад талдаа цаад талынхаа шаардлагыг бид авч явахаас өөр аргагүй байдаг. Олон улсад нэг иймэрхүү жишгээр явдаг. Цаад талынхаа экспортыг дэмждэг ч байх жишээтэй. Цаад талынхаа хуулиар явна, хуулиар явна. Одоо бид.../минут дуусав/

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Бадамдоржийн Пунсалмаа.

Б.Пунсалмаа: Сайн байцгаана уу. Дорноговь аймгийн Алтанширээ сум дахь Нефть боловсруулах үйлдвэрт 1,2 сая тэрбум долларын гэрээг Энэтхэгийн Засгийн газартай хийсэн. Энэ 2017 онд хийсэн гэрээ байгаа. Одоогоор 268 сая долларын санхүүжилт ороод EPC-1 буюу эхний шатын үйл ажиллагаагаа гүйцэтгэчихсэн байгаа. Цаашдаа 4 ер нь нийтдээ 4 үе шат үйлдвэрүүдийн барилгажилтын ажил байж байгаа. Тэрний эхний шатыг нь дөнгөж гүйцэтгэсэн. Цаашид энэ 3 үе шатыг хийж гүйцэтгэхийн тулд бид хийх гэж байна, гүйцэтгэж байна, хүлээж авч байна, дараачийн зээл, санхүүжилт, хүү гээд маш олон ажил болох шинжтэй байна. Цаг хугацаандаа амжих уу? Ингэж бид бүх зүйлийг детальчлах хэрэг байна уу?

Энэ нэгэнт л Энэтхэгийн Засгийн газраас зээл, дээрээс нь Энэтхэгийн Засгийн газар өөрсдөө Энэтхэг компани заавал гүйцэтгэх ёстой гэдэг гэрээ орж ирсэн юм байна лээ. Тэгэхээр энийг заавал ингэж бүх үе шатаар нь ингэж детальчилж байхын оронд бид зүгээр нэг томоохон гэрээ, түлхүүр хүлээлцэх Монгол Улс бол Засгийн газрын зүгээс захиалагч улс орон болоод, Энэтхэгийн Засгийн газар түлхүүр хүлээлгэх нөхцөлөөр энэ гэрээг ганцхан том гэрээ хийж болохгүй юу? Ингэх юм бол энэ цаг хугацаандаа амжих, энэ олон үе шат, энэ олон ажлууд товчлогдох боломж байна гэж ингэж харж байна. Хэрвээ энэ ажил ингээд удаашраад байх юм бол бид нарт хэд хэдэн аюулууд байгаа. 1 дүгээрт Тамсагийн нефтийн ордын нефть олборлолт маань багасаад эхэлсэн. 1 сая тонн түүхий нефть олборлодог байсан бол одоо 500 мянга болчихсон, буурчихсан байна. Энэ яг юунаас болж ингээд буурч байгаа юм бэ?

2 дугаарт нь дэлхий нийтээрээ энэ цахилгаан газ машины хэрэглээ рүү нэвтэрчихлээ. Энэ үед бид ингээд нефть үйлдвэрээ оруулах гээд байдаг энэ цаг хугацаа хоцрох вий.

3 дугаар энэ хугацаа сунаад ирэх тусам энэ Засгийн газарт хүүгийн дарамт орж ирэх гэж байна. Энэ хэдий дахиад хөрөнгө оруулалт нэмэгдэж магадгүй. Тэгэхээр энэ асуудлуудаа бодоод бид ерөөсөө захиалагчийн зүгээс ганцхан том л гэрээ түлхүүр хүлээж авах энэ нөхцөлөөр л хийх ийм хүсэлтийг хүргүүлж байна.

2 дугаарт нь энэ Евро стандартын үйлдвэр маш том өндөр стандарт. Энэ евро стандарт руу шилжсэн улс орнууд цөөхөн. ОХУ бараг 4, 5 жил зорьж байгаад энэ стандартад шилжиж байсан. Энэ стандартын үйлдвэрийг хүлээж авах энэ менежментийн ямар компани ажиллаж байгаа юм бэ? Энэ компанийг ер нь сайн танилцах, энэ компанийн үйл ажиллагаатай иргэдийн зүгээс нэмж оролцох ийм хүсэлтийг хүргүүлж байна. Ийм асуулт байна.

Х.Булгантуяа: Ажлын хэсгээс хариулах уу? Эхлээд Жавхлан сайд.

Б.Жавхлан: Пунсалмаа гишүүний асуултад хариулъя. Бид өнөөдөр гэрээгээ соёрхон батлах гэж байгаа. Өөрөөр хэлбэл гэрээнд өөрчлөлт орох шат, процессууд нь өнгөрчихсөн. Ер нь яах вэ том зургаараа энэ чинь аль 19 онд эхэлсэн гэрээ. Гэрээний нөхцөл, загвар, схемийн санхүүжилт энэ бүх юм нь 5 дахь жилдээ орчихсон буюу замынхаа дунд орчихсон явж байгаа. Энийг буцааж эвдээд, тендерээр шалгарсан компаниудыг гэрээнүүдээ бүгдийг нь хүчингүй болгоод, тэгээд буцаад дахиад эхнээс нь эхэлнэ гэдэг тийм боломж одоо байхгүй л дээ. Одоо байгаа энэ нөхцөлөөрөө бушуухан дуусгах нь л бидний хувьд аягүй том сорилт цаг хугацааны зүйл болж ирж байна гэсэн үг. Бусад тэр асуудлуудыг нь ажлын хэсгээс хариулчих уу?

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын, ажлын хэсгийн 21 номерын микрофон.

У.Чинзориг: Монгол газрын тос боловсруулах үйлдвэрийн Гэрээ, эрх зүйн газрын дарга Чинзориг. Гишүүний асуултад нэмж хариулъя. ЕРС гэрээг ганц гэрээ байгуулаад түлхүүр гардуулах нөхцөлтэй ганц гэрээ байгуулаад явчхаж болоогүй юм уу, яагаад нэг хуваасан юм бэ гэж асууж байх шиг байна. Тэгэхээр энэ хуваах асуудлыг анхнаасаа л төслийн философийг гаргаж байх цаг үеэс л 19 оноос л энэ дээр нэлээд судалж, ярьж хэлэлцсэний эцэст л ийм шийдвэр гаргасан л даа. Ер нь Энэтхэгийн талаас ч Эксим банк, Гадаад хэргийн яам ч хүртэл энэ дээр оролцож явсан. Эцэст нь төслийн философийг эцэслээд, нийт төслийн ажлын хүрээнд хийгдэх ажлын дэс дараалал, ажлын онцлог, шаардагдах тусгай зөвшөөрлүүд, тэгээд төвөгшил гэх мэт.../минут дуусав/

Х.Булгантуяа: 21 номерын микрофон нэмж хариулъя.

У.Чинзориг: Энэ бүх хүчин зүйлүүдийг харгалзан үзэж, ЕРС-г 4 ЕРС-д хуваагаад ингээд хэрэгжүүлнэ гэдэг ийм шийдвэрийг гаргаад л ингээд 19 оноос хойш л хэрэгжээд явж байгаа юм. Энэ хэмжээний мега төслүүдэд бол ЕРС-г жишээлбэл Энэтхэгт бол бүр 7 хуваасан ийм жишээ байгаа, практик байгаа. Бүр 15 ч гэж байгаа. ЕРС гэрээг, ЕРС гэдэг нь ер нь түлхүүр гардуулах нөхцөлтэй л гэрээ юм л даа. Тэгэхээр бүхэл үнийн дүнтэй, нийт үнэд суурилсан түлхүүр гардуулах нөхцөлтэй гэрээг л хэлээд байгаа юм.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Пунсалмаа тодруулга.

Б.Пунсалмаа: Миний ер нь хэлээд байгаа санаа бол гүйцэтгэгч компани мэдээж ажлуудаа төлөвлөнө, цаг хугацаагаар төлөвлөнө, тэрийг хэд ч салгаж болно. Тэр манай Засгийн газрын яг үүрэг мөн үү, яг манай Засгийн газар энэ хяналтад орох шаардлага байна уу? Одоо үлдсэн ажлаа нэг багц болгоод гэрээ дээрээ төдий хугацаанд хүлээж авна, ийм стандартын евро стандартын үйлдвэр хүлээж авна гээд үлдсэн гэрээгээ нэг багцлах боломж байна уу л гэж асуугаад байгаа юм.

Х.Булгантуяа: Ажлын хэсгээс 21 номерын микрофон.

У.Чинзориг: Үлдсэн энэ зээлийн нэмэлт зээлээс санхүүжих энэ гэрээний хувьд үндсэндээ энэ нэг л ЕРС-ийн асуудал яриад байна л даа. Энэ 700-аас ЕРС 4 санхүүжнэ, бүхэлдээ санхүүжнэ. Энэ бол дангаараа ганц ЕРС. Үүнээс гадна ЕРС 4-өөс гадна энэ нэмэлт зээлийн санхүүжилтээс энэ license-ийн зарим лиценз

эзэмшигчтэй байгуулсан тэд нарт, тэд нараас авах тоног төхөөрөмж, зөвлөх үйлчилгээний зарим гэрээнүүд энэ зээлийн хэлэлцээрээр санхүүжих ёстой. Дээрээс нь Энэтхэгийн талаас энэ contingency гээд магадалшгүй ажлын зардал гээд оруулсан. Тэгэхээр энэ 700-д магадалшгүй ажлын зардал ороод явж байгаа.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Чинбаатарын Анар.

Ч.Анар: Асуулт асуухгүй, үг хэлэхгүй, шаардлага тавья. 8 жил болж байгаа нефтийн үйлдвэр. Тэгээд энэ хариуцлагын тогтолцоо байхгүй, хариуцлага байхгүй. Тэгээд ингээд дахиад зээл авна гээд орж ирээд суудаг. Энэ төрийн бүтээн байгуулалтууд бүгд ийм. Шат шатын хариуцлагын асуудал байдаггүй. Тэгээд хариуцлагын тогтолцоо нь яадаг юм бэ гэхээр улс төрийн хариуцлага авдаг, ажлаасаа халагддаг. Хувийн хэвшилд ийм юм байхгүй шүү дээ. Өөрийн хөрөнгөөрөө Компанийн тухай хууль, Иргэний тухай хуулиараа хувийн хэвшилдээ зориулаад Дампуурлын тухай хууль ч байхгүй. Бүгдийг нь шоронд хийхээр хэмжээний зохицуулалттай. Тэгсэн мөртөө төр өөрөө юм хийхээрээ бүтдэггүй нэмээд аваад л байдаг. Энэ хариуцлагын тогтолцоо ерөөсөө байхгүй бүх төсөл шүү. Ганц энэ нефтийн үйлдвэр биш. Энийгээ хэзээ болих юм бэ? Энэ дээр шаардлага тавимаар байна. Энэ эрх зүйн асуудлаа зохицуулах хэрэгтэй байна бид.

2 дугаарт энэ зээлийн хэлэлцээрүүд энэ аягүй олон зээлийн хэлэлцээр орж ирж байна. Нөгөө Жавхлан сайд дахиад нөгөөхөө ярих нь гэж бодож байгаа байх. Зээлийн хэлэлцээрүүдийг энэ мэргэжлийн салбарын чиг үүрэгтэй яам, мэргэжлийн холбоод нь оруулж ирэхдээ хэлэлцээрийг бодит өртөгт нь ойртуулах хэлэлцээрийг хийгээч. Тэнд нь мэргэжлийн экспертүүд тавиагч. Тэгэхгүй тэгээд Toyo engineering-гээс ийм үнэ авсан, тэндээс ийм үнэ авсан гээд анхны үнийг нь аваад тэрийгээ Сангийн яамандаа өгчихдөг. Тэгээд нөгөө хөнгөлөлттэй зээл гэдэг нэрээр 2, 3 дахин өртөгтэй, нөгөө улсуудынх нь Эксим банкнууд нь аягүй сайхан сэтгэл ханамжтай, маш бага хүүтэй зээлийг шүүмжиллээ гээд байх юм. Бага хүүтэй биш шүү дээ өртөг өндөртэй. Тэгээд энийг нь эргээгээд төсвийн мөнгөөр буюу татвар төлөгчдийн мөнгөөр л төлөөд байгаа юм. Энийгээ процессынхоо энэ алдааг засах хэрэгтэй байна.

Тэр салбар салбарынх нь яамд, мэргэжлийн холбоодод нь тэр өчигдөр хасагдчихсан байгаа тэр Сонор мэргэжилтэн шиг хүмүүсийг нь 10, 20-оор нь тавиагч. Тэгэхгүй тэгээд ингээд Худалдан авах ажиллагааныхаа тухай хууль дээрээ хамгийн хямдханыг нь авна гээд чанаргүй юм авчхангуутаа тэрийгээ өөрчлөх гээд явж байгаа бид хэд. Гэтэл эргээгээд гаднаас зээл, тусламж авахаараа гадаадын зээл, тусламж хөнгөлөлттэй гээд аймар үнэтэйгээр нь авдгаа одоо больё. Ийм 2 шаардлагыг хэлье.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Анар үг хэллээ. Гадаадаас зээл, тусламжаар авч байгаа бараа, бүтээгдэхүүний үнэ, үйлчилгээ хэтэрхий өндөр байна шүү гээд. Үүнтэй холбоотойгоор Улсын Их Хурлын даргын захирамжаар ажлын хэсэг гарчихсан ажиллаж байгаа. Энэ улсын төсөв дээр үзүүлж байгаа нөлөөллүүдийг хууль тогтоомжуудын үнэлгээг хийх, ачааллыг нь тооцоолох, үнэлэх гэдэг дээр энэ зээл, тусламжтай холбоотойгоор дэд ажлын хэсэг гарч ажиллаж байгаа. Тэгээд Анар гишүүн тийшээ манай тэр ажлын хэсэгт ороод ажиллаарай. Төдийгөөс өдий болтол авсан зээл, тусламжууд, түүний төсөв дээр

үзүүлж байгаа ачаалал, цаг хугацаандаа дуусдаггүй, ахиад үргэлжлүүлээд ингээд зээл авч байгаа гэдэг энэ асуудлуудтай холбоотойгоор үнэлэлт, дүгнэлт өгөх ажлын хэсэг гарчихсан ажиллаж байгаа.

Өнөөдөр түрүүн Улсын Их Хурлын дарга хэлсэн. Хэлэлцэж байгаа асуудалтай холбоотойгоор Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, үг хэллээ. Хэд хэдэн гишүүдээс үүнтэй холбоотойгоор нэмэлт материалууд ажлын хэсгээс авах шаардлагатай байна, нэмж танилцах шаардлагатай байна, тэгж байж санал хураалтыг явуулах нь зүйтэй юм байна гэсэн энэ саналуудыг хүргүүлсэн. Түрүүн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороон дээр энэ чиглэлээр нэлээдгүй хэлэлцүүлэг өрнөх шиг боллоо. Тийм учраас санал хураалтыг ажлын хэсгийн гишүүд, түрүүн Мөнхбаясгалан гишүүн бас хэллээ. Ер нь манай ажлын хэсэг нэмж жоохон ажиллах хэрэгтэй, шаардлагатай байгаа юм байна. Нэмэлт цаас, мэдээллүүд шаардлагатай байна. Энэ дээрээ ажиллаж байж санал хураалтыг явуулъя гэж түрүүн Мөнхбаясгалан гишүүн хэлж байсан. Тэгэхээр санал хураалтыг угаасаа чуулган бол сунаж хуралдахаар болсон. Үүнтэй холбоотойгоор санал хураалтыг ирэх долоо хоногт явуулъя.

19.02 цаг

Одоо Даргын дэргэдэх зөвлөл хуралдаж, ирэх долоо хоногийн товыг тохирохоор байгаа. Өнөөдрийн чуулганы хуралдаан, ингээд өнөөдрийн чуулганы хуралдаан дууслаа.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА